

Тайлбар:


Шинэ-Зеландын дүрмийн өөрчлөлтөөр нэмж орсон / хассан

“ИНД-ийн нэр томъёоны тайлбар”-ын дагуу нэмж орсон / хассан

Найруулга зассан

Анхаар:

Та баруун дээд буланд байгаа navigation bar-ийн “Two page view”-г сонгож монгол, англи хувилбарыг зэрэгцүүлэн харж болно.



ИНД - 121

Том нисэх онгоцны арилжааны нислэгийн
үйл ажиллагаа

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-121 нь ИНД-119-ийн дагуу олгосон шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн дараах нисэх онгоц ашиглан гүйцэтгэж байгаа арилжааны нислэгийн үйл ажиллагаанд тавих үйл ажиллагааны шаардлагыг тогтооно:

- (1) шаардлагатай багийн гишүүний суудлаас гадна, 30-аас дээш зорчигчийн суудлын конфигурацитай; эсхүл
- (2) 3410 кг-аас их төлбөрт ачааллын багтаамжтай.

Энэ Дүрмийн зорилго нь дараах этгээд болон үйл ажиллагаанд хамааралтай дүрмийг хэрэгжүүлснээр дээрх категорийн нисэх онгоцоор үйл ажиллагаа эрхлэгчдэд зориулсан дүрмийн стандартыг тогтооход оршино:

- арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд;
- арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч;
- арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа хөлгийн дарга;
- агаарын хөлгийн нэмэлт төхөөрөмж, хэрэглэл болон гэрчилгээжүүлэлтийн шаардлага, тодорхойлолт;
- агаарын хөлгийн техник үйлчилгээ;
- багийн гишүүдийн сургалт болон ур чадвар;
- нисэх багийн ажил, амралтын цагийн зохицуулалт.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-121-ын цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-121, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх	Хүчинтэй огноо
Анхны боловсруулалт	2003 оны 06 сарын 05
Нэмэлт, өөрчлөлт 1	2003 оны 12 сарын 05
Нэмэлт, өөрчлөлт 2	2005 оны 09 сарын 14
Нэмэлт, өөрчлөлт 3	2006 оны 01 сарын 16
Нэмэлт, өөрчлөлт 4	2008 оны 02 сарын 29
Хоёрдугаар боловсруулалт	2010 оны 04 сарын 16
Нэмэлт, өөрчлөлт 1	2010 оны 10 сарын 05
Нэмэлт, өөрчлөлт 2	2010 оны 12 сарын 23
Нэмэлт, өөрчлөлт 3	2011 оны 04 сарын 22
Нэмэлт, өөрчлөлт 4	2013 оны 01 сарын 11
Гуравдугаар боловсруулалт	2021 оны 02 сарын 04
Нэмэлт, өөрчлөлт 3.1	2022 оны ... сарын ...

Тэмдэглэл: ИНД-121-ийн нэмэлт, өөрчлөлт 3.1-ийг монгол, англи хэл дээр, NZ Part 121-ийн **2020 оны 12 сарын 01-ний А.32**-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

А Бүлэг - Ерөнхий зүйл.....	1
121.1. Зорилго.....	1
121.3. Нэр томьёо болон товчлол.....	1
121.5. Хууль, дүрэм болон журам.....	1
121.7. Журмын хэрэгжүүлэлт	1
121.9. Багийн гишүүний давуу нөхцөл.....	1
121.11. Нөөц	1
121.13. Дүрмийн шаардлагаас чөлөөлөх	1
В Бүлэг - Нислэгийн үйл ажиллагаа	2
121.51. Зорилго.....	2
121.53. Нисэх онгоцны НТЧ	2
121.55. Нийтлэг хэл	2
121.57. Нисэх онгоцны бататгах нислэг	2
121.59. Нислэгийн бэлтгэл.....	3
121.61. Нислэгийн үйл ажиллагааны төлөвлөгөө	4
121.63. Эрэн хайх, авран туслах мэдээлэл.....	4
121.65. Ослын болон аврах төхөөрөмжийн мэдээлэл.....	4
121.67. Усан дээр ослын буулт үйлдэх гэрчилгээжүүлэлт	5
121.69. VFR нислэгийн минимум өндөр	5
121.71. Аэродром ашиглах.....	5
121.73. Шөнийн нислэгийн үйл ажиллагаа.....	7
121.75. Түлш	7
121.77. Нислэгийн шалгалт хийх тогтолцоо.....	8
121.79. Онцгой нөхцөлийн гэрлэн дохио (emergency light).....	8
121.81. Зорчигчдын аюулгүй байдал	9
121.83. Зорчигчдод зориулсан мэдээлэл	9
121.85. Нисэх багийн бүхээгт орох зөвшөөрөл	9
121.87. Нисэх онгоцны удирдлагад оролцох.....	10
121.89. Нислэгийн бичлэгийн төхөөрөмжид тавих шаардлага	10
121.91. Түлшээр сумлах болон түлш юүлэх үйл ажиллагаа	11
121.93. Нөөц	11
121.95. Онцгой нөхцөлийн үеийн арга хэмжээний төлөвлөгөө	11
121.97. Үйл ажиллагааг хязгаарлах, эсхүл түдгэлзүүлэх	12
121.99. Нисэх багийн бүхээгийн хаалгыг түгжих.....	12
121.101. Нисэх багийн бүхээгийн хаалганы гадна орчныг хянах	12
121.103. Нисэх багийн гишүүдтэй харилцах нууц дохио	13
С Бүлэг - Үйл ажиллагааны хязгаарлалт болон цаг агаарын шаардлага	13
121.151. Зорилго.....	13
121.153. Цаг уурын мэдээ	13
121.155. VFR нислэгийн цаг уурын нөхцөл	13
121.157. IFR нислэгийн цаг уурын нөхцөл.....	14
121.159. IFR нислэгийн аэродромын үйл ажиллагааны минима	15
121.159A. Аэродром бүрд ашиглах аэродромын үйл ажиллагааны минима	15

121.161.	IFR-аар нисэн гарах хязгаарлалт	15
121.163.	Хөөрөлтийн багасгасан минима.....	16
121.165.	Нислэгийн замын зайн хязгаарлалт	16
121.167.	Нөөц	17
121.169.	IFR-ийн журам.....	17
121.171.	Туйлын бүсийн арилжааны нислэгийн үйл ажиллагааны шаардлага	17
121.173.	Туйлын бүсэд арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт	17
121.175.	Туйлын бүсийн арилжааны нислэгийн үйл ажиллагааны зөвшөөрөл.....	18
D	Бүлэг - Нислэгийн үзүүлэлт	18
121.201.	Зорилго.....	18
121.203.	Нөөц	18
121.205.	Нисэх онгоцны ерөнхий үзүүлэлт	19
121.207.	Хөөрөлтийн зай.....	19
121.209.	ХБЗ-ны гадаргууг засаж тооцох хүчин зүйл.....	20
121.211.	Хөөрөлтийн үеийн нислэгийн аюулгүй зам	20
121.213.	Хөдөлгүүр ажиллагаагүй үеийн градиент болон хурдны нурултыг засаж тооцох	22
121.215.	Нислэгийн замд эрсдэлтэй хөдөлгүүр ажиллагаагүй болох.....	22
121.217.	Нислэгийн зам дагуух 90 минутын хязгаарлалт.....	23
121.219.	Нисэн очих болон бэлтгэл аэродромд буултын үед өндөр авах	24
121.221.	ХБЗ-ны буултын зай	25
121.223.	[Хүчингүй болсон].....	25
121.225.	Огцом ойртолт болон богино зайд буулт үйлдэх арга техник	25
E	Бүлэг - Жин ба төвлөрөлт.....	26
121.301.	Зорилго.....	26
121.303.	Бараа, зорчигч болон тээшний жин	26
121.305.	Нисэх онгоцны ачааллын хязгаарлалт	27
121.307.	Ачааллын манифест.....	27
F	Бүлэг - Хэрэглэл болон төхөөрөмж.....	28
121.351.	Зорилго.....	28
121.353.	Ерөнхий зүйл.....	28
121.355.	Нэмэлт хэрэглэл	29
121.357.	Нэмэлт төхөөрөмж.....	30
121.359.	Шөнийн нислэг	30
121.361.	Хэрэглэлийн нислэгийн дүрэм (IFR)	30
121.363.	Усан дээгүүрх нислэг	31
121.365.	Ослын төхөөрөмж.....	31
121.367.	Амьсгал хамгаалах төхөөрөмж (PBE).....	31
121.369.	Зарлан мэдээлэх болон багийн гишүүдийн дотоод холбооны систем	32
121.371.	Бүхээгийн дуу чимээ бичигч (CVR)	32
121.373.	Нислэгийн өгөгдөл бичигч (FDR)	32
121.375.	Нэмэлт байрлал заах хэрэгсэл (Additional attitude indicator)	32
121.377.	Цаг агаарын радар.....	33
121.379.	Газар ойртсоныг анхааруулах систем (GPWS).....	33

121.381. Газар мэдрэх ба анхааруулах систем (TAWS).....	33
121.383. Агаарт мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх систем (ACAS II)	34
G Бүлэг - Техник үйлчилгээ	34
121.401. Зорилго.....	34
121.403. НТЧ-ын хариуцлага	34
121.405. Нөхцөлөөр хянах техник үйлчилгээний хөтөлбөр.....	35
121.407. EDTO нислэгийн техник үйлчилгээний элемент	35
121.409. Нөөц	37
121.411. Нөөц	37
121.413. Нөөц	37
121.415. Техник үйлчилгээний дүгнэлт.....	37
121.417. EDTO нислэгийн улирлын тайлан.....	38
H Бүлэг - Багийн гишүүдэд тавих шаардлага.....	39
121.501. Зорилго.....	39
121.503. Багийн гишүүдийг томилох.....	39
121.505. Нисэх багийн гишүүдийг ажил үүрэгт томилох.....	40
121.507. Хөлгийн даргын туршлагад тавих шаардлага	40
121.509. Хамтран нисгэгчийн туршлагад тавих шаардлага	41
121.511. Аяллын орлон нисгэгчийн туршлагад тавих шаардлага.....	41
121.513. Нисэх-инженерийн туршлагад тавих шаардлага	42
121.515. Бүхээгийн ажилтны туршлагад тавих шаардлага	42
121.517. Шугамын хяналтын нисгэгчийн туршлагад тавих шаардлага.....	42
121.519. Сургагч-нисгэгчийн туршлагад тавих шаардлага.....	43
121.521. Шалгагч-нисгэгчийн туршлагад тавих шаардлага.....	43
121.523. Симуляторын багш болон шалгагч-нисгэгчийн туршлагад тавих шаардлага 44	
121.525. Сургагч-бүхээгийн ажилтны туршлагад тавих шаардлага.....	45
121.527. Бүхээгийн ажилтанд үнэлгээ хийх этгээдийн туршлагад тавих шаардлага	45
121.529. Онолын багшийн туршлагад тавих шаардлага	45
121.531. Нисэх баг бүрдүүлэхэд тавих хязгаарлалт.....	45
121.533. Нисгэгчийн үйл ажиллагааны хязгаарлалт.....	46
121.535. Хэд хэдэн нисэх онгоцны маяг, эсхүл вариантаар үйл ажиллагаа гүйцэтгэх нисэх баг 47	
121.537. CAT II, эсхүл CAT III нарийвчлалтай ойртолт ын журмаар болон хөөрөлтийн багасгасан минима-гаар нислэг үйлдэх нисэх баг	48
121.539. Бүхээгийн ажилтныг ажил үүрэгт томилох	49
I Бүлэг - Сургалт	50
121.551. Зорилго.....	50
121.553. Багийн гишүүний сургалтын хөтөлбөр.....	50
121.555. Багийн гишүүний сургалтын хөтөлбөрийн сэдэв.....	51
121.557. Багийн гишүүний танилцах сургалт	52
121.559. Багийн гишүүний шилжих сургалт.....	53
121.561. Багийн гишүүний шат ахих сургалт.....	53
121.563. Багийн гишүүний давтан сургалт	54

121.565.	Нисэх багийн сургалтын төхөөрөмж	54
121.567.	Нисгэгчийн шугамын нислэгийн сургалт.....	55
121.569.	Нисгэгчийн зөөлтийн нислэг.....	57
121.571.	Нисэх-инженерийн зөөлтийн нислэг	58
121.573.	Бүхээгийн ажилтны сургалтын хөтөлбөр.....	59
121.575.	Бүхээгийн ажилтны үйл ажиллагааны туршлага.....	59
121.577.	Багийн гишүүдийн сургалтын бүртгэл	60
Ж	Бүлэг - Багийн гишүүдийн ур чадварт тавих шаардлага.....	60
121.601.	Зорилго.....	60
121.603.	Ерөнхий зүйл.....	60
121.605.	Ур чадварын үнэлгээний хөтөлбөрийн үүрэг хариуцлага.....	61
121.607.	Нисэх багийн гишүүдийн ур чадварын үнэлгээ	62
121.609.	Сургагч-нисгэгч, шугамын хяналтын нисгэгч, симуляторын багш болон шалгагч-нисгэгчийн ур чадварын үнэлгээ	63
121.611.	Бүхээгийн ажилтны ур чадварын үнэлгээ.....	64
121.613.	Ур чадварын болон шалгалтын бүртгэл.....	64
К	Бүлэг - Багийн гишүүдийн ажил, амралтын цагийн зохицуулалт	65
121.801.	Зорилго.....	65
121.803.	Үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэг хариуцлага.....	65
121.805.	Нисэх багийн гишүүний үүрэг хариуцлага	66
121.807.	Бүхээгийн ажилтны ажил, амралтын цагийн зохицуулалт	66
Л	Бүлэг - Заавар, бүртгэлийн дэвтэр болон бүртгэл	67
121.851.	Зорилго.....	67
121.853.	Үйл ажиллагааны мэдээлэл	67
121.855.	Бүхээгт авч явах баримт бичиг	67
121.857.	Үйл ажиллагааны бүртгэл	68
121.859.	Хадгалагчтын ж хугацаа.....	68
М	Бүлэг - Мэргэшил дээшлүүлэх хөтөлбөр.....	68
121.901.	Зорилго.....	68
121.903.	Ерөнхий зүйл.....	68
121.905.	Хөтөлбөрт өөрчлөлт оруулах.....	69
121.907.	Хөтөлбөрийн сэдэв.....	69
121.909.	Шаардлагатай сэдвийн агуулга	70
121.911.	Үзэл баримтлалын сургалтын сэдэв.....	70
121.913.	Мэргэшүүлэх сургалтын сэдэв	71
121.915.	Мэргэшил хадгалах сургалтын сэдэв	72
121.917.	Багийн нөөцийн удирдлагын шаардлага (CRM).....	75
121.919.	Өгөгдөл цуглуулах шаардлага	75
121.921.	Гэрчилгээжүүлэлт	75
121.923.	Гэрээгээр сургалт хийх этгээдэд зөвшөөрөл олгох	76
Н	Бүлэг - EDTO нислэгийн эрх болон шаардлага	76
121.951.	Ерөнхий зүйл.....	76
121.953.	Хоёр-хөдөлгүүртэй нисэх онгоцны 180 минутын даялах максимум хугацаатай EDTO нислэгийн шаардлага.....	77

121.955. Хоёр-хөдөлгүүртэй нисэх онгоцны 180 минутын даялах максимум хугацаатай EDTO нислэгийн зөвшөөрөл.....	78
121.957. Хоёр-хөдөлгүүртэй нисэх онгоцны 240 минутын даялах максимум хугацаатай EDTO нислэгийн шаардлага.....	79
121.959. Хоёр-хөдөлгүүртэй нисэх онгоцны 240 минутын даялах максимум хугацаатай EDTO нислэгийн зөвшөөрөл.....	79
121.961. Хоёр-хөдөлгүүртэй нисэх онгоцны 240 минутын даялах максимум хугацаатай EDTO нислэгийн шаардлага.....	79
121.963. Хоёр-хөдөлгүүртэй нисэх онгоцны 240 минутын даялах максимум хугацаатай EDTO нислэгийн зөвшөөрөл.....	80
121.965. 2-оос олон хөдөлгүүртэй нисэх онгоцны EDTO нислэгийн шаардлага.....	80
121.967. 2-оос олон хөдөлгүүртэй нисэх онгоцны EDTO нислэгийн зөвшөөрөл.....	81
121.969. EDTO нислэгт гаргах шаардлага - ерөнхий зүйл.....	81
121.971. EDTO нислэгт гаргах - 180 минутын даялах максимум хугацаатай EDTO нислэгийн нэмэлт шаардлага.....	82
121.973. Нислэгийн замын дагуух EDTO нислэг.....	83
121.975. EDTO нислэгийн түлшний шаардлага.....	84
121.977. Нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродромын төлөвлөлтийн минима.....	86
121.979. Нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродромын төлөвлөлтийн бага минима.....	87
121.981. Мөрдөж байгаа ETOPS нислэгийн шилжилт.....	87
Хавсралт А - Нөөц.....	87
Хавсралт В - Хэрэглэл болон төхөөрөмжийн НТЧ-ын загварын стандарт.....	88
В.1. Амьсгал хамгаалах төхөөрөмж (PBE).....	88
В.2. Эмнэлгийн түргэн тусламжийн иж бүрдэл (Emergency medical kit).....	88
В.3. Зарлан мэдээлэх систем.....	89
В.4. Багийн гишүүдийн дотоод холбооны систем.....	89
В.5. Бүхээгийн дуу чимээ бичигч (CVR).....	90
В.6. Нислэгийн өгөгдөл бичигч (FDR).....	90
В.7. Нэмэлт байрлал заах хэрэглэл (Additional attitude indicator).....	90
В.8. Цаг агаарын радар (Weather radar).....	91
В.9. Газар ойртсоныг анхааруулах систем (GPWS).....	91
В.10. Газар мэдрэх ба анхааруулах систем (TAWS).....	91
В.11. Агаарт мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх систем (ACAS II).....	92
Хавсралт С - Хөөрч, буух зурвас.....	93
С.1. ХБЗ-ны минимум өргөн.....	93
Хавсралт D - ХБЗ-ны буултын зайн үнэлгээ.....	95
D.1. Хуурай ХБЗ-ны зөвшөөрөгдсөн буултын зайн үнэлгээ.....	95
D.2. Нойтон, эсхүл тунадастай ХБЗ-ны зөвшөөрөгдсөн буултын зайн үнэлгээ.....	95
D.3. TALPA журам.....	96

А Бүлэг - Ерөнхий зүйл

121.1. Зорилго

Энэ Дүрэм нь шаардлагатай багийн гишүүний суудлаас гадна, 30-аас дээш зорчигчийн суудлын конфигурацитай, эсхүл төлбөрт ачааллын багтаамж нь 3410 кг-аас их нисэх онгоцоор гүйцэтгэх агаарын тээврийн үйл ажиллагаа болон тусгай зориулалтын нисэхийн үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг тогтооно.

121.3. Нэр томьёо болон товчлол

Энэ Дүрэмтэй холбоотой нэр томьёо болон товчлол нь ИНД-ийн нэр томьёоны тайлбарт багтсан.

121.5. Хууль, дүрэм болон журам

ИНД-119-ийн дагуу олгосон шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ (цаашид “АТ-ийн гэрчилгээ” гэх) эзэмшигч нь гэрчилгээ эзэмшигчийн бүх үндсэн ажилтан, эсхүл гэрээт ажилтнууд иргэний нисэхийн хууль, иргэний нисэхийн дүрэм болон гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт заасан журамтай танилцсан болохыг бататгана.

121.7. Журмын хэрэгжүүлэлт

Арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт заасан холбогдох журам нь тухайн гэрчилгээгээр зөвшөөрсөн үйл ажиллагаатай тохирч байгааг бататгана.

121.9. Багийн гишүүний давуу нөхцөл

Хэрэв багийн гишүүн I, J, эсхүл M Бүлгийн дагуу шаардсан тест, нислэгийн шалгалт, эсхүл үнэлгээг шаардлагатай хугацаанаас нь өмнө 60 хоногийн дотор тухайн тест, нислэгийн шалгалт өгсөн, эсхүл үнэлгээ хийлгэсэн бол, багийн гишүүнийг тухайн тест, нислэгийн шалгалт, эсхүл үнэлгээг шаардсан хугацаанд нь хийлгэсэнд тооцно.

121.11. Нөөц

121.13. Дүрмийн шаардлагаас чөлөөлөх

(а) Хэрэв тухайн дүрмийн шаардлагаас чөлөөлөх нь тухайн нисэх онгоцыг дараах системээр тоноглогсон байх ёстой өдрөөс хойш нэг жилээс урт хугацаагаар үргэлжлэх бол Дарга 121.381, эсхүл 121.383-ын шаардлагаас чөлөөлөхгүй байж болно.

- (1) 121.381-д заасан хамаарах TAWS;
- (2) 121.383-т заасан ACAS II.

(б) Энэ зүйлийн (а)-г үл харгалзан, Дарга дараах дүрмийн шаардлагаас чөлөөлөхгүй байж болно:

- (1) 40, эсхүл түүнээс цөөн зорчигчийн суудлын конфигурацитай нисэх онгоцны хувьд, 121.381(b), эсхүл 121.383(b)(1)-ийн дагуух шаардлага, хэрэв тухайн нисэх онгоцны хувьд, 47.55(b)-д заасан дэлгэрэнгүй мэдээлэл нь 2003 оны 8 сарын 1-нд Монгол Улсын агаарын хөлгийн бүртгэлд орсон бол; эсхүл
- (2) 121.381(c), эсхүл 121.383(b)(2)-т заасан шаардлагын нөхцөл.

В Бүлэг - Нислэгийн үйл ажиллагаа

121.51. Зорилго

Энэ Бүлэг нь арилжааны нислэгийн үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг тогтооно.

121.53. Нисэх онгоцны НТЧ

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоц хүчинтэй стандарт категорийн НТЧ-ын гэрчилгээтэй болохыг бататгах үүрэгтэй.

121.55. Нийтлэг хэл

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгах үүрэгтэй:

- (1) багийн бүх гишүүн нь нийтлэг нэг хэлээр харилцан ойлголцох чадвартай байх ба нисэх багийн гишүүд нь тухайн нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай хэлээр харилцан ойлголцох чадвартай байх;
- (2) нислэгийн үйл ажиллагааны бүх ажилтан нь гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааврын тэдэнд хамааралтай хэсэг болон нислэгийн заавар бичигдсэн хэлээр уншиж, ойлгох чадвартай байх.

121.57. Нисэх онгоцны бататгах нислэг

(a) Шинэ маягийн нисэх онгоцыг үйл ажиллагаандаа ашиглахаар төлөвлөж байгаа АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн маягийн нисэх онгоцыг арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж эхлэхийн өмнө, Даргын хүлээн зөвшөөрөхүйц бататгах нислэгийг өмнө нь Гэрчилгээжүүлэгч Улсын шаардлагын дагуу хийгээгүй бол, тухайн нисэх онгоцны гэрчилгээжүүлэлтийн тестээс гадна, бататгах нислэгийн хөтөлбөрийг нэмж гүйцэтгэсэн болохыг бататгана.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан хөтөлбөр нь нислэгийн замын дагуух аэродром руу ниссэн хангалттай тооны нислэг болон 10-аас доошгүй цагийн шөнийн нислэгийг багтаасан 100-гаас доошгүй цагийн бататгах нислэгээс бүрдэнэ.

(c) Сүүлчийн бататгах нислэгээс хойш загвар нь бодитоор өөрчлөгдсөн нисэх онгоцны маягийг үйл ажиллагаандаа ашиглахаар төлөвлөж байгаа АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн маягийн нисэх онгоцыг арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглахын өмнө бататгах нислэгийн 50-иас доошгүй цагийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн болохыг бататгана.

(d) Энэ зүйлийн (c)-гийн зорилгоор, хэрэв дараах өөрчлөлт хийгдсэн бол, нисэх онгоцны маягийг загвар нь бодитоор өөрчлөгдсөн гэж үзнэ:

- (1) анхан шатны гэрчилгээжүүлэлтэд суурилуулснаас өөр маягийн хүчний төхөөрөмж суурилуулсан; эсхүл
- (2) нислэгийн үзүүлэлтэд бодитоор нөлөөлөх, тухайн нисэх онгоц, эсхүл түүний бүрдэл хэсэгт хийсэн өөрчлөлт.

(e) Нисэх онгоцны бататгах нислэг гүйцэтгэж байгаа АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь шаардлагатай багийн гишүүд болон дараах үйл ажиллагаанд оролцох ажилтнаас бусад этгээдийг тухайн нислэгт тээвэрлэхгүй байх үүрэгтэй:

- (1) сургалт, дадлагад хамрагдаж байгаа; эсхүл
- (2) шугамын-үйл ажиллагааны нислэгийн цаг цуглуулж байгаа; эсхүл
- (3) Даргыг төлөөлөх эрхтэй.

(f) Дарга зөвшөөрсөн бол, энэ зүйлийн (a)-г үл харгалзан АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь бататгах нислэгт ачаа, эсхүл шуудан тээвэрлэж болно. *FAA 121.163(e)*

121.59. Нислэгийн бэлтгэл

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд гүйцэтгэж байгаа арилжааны нислэгийн үйл ажиллагааны хувьд, төлөвлөсөн үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай бүх мэдээлэл хөлгийн даргад бэлэн байдаг болохыг бататгах үүрэгтэй.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд гүйцэтгэх арилжааны нислэгийн үйл ажиллагааны өмнө тухайн нислэгийн төлөвлөгөөг бэлтгэж байгаа үйл ажиллагааны төрөлд тохирсон ИНД-91.307(c), эсхүл 91.407-гийн шаардлага хангасан ба хэрэв хөлгийн дарга тухайн нислэгийн төлөвлөгөөг биечлэн бэлдээгүй бол төлөвлөсөн үйл ажиллагааны өмнө хөлгийн даргад нислэгийн төлөвлөгөөний агуулгыг танилцуулдаг болохыг бататгах үүрэгтэй.

(c) Тухайн нислэгийн гүйцэтгэлээс шалтгаалан буулт үйлдэхээр төлөвлөсөн дараагийн аэродромын SARTIME-ийг өөрчилдөг бол, ИНД-91.307(c)-д шаардсан, энэ зүйлийн (b)-гийн дагуу бэлтгэдэг VFR нислэгийн төлөвлөгөө нь хэд хэдэн нислэгийн замын сегментээс бүрдэж болно.

(d) Нислэгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг нислэгийн үйл ажиллагааны ажилтнууд бэлтгэдэг бол, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн ажилтныг дараах шаардлага хангасан болохыг бататгах үүрэгтэй:

- (1) сургалтад хамрагдсан бөгөөд тухайн ажлыг гүйцэтгэх чадвартай байх;
- (2) төхөөрөмж болон үйл ажиллагааны журам, эсхүл байгууламжийн өөрчлөлтийн мэдээллийг цаг алдалгүй авсан байх.

(e) Энэ зүйлийн (d)(2)-т заасан мэдэгдэх ёстой өөрчлөлт нь бодит аюултай цаг уурын нөхцөл, газрын болон навигацийн байгууламжийн хэвийн бус ажиллагааг багтаасан нислэгт нөлөөлөх мэдэгдэж байгаа аюул болон навигацийн туслах төхөөрөмж, аэродром, НХУ-ын журам болон дүрэм, орон нутгийн аэродромын хөдөлгөөний журмын ашиглалтын өөрчлөлтийг багтаана.

(f) ИНД-91.307(а)-г үл харгалзан, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (b)-д шаардсан нислэгийн төлөвлөгөөг арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхийн өмнө холбогдох НХҮ-ний нэгжид хүргүүлсэн болохыг бататгах үүрэгтэй.

(g) ИНД-91.307(а) болон ИНД-91.407(а)(1)-ийг үл харгалзан, энэ зүйлийн (f)-ийн дагуу НХҮ-ний нэгжид хүргүүлэх шаардлагатай нислэгийн төлөвлөгөөг АТ-ийн гэрчилгээ эзэмшигч хүргүүлж болох ба хөлгийн дарга тухайн нислэгийн төлөвлөгөөний агуулгыг мэддэг байх үүрэгтэй.

121.61. Нислэгийн үйл ажиллагааны төлөвлөгөө

(a) Нислэгийн хуваарийн суурь болох нислэгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг тогтооходоо, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгана:

- (1) тухайн нисэх онгоцны маягийн гэрчилгээнд агуулагдсан үзүүлэлттэй нийцсэн, үйлдвэрлэгчийн зааварт байгаа, эсхүл түүнээс гаргаж авсан тухайн нисэх онгоцонд зориулсан өгөгдлийг ашиглан нисэх онгоцны нислэгийн циклийг тооцоолсон байх;
- (2) нислэгийн замын дагуух зонхилох салхийг тооцсон байх;
- (3) завсрын буудалд нисэх онгоцонд шаардлагатай үйлчилгээ хийх хангалттай хугацаатай байх.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь 365 хоногийн хугацаанд гүйцэтгэсэн арилжааны нислэгийн үйл ажиллагааны 80-аас доошгүй хувь нь тухайн хуваарийг хэрэгжүүлэхэд ашигласан нислэгийн үйл ажиллагааны төлөвлөгөөний үзүүлэлтийн дотор төлөвлөсөн нисэн очих цэгт хүрдэг болохыг бататгана.

121.63. Эрэн хайх, авран туслах мэдээлэл

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь, тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа нисэх онгоцонд, тухайн нисэх онгоц дээгүүр нь нисэх газар нутгийн ЭХАТ үйлчилгээтэй холбоотой мэдээлэл бүхээгт бэлэн байгааг бататгах үүрэгтэй.

121.65. Ослын болон аврах төхөөрөмжийн мэдээлэл

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь, онцгой нөхцөлийн үед **авран туслах албатай ЭХАТ мэдээлэл зохицуулалтын төвтэй** шуурхай холбоо барих зорилгоор нисэх онгоцондоо тээвэрлэж байгаа ослын болон аврах төхөөрөмжийн мэдээллийг бэлэн байлгана.

(b) Усан дээгүүрх үргэлжилсэн нислэгийн үйл ажиллагаанд, энэ зүйлийн (a)-д шаардсан мэдээлэл нь дараах мэдээллийг багтаасан байна:

- (1) аврах завины тоо, өнгө болон төрөл;
- (2) пиротехникийн эд зүйл агуулсан эсэх;
- (3) эмнэлгийн яаралтай тусламжийн болон цэвэр усны хангамжийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- (4) ослын зөөврийн радио төхөөрөмжийн төрөл ба ажиллах давтамж.

121.67. Усан дээр ослын буулт үйлдэх гэрчилгээжүүлэлт

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь усан дээгүүрх үргэлжилсэн нислэгийн үйл ажиллагаанд ашигладаг нисэх онгоцыг усан дээр ослын буулт үйлдэхээр гэрчилгээжсэн болохыг бататгах үүрэгтэй.

121.69. VFR нислэгийн минимум өндөр

ИНД-91.311(с) нь энэ Дүрмийн дагуу арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа хөлгийн даргад хамаарахгүй.

121.71. Аэродром ашиглах

(а) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлага хангаагүй аэродромыг тухайн эзэмшигчийн гэрчилгээний эрхийн хүрээнд арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны хөөрөлт, эсхүл буулт үйлдэхэд ашигладаггүй болохыг бататгах үүрэгтэй:

- (1) тухайн аэродромын бодит үзүүлэлт, саадыг хязгаарлах гадаргуу болон ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ нь дараах шаардлагыг хангасан байх:
 - (i) ашиглаж байгаа нисэх онгоцны үзүүлэлтэд тохирсон байх;
 - (ii) ашиглах цаг уурын минимал дийцсэн байх;
- (2) хэрэв тухайн үйл ажиллагаа нь ~~2007 оны 7 сарын 12-ноос хойш~~ Монгол Улсаас, эсхүл Монгол Улс руу болон Монгол Улсын гадна гүйцэтгэж байгаа тогтмол агаарын тээврийн үйлчилгээ бол:
 - (i) үйл ажиллагаандаа ашигладаг, Монгол Улс доторх аэродромын ХБЗ нь ИНД-139 Хавсралт А.1-ийн шаардлагын дагуу тухайн ХБЗ-ны төгсгөлд RESA-тай байх; эсхүл
 - (ii) хэрэв тухайн ХБЗ нь энэ зүйлийн (а)(2)(i)-д шаардсан RESA-гүй бол, гэрчилгээ эзэмшигч нь 2011 оны 12 сарын 12-ноос хойш гүйцэтгэх үйл ажиллагаандаа нисэх онгоцны хөөрөлт болон буултын үзүүлэлтийг тооцохдоо тухайн ХБЗ-ны хувьд 90 м-тэй дүйцэх RESA-г ХБЗ-ны талбайн даван гүйж гарах төгсгөлд байхаар зарлагдсан зайг багасгаж тооцдог болохыг бататгах үүрэгтэй;
 - (iii) үйл ажиллагаандаа ашигладаг, Монгол Улсын гаднах аэродромын ХБЗ нь ХБЗ-ны даван гүйж гарах төгсгөлийг 150 м-ээс доошгүй уртасгасан RESA-тай байх, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц, дүйцэх инженерингийн үндэслэлтэй бүтээгдсэн байх; эсхүл
 - (iv) хэрэв ХБЗ нь RESA-гүй, эсхүл энэ зүйлийн (а)(2)(iii)-т шаардсантай дүйцэхээр бүтээгдээгүй бол, гэрчилгээ эзэмшигч нь тухайн нисэх онгоцны хөөрөлт болон буултын үзүүлэлтийг тооцохдоо тухайн ХБЗ-ны хувьд энэ зүйлийн (а)(2)(iii)-т шаардсантай дүйцэх RESA-тай ХБЗ-ны даван гүйж гарах төгсгөлд байхаар зарлагдсан зайг багасгаж тооцдог болохыг бататгах үүрэгтэй.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлага хангаагүй аэродромыг тухайн эзэмшигчийн гэрчилгээний эрхийн хүрээнд арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны хөөрөлт, эсхүл буулт үйлдэхэд ашигладаггүй болохыг бататгах үүрэгтэй:

- (1) тухайн нисэх онгоцны маягт тохирох, Даргын хүлээн зөвшөөрөхүйц гал унтраах хэрэгсэлтэй байх;
 - (2) тухайн нисэх онгоц глиссадын чиглүүлэгчийг багтаасан нарийвчлалтай хэрэглэлийн ойртолтын журмыг ашиглаж байхаас бусад тохиолдолд, турбо-жэт болон турбо-фэн хөдөлгүүртэй нисэх онгоцны хувьд, ажиллагаатай VASIS-тэй байх.
- (c) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн аэродромыг Ерөнхий заавартаа тусгайлан, эсхүл бүлэглэн зааснаас бусад аэродромыг тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны хөөрөлт, эсхүл буулт үйлдэхэд ашигладаггүй болохыг бататгах үүрэгтэй.
- (d) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (c)-гийн дагуу Ерөнхий зааварт заасан аэродром, эсхүл бүлэг аэродромд дараах шаардлагыг тогтоосон болохыг бататгах үүрэгтэй:
- (1) нислэгийн зам, эсхүл нислэгийн замын сегмент;
 - (2) нисэх багийн сургалтын шаардлагатай түвшин;
 - (3) нисэх багийн минимум туршлага;
 - (4) нисэх баг бүрдүүлэхэд тавих хязгаарлалт;
 - (5) зөвшөөрөгдсөн нислэгийн үйл ажиллагааны төрөл.
- (e) Энэ зүйлийн (f)(1)-ийг үл харгалзан, энэ зүйлийн (c)-д заасан, орон нутгийн арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа, 30-аас дээш гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай нисэх онгоц ашиглах бэлтгэл аэродром нь гэрчилгээжээгүй аэродром байж болно.
- (f) Энэ зүйлийн (c)-гийн дагуу гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт заасан, тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээнд ашиглаж байгаа, 30-аас дээш гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай нисэх онгоц ашиглах аэродром нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:
- (1) Монгол Улсын аэродромын хувьд, ИНД-139-ийн дагуу олгосон аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээтэй байх; эсхүл
 - (2) Монгол Улсын гаднах аэродромын хувьд, ИНД-139-д шаардсантай дүйцэх стандартыг хангасан, ICAO-гийн Хэлэлцэн тохирогч Улсаас олгосон гэрчилгээтэй байх.
- (g) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (e), (f)-ийн дагуу ашиглах аэродромын нислэгийн замын гарын авлагын хэсэг болох дараах мэдээллийг агуулсан бүртгэлийг байнга хөтлөх үүрэгтэй:
- (1) тухайн аэродромын өгөгдөл;
 - (2) аэродромын нөхцөл нь үйл ажиллагаанд аюулгүй болохыг бататгах журам;
 - (3) аврах төхөөрөмжийг багтаасан шаардлагатай төхөөрөмжийн нөхцөл нь тухайн үйл ажиллагаанд аюулгүй болохыг бататгах журам;
 - (4) тухайн аэродромыг ашиглах хязгаарлалтын дэлгэрэнгүй мэдээлэл.
- (h) Энэ зүйлийн (i)-д зааснаас бусад тохиолдолд, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлага хангаагүй ХБЗ-ыг, тухайн эзэмшигчийн гэрчилгээний эрхийн

хүрээнд арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны хөөрөлт, эсхүл буулт үйлдэхэд ашигладаггүй болохыг бататгах үүрэгтэй:

- (1) ашиглах ХБЗ-ны өргөн нь тухайн нисэх онгоцны хувьд, Хавсралт С-гийн дагуу тогтоосон өргөнөөс багагүй байх;
- (2) ашиглах ХБЗ-ны талбайн (runway strip) өргөн нь тухайн нисэх онгоц болон ХБЗ-ны хувьд, ИНД-139 Хавсралт С-гийн Хүснэгт С-1-ийн дагуу тогтоосон өргөнөөс багагүй байх.

(i) Хэрэв минимум өргөнөөс бага өргөнтэй ХБЗ-ыг ашиглаж болохыг гэрчилгээжсэн шалгах нислэгээр тогтоосон ба тухайн нисэх онгоцны нислэгийн зааварт заасан бол, тухайн эзэмшигчийн гэрчилгээний эрхийн хүрээнд арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоц нь энэ зүйлийн (h)-д шаардсанаас бага өргөнтэй ХБЗ-ыг ашиглаж болно.

121.73. Шөнийн нислэгийн үйл ажиллагаа

Аливаа этгээд нь шөнийн цагт VFR-ийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэхгүй.

121.75. Түлш

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн төлөвлөлт болон нислэгийн замын дагуух дахин төлөвлөлт хийх зорилгоор тухайн төлөвлөсөн нислэгийн хазайлтыг нөхөх нөөцийг багтаасан, төлөвлөсөн үйл ажиллагаандаа хангалттай түлшийг тухайн нисэх онгоц тээвэрлэж байгааг бататгах түлшний бодлогыг хэрэгжүүлсэн байна.

(b) Түлшний бодлого нь түлшний төлөвлөлтийн шаардлагыг дараах мэдээлэлд үндэслэсэн болохыг бататгана:

- (1) тухайн нисэх онгоцны маягийн гэрчилгээнд заасан үзүүлэлтэд нийцсэн бөгөөд үйлдвэрлэгчийн зааварт агуулагдсан, эсхүл түүнээс гаргаж авсан журам, хүснэгт болон график;
- (2) дараах өгөгдлийг багтаасан, тухайн төлөвлөсөн нислэг үйлдэх үйл ажиллагааны нөхцөл:
 - (i) нисэх онгоцны түлшний хэвийн зарцуулалтын өгөгдөл;
 - (ii) урьдчилан тооцоолсон жин;
 - (iii) таамаглаж байгаа цаг уурын нөхцөл;
 - (iv) НХҮ-ний шаардлага болон хязгаарлалт;
 - (v) нисэн очих аэродромын газар зүйн байрлал;
 - (vi) тогтоогдсон нөөцийн түлшний зарцуулалтад үзүүлэх нөлөө.

(c) Энэ зүйлийн (d)-д зааснаас бусад тохиолдолд, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагаанд шаардлагатай, хэрэглэх боломжит түлшний тооцоонд дараах хүчин зүйлийг тооцдог болохыг бататгана:

- (1) явгалах түлш (taxi fuel);
- (2) аяллын түлш (trip fuel);
- (3) дараах түлшнээс бүрдсэн нөөц түлш (reserve fuel);
 - (i) хазайлтыг нөхөх түлш (contingency fuel);
 - (ii) бэлтгэл аэродромын түлш (alternate fuel), хэрэв бэлтгэл аэродром шаардлагатай бол;

- (iii) үлдэгдэл-нөөц түлш (final-reserve fuel);
- (iv) нэмэлт түлш (additional fuel), хэрэв тухайн үйл ажиллагааны төрөлд шаардлагатай бол.

(d) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь хэрэв тухайн вариант нь гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт заагдсан бол нислэгийн замын дагуух дахин төлөвлөлтийн журмыг хэрэгжүүлэхдээ энэ зүйлийн (c)-д тооцож үзэхийг шаардсан хүчин зүйлийг өөрөөр авч үзэж болно.

121.77. Нислэгийн шалгалт хийх тогтолцоо

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах аргачлалыг багтаасан нислэгийн шалгалт хийх тогтолцоог нисэх багийн гишүүд хэрэглэхэд боломжтой байгааг бататгах үүрэгтэй:

- (1) нисэх багийн бүхээгийн удирдлагын аюулгүй, үр дүнтэй зааварчилгаа болон удирдамж;
- (2) нислэгийг аюулгүй гүйцэтгэхэд ашигладаг арга.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах зарчимд нийцүүлэн тухайн тогтолцоог цаг хугацаанд нь аюулгүй шийдвэр гаргах болон нисэх онгоц удирдах нөхцөлийг бүрдүүлдэг болохыг бататгах үүрэгтэй:

- (1) тухайн нисэх онгоцны нислэгийн зааварт багтсан;
- (2) үйлдвэрлэгчийн техникийн болон аюулгүй байдлын зааварчилгаанд багтсан;
- (3) багийн нөөцийн удирдлагын (CRM);
- (4) хүний хүчин зүйл болон сэтгэл судлалын;
- (5) ажиллах орчны таатай нөхцөлийн (ergonomics).

(c) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн тогтолцоонд дараах баримт бичиг багтсан болохыг бататгах үүрэгтэй:

- (1) үйл ажиллагааны зааврын дэлгэрэнгүй шалгах-хуудас;
- (2) тогтоосон дэс дарааллаар ажиглалт хийх;
- (3) хурдан лавлах гарын авлага (QRH);
- (4) онцгой нөхцөлийн журмыг багтаасан журам шалгах-хуудас.

(d) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах үе шатуудад нисэх багийн гишүүдийн ажил үүрэг гүйцэтгэх байрнаас ашиглах боломжтой журам тухайн тогтолцоонд агуулагдсан болохыг бататгах үүрэгтэй:

- (1) хөөрөлтийн өмнө болон хөөрөлт үйлдэх үед;
- (2) нислэгийн үед;
- (3) буулт үйлдэх үед;
- (4) хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн үед.

121.79. Онцгой нөхцөлийн гэрлэн дохио (emergency light)

Арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь ИНД-26 Хавсралт D-д шаардсан онцгой нөхцөлийн гэрлэн дохионы системийг явгалалт, хөөрөлт болон буулт үйлдэх үед ажиллагаатай, эсхүл асаалттай байгааг бататгах үүрэгтэй.

121.81. Зорчигчдын аюулгүй байдал

Арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь дараах шаардлагыг бататгана:

- (1) онцгой нөхцөлийн нүүлгэн шилжүүлэлт хийх үед, зорчигчдыг нисэх онгоцноос нүүлгэн шилжүүлэхэд саад болохгүй байхаар суулгасан байх;
- (2) согтууруулах ундаа, эсхүл эмийн бодисын нөлөөнд байгаа, эсхүл тухайн нисэх онгоц, эсхүл түүнд байгаа хүмүүсийн аюулгүй байдалд аюултай байж болох бүдүүлэг авир гаргасан зорчигчийг нисэх онгоцонд суулгахаас татгалздаг, эсхүл шаардлагатай тохиолдолд буулгадаг байх;
- (3) хөгжлийн бэрхшээлтэй зорчигчдыг онцгой нөхцөл үүссэн тохиолдолд, тусламж үзүүлэх болон тохиромжтой суудлын байрлалд хуваарилан зохих ёсоор асран халамжилдаг байх;
- (4) 15 нас хүрээгүй болон нялх хүүхэдтэй насанд хүрсэн зорчигчийг ослын гарцтай эгнээний суудалд суулгадаггүй байх;
- (5) харгалзагчтай зорчигч нь бусад зорчигчид, эсхүл нисэх онгоцонд аюул учруулахгүй байх зорилгоор гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт заасан журмын дагуу тэднийг тээвэрлэх урьдчилсан зохицуулалт хийдэг байх;
- (6) тухайн нисэх онгоцны бүхээгт хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл харгалзагчтай зорчигчийг тээвэрлэх тохиолдолд бүхээгийн ахлах ажилтан, эсхүл хөлгийн даргад мэдэгдсэн байх.

121.83. Зорчигчдод зориулсан мэдээлэл

(a) Арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь дараах тохиолдолд, “Суудлын бүсээ бүсэл” гэрлэн дохио асаалттай байгааг бататгах үүрэгтэй:

- (1) нисэх онгоц газар дээр хөдөлгөөн хийж байгаа үед;
- (2) хөөрөлт үйлдэж байгаа үед;
- (3) буулт үйлдэж байгаа үед;
- (4) хөлгийн дарга шаардлагатай гэж үзсэн бусад үед.

(b) Арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь нисэх онгоцонд тамхи татахыг хориглосон үед “Тамхи татахыг хориглоно” гэрэлтдэг тэмдэг, эсхүл зөвшөөрөгдсөн “Тамхи татахыг хориглоно” зурагт хуудсаар зорчигчид мэдээлдэг болохыг бататгах үүрэгтэй.

(c) Хэрэв нисэх онгоцонд “Тамхи татахыг хориглоно” гэрэлтдэг тэмдэг суурилуулсан бол, тамхи татахыг хориглосон үед дээрх гэрэл асаалттай байх ёстой.

121.85. Нисэх багийн бүхээгт орох зөвшөөрөл

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны нисэх багийн бүхээгт, чиглэлийн нислэгийн шалгалт авахад ашиглахад тохиромжтой, урагшаа харсан 1-ээс доошгүй ажиглагчийн суудал байгааг бататгах үүрэгтэй.

(b) Арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь тухайн нислэгт томилогдсон нисэх багийн гишүүдээс **бусад гадна**, хөлгийн дарга зөвшөөрч **болох еөн** дараахаас **этгээдээс** бусад этгээдийг нисэх багийн бүхээгт орох, эсхүл тээвэрлэхийг, эсхүл нисгэгчийн суудалд суухыг зөвшөөрдөггүй болохыг бататгах үүрэгтэй:

- (1) багийн гишүүн; эсхүл
- (2) Даргын эрх бүхий төлөөлөгч; эсхүл
- (3) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч Ерөнхий зааварт заасан журмын дагуу зөвшөөрсөн этгээд.

(c) Арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь, нисэх багийн бүхээгт орох зөвшөөрөлтэй, эсхүл нисгэгчийн суудалд сууж байгаа этгээд нь гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт заасан аюулгүй байдлын журамтай танилцсан болохыг бататгах үүрэгтэй.

121.87. Нисэх онгоцны удирдлагад оролцох

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараахаас бусад этгээдийг арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны удирдлагад оролцохыг зөвшөөрдөггүй болохыг бататгах үүрэгтэй:

- (1) 121.505-ын дагуу мэргэшсэн ба гэрчилгээ эзэмшигч зөвшөөрсөн нисэх багийн гишүүн; эсхүл
- (2) 121.505-ын дагуу мэргэшсэн, Даргын эрх бүхий дараах төлөөлөгч:
 - (i) гэрчилгээ эзэмшигчийн болон хөлгийн даргын зөвшөөрөлтэй;
 - (ii) шаардлагатай ажил үүрэг гүйцэтгэж байгаа.

(b) Энэ зүйлийн (a)(1), эсхүл (2)-т заасны дагуу зөвшөөрөгдсөн этгээдээс бусад аливаа этгээд арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны удирдлагад оролцохгүй байх үүрэгтэй.

121.89. Нислэгийн бичлэгийн төхөөрөмжид тавих шаардлага

(a) Нисэх багийн гишүүн нь дараах шаардлагыг бататгах **үүрэгтэй на:**

- (1) 121.371-д шаардсан **CVR** нь хөдөлгүүр асаахын өмнөх шалгах-хуудсыг уншиж эхлэхээс нислэгийн дараах төгсгөлийн шалгах-хуудсыг уншиж дуусах хүртэл тасралтгүй ажилладаг байх;
- (2) хэрэв тухайн нисэх онгоц нь гар, эсхүл маскны микрофоноос хүлээж авах тасалддаггүй аудио дохиог бичихээр тоноглогдсон бол, тухайн гар микрофоныг 3000 м-ээс (10 000 ft) доош **өндрийн** түвшинд ашигладаг байх;
- (3) ~~хэрэв CVR-ийн бичлэг арилгах үйлдлийг ашигладаг бол зөвхөн сүүлчийн бичлэгийн 30 минутаас өмнө бичигдсэн мэдээллийг устгадаг, эсхүл бусад хэлбэрээр арилгадаг байх~~ хэрэв **CVR** нь бичлэгээ арилгах чадвартай бол **техник үйлчилгээ, эсхүл аюулгүй байдлын шинжлэн шалгах ажиллагаанаас бусад зорилгоор түүний бичлэгийг арилгадаггүй байх.**

- (b) Нисэх багийн гишүүн нь дараах шаардлагыг бататгах үүрэгтэй на:
- (1) 121.373-т шаардсан **FDR** нь тухайн нисэх онгоц **жөөрөлт-эхлэхээс буулт-үйлдэж дуусах** өөрийн хөдөлгүүрийн хүчээр хөдөлж эхлэхээс нислэг дуусч бүрэн зогсох хүртэлх хугацаанд тасралтгүй ажилладаг байх;
 - (2) ~~нислэгийн цикл бүрийн дараа, тухайн нисэх онгоц 25-аас доошгүй цагийн нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх хүртэл бүх бичигдсэн өгөгдлийг хадгалдаг байх~~ сүүлийн 25-аас доошгүй цагийн үйл ажиллагааг тоон өгөгдөл хэлбэрээр бичдэг ба хадгалдаг байх;
 - (3) нислэгийн бичлэгийн төхөөрөмж, эсхүл нислэгийн бичлэгийн төхөөрөмжийн системд шалгалт хийх зорилгоор, **эсхүл аюулгүй байдлын шинжлэн шалгах ажиллагааны дараа** 1-ээс ~~дээш~~ **ихгүй** цагийн бичигдсэн өгөгдлийг арилгадаггүй байх;
 - (4) энэ зүйлийн (b)(3)-ын дагуу хийсэн арилгах үйлдэл нь:
 - (i) **тест, эсхүл аюулгүй байдлын шинжлэн шалгах ажиллагаа** хийх үед хадгалагдсан хамгийн эхэнд бичигдсэн өгөгдөл байх;
 - (ii) холбогдох техник үйлчилгээний баримт бичигт тэмдэглэгдсэн байх.

121.91. Түлшээр сумлах болон түлш юүлэх үйл ажиллагаа

(a) ИНД-91.15(3)-ыг үл харгалзан, ИНД-119-ийн дагуу олгосон АТ-ийн гэрчилгээний эрхийн хүрээнд нисэх онгоцоор үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь, хэрэв гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт заасан журмын дагуу аюулгүй байдлын болон нүүлгэн шилжүүлэх анхааруулах арга хэмжээ авсан болохыг тухайн нисэх онгоцоор үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд бататгасан бол, аливаа этгээдийг нисэх онгоцонд суулгаж байхад, бүхээгт байхад, эсхүл буулгаж байх үед 3.1C, эсхүл 3.1D ангиллын шатамхай шингэнээр нисэх онгоцыг сумлах, эсхүл юүлэх үйл ажиллагааг гүйцэтгэж болно.

(b) ИНД-119-ийн дагуу олгосон АТ-ийн гэрчилгээний эрхийн хүрээнд нисэх онгоцоор үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь дараах тохиолдолд 1, эсхүл түүнээс олон татах хүчний төхөөрөмж ажиллаж байх үед 3.1C, эсхүл 3.1D ангиллын шатамхай шингэнээр нисэх онгоцыг сумлах, эсхүл юүлэх үйл ажиллагааг гүйцэтгэж болно, хэрэв:

- (1) түлшээр сумлах, эсхүл түлш юүлэх үйл ажиллагаа эхлэхийн өмнө, бүх зорчигчийг багийн гишүүний хяналтан дор нисэх онгоцноос буулгасан байх ба тэд тухайн талбайгаас зайтай байгаа бол;
- (2) түлшээр сумлах, эсхүл түлш юүлэх үйл ажиллагааны бүх асуудлыг хөлгийн дарга хариуцдаг бол.

121.93. Нөөц

121.95. Онцгой нөхцөлийн үеийн арга хэмжээний төлөвлөгөө

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь, агаарт болон газарт үүссэн онцгой нөхцөлийн үед ажиллах болон хүмүүсийг гэмтээх эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан болохыг бататгах үүрэгтэй на.

(b) Гэрчилгээ эзэмшигчийн онцгой нөхцөлийн үеийн арга хэмжээний төлөвлөгөө нь дараах өгөгдөлд суурилсан байх боловч үүгээр хязгаарлагдахгүй **байх ёстой**:

- (1) тухайн үйл ажиллагаа гүйцэтгэдэг нислэгийн замын төрөл болон урт;
- (2) аэродромын газрын байгууламж;
- (3) орон нутгийн авран хамгаалах үйлчилгээ;
- (4) НХУ-ын байгууламж;
- (5) ашиглаж болох нисэх онгоцны маяг, суудлын конфигураци болон төлбөрт ачаалал.

(c) Гэрчилгээ эзэмшигчийн агаарт **үүссэн** онцгой нөхцөлийн үед ажиллах төлөвлөгөө нь дараах журмыг багтаасан байх **ёстой** **на**:

- (1) хэрэв удирдах ажилтан нислэгийн үед нисэх онгоцонд онцгой нөхцөл үүссэн болохыг мэдсэн бол, дараах шаардлагыг бататгах зорилгоор ажилтнуудын мөрдөх яаралтай шийдвэр болон арга хэмжээ авахыг шаардсан журам:
 - (i) тухайн онцгой нөхцөлийн талаар хөлгийн даргад мэдэгдэх;
 - (ii) хөлгийн даргын шийдвэрийг бататгах;
 - (iii) тухайн шийдвэрийг бүртгэх;
- (2) хэрэв удирдах ажилтан энэ зүйлийн (c)(1)-ийн дагуу хөлгийн даргатай холбоо тогтоох боломжгүй бол, дараах шаардлагыг бататгах зорилгоор ажилтнуудын мөрдөх журам:
 - (i) онцгой нөхцөлийг зарлах;
 - (ii) тухайн нөхцөл байдалд шаардлагатай гэж үзсэн арга хэмжээг авах.

(d) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь, онцгой нөхцөлийн үеийн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу онцгой нөхцөлийн үед үүрэг гүйцэтгэх ажилтан сургалтад хамрагдсан бөгөөд ур чадвар эзэмшсэн болохыг бататгах **үүрэгтэй** **на**.

121.97. Үйл ажиллагааг хязгаарлах, эсхүл түдгэлзүүлэх

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагааны аюулгүй байдалд аливаа аюултай нөхцөл байгааг мэдсэн даруйд тухайн аюулыг зайлуулах хүртэл үйл ажиллагаагаа шаардлагатай байдлаар хязгаарлана, эсхүл түр зогсооно.

121.99. Нисэх багийн бүхээгийн хаалгыг түгжих

Зорчигч тээвэрлэн агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисэх онгоцны дарга нь, зорчигчдыг суулган гадна бүх хаалгыг хааснаас хойш, зорчигчдыг буулгахаар гадна хаалгыг нээх хүртэл хөлгийн даргын зөвшөөрлөөр аливаа этгээд орох, эсхүл гарахаас бусад тохиолдолд, нисэх багийн бүхээгийн хаалга хаалттай ба түгжээтэй байгааг бататгах үүрэгтэй.

121.101. Нисэх багийн бүхээгийн хаалганы гадна орчныг хянах

Зорчигч тээвэрлэн агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисэх онгоцны дарга, багийн гишүүн нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц харааны хэрэгсэл болон аудио-ярианы журмыг ашиглан дараах шаардлагыг бататгадаг байхаас бусад тохиолдолд, нисэх багийн бүхээгийн хаалганы түгжээг онгойлгодоггүй болохыг бататгах үүрэгтэй:

- (1) нисэх багийн бүхээгийн хаалганы гадна орчин аюулгүй байх;
- (2) нисэх багийн бүхээгийн хаалгыг нээлгэхийг хүсэж байгаа этгээд нь хүчинд автагдаагүй болохыг бататгах.

121.103. Нисэх багийн гишүүдтэй харилцах нууц дохио

Зорчигч тээвэрлэн агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь хэрэв бүхээгт сэжигтэй үйлдэл, эсхүл аюулгүйн хамгаалалтын зөрчил илэрсэн бол, бүхээгийн ажилтан нууц харилцах дохио ашиглан нисэх багийн гишүүнд мэдэгдэх чадвартай болохыг бататгах Даргын хүлээн зөвшөөрөхүйц журмыг ашиглах үүрэгтэй.

С Бүлэг - Үйл ажиллагааны хязгаарлалт болон цаг агаарын шаардлага

121.151. Зорилго

Энэ Бүлэг нь VFR, IFR-ийн үйл ажиллагаа болон холбогдох цаг агаарын зохицуулалтын шаардлагыг тогтооно.

121.153. Цаг уурын мэдээ

(а) Арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь иргэний нисэхэд ашиглах зорилгоор дараах байгууллагын хангасан цаг уурын мэдээг ашиглан нислэгийг төлөвлөж, гүйцэтгэх ба хяналт тавих үүрэгтэй:

- (1) энэ зүйлийн (b)-г харгалзан, Монгол Улсаас эхлэлтэй нислэгийн хэсгийн хувьд, ИНД-174-ийн дагуу олгосон нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч; эсхүл
- (2) Монгол Улсын гаднах аэродромоос эхлэлтэй нислэгийн хэсгийн хувьд:
 - (i) ИНД-174-т заасантай дүйцэх стандартыг хангасан нисэхийн цаг уурын байгууллага;
 - (ii) ICAO-гийн Хэлэлцэн тохирогч Улсаас нисэхийн цаг уурын мэдээгээр хангах эрх олгогдсон нисэхийн цаг уурын байгууллага.

(b) Нисэх онгоцны дарга нь Монгол Улсаас эхэлж, Монгол Улсад дуусдаг нислэгийн хэсгийн хувьд, хэрэв нислэг гүйцэтгэж байгаа АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь ИНД-174.6-гийн шаардлагын дагуу өгөгдсөн цаг агаарын үндсэн мэдээг шаардлага хангаж байна гэж үзвэл цаг агаарын үндсэн мэдээнд өгөгдсөн цаг уурын мэдээллийг хэрэглэлийн ойртолтын журмыг ашиглах зорилгоор хэрэглэж болно.

121.155. VFR нислэгийн цаг уурын нөхцөл

(а) Арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисэх онгоцны дарга, ИНД-91 болон энэ зүйлийн (d)-д заасан VFR-ийн минима-г харуулах цаг уурын бодит мэдээ, эсхүл нэгтгэсэн цаг уурын бодит мэдээ болон урьдчилсан мэдээ нь VFR-ийн дагуу нисэх нислэгийн зам, эсхүл тухайн нислэгийн замын тодорхой хэсэгт тохирч байхаас бусад тохиолдолд, VFR нислэгийг эхлүүлэхгүй байх үүрэгтэй.

(b) Аливаа этгээд VFR-ийн дагуу усан дээгүүрх үргэлжилсэн нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байх үүрэгтэй.

(c) Хяналттай агаарын зайн гадна VFR-ийн дагуу арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисэх онгоцны дарга нь дараах нөхцөлд нисэх үүрэгтэй:

- (1) үүлний суурийн өндөр газрын түвшнээс дээш (AGL) 300 м-ээс (1000 ft) доошгүй ба нислэгийн хараа 5 км-ээс багагүй байх цаг уурын нөхцөлд;
- (2) үүлний суурийн өндрөөс доогуур, үүлнээс зайтай хэвээр байх ба газар, эсхүл ус байнга харагдаж байхад;
- (3) солигдмол үүлнээс (SCT 3-4 окт) бага үүлний дээгүүр.

(d) Дараахаас бусад тохиолдолд, нисэх онгоцны дарга олон-хөдөлгүүртэй нисэх онгоцоор солигдмол үүлнээс (SCT 3-4 окт) их үүлний дээгүүр VFR-ийн дагуу арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байх үүрэгтэй:

- (1) тухайн нисэх онгоц нь IFR нислэгт зөвшөөрөгдсөн ба хүчинтэй хэрэглэлийн зэрэглэлтэй, IFR-ийн үйл ажиллагаанд шаардлагатай минимум нисэх баг тухайн үйл ажиллагааг гүйцэтгэж байх;
- (2) IFR нислэгт шаардлагатай, радио навигацийн төхөөрөмжийг багтаасан хэрэглэл болон төхөөрөмж нь ажиллагаатай байх;
- (3) тухайн нисэх онгоц нь нэг хөдөлгүүр ажиллагаагүй үед үүлнээс дээш 300 м-ийн (1000 ft) өндөрт эерэг өндөр авах өнцөгтэй нислэгийн аюулгүй замыг хадгалах чадвартай байх;
- (4) тухайн нисэх онгоц нь хэрэглэлийн ойртолтын журмыг буулт үйлдэхэд ашиглах бол, аэродром хүртэл IFR-аар нислэг үйлдэх боломж олгодог радио навигацийн төхөөрөмжөөр тоноглогдсон байх;
- (5) тухайн нисэх онгоц нь хэрэглэлийн ойртолтын журмыг буулт үйлдэхэд ашиглах бол, аэродром хүртэл IFR-аар нислэгийг үргэлжлүүлэхэд хангалттай түлш болон нөөц түлш тээвэрлэж байх.

121.157. IFR нислэгийн цаг уурын нөхцөл

(a) Арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисэх онгоцны дарга нь цаг уурын бодит мэдээ, эсхүл нэгтгэсэн цаг уурын бодит мэдээ болон урьдчилсан мэдээ нь дараах нөхцөлийг харуулж байхаас бусад тохиолдолд, IFR-ийн дагуу үйл ажиллагаа эхлүүлдэггүй байх үүрэгтэй:

- (1) тухайн нисэн очих аэродромд нисэн хүрэх тооцоот цагт тухайн аэродромд ашиглаж болох хэрэглэлийн журмын холбогдох AIP-д хэвлэн нийтэлсэн минима-д, эсхүл түүнээс дээш байх; эсхүл
- (2) дараах аэродромд ашиглах тооцоот цагт:
 - (i) нэг бэлтгэл аэродромд, ИНД-91.405(a)(2)-т шаардсан үүлний суурийн өндөр болон хараа тохирч байх; эсхүл
 - (ii) хоёр бэлтгэл аэродромд, ИНД-91.405(b)-д шаардсан үүлний суурийн өндөр болон хараа тохирч байх.

(b) Нисэх онгоцны дарга, ИНД-91.405(b)-д шаардсан үүлний суурийн өндөр болон харааны шаардлага хангасан нэгээс доошгүй бэлтгэл аэродром бэлэн байхаас бусад тохиолдолд, IFR-ийн дагуу арилжааны нислэгийн үйл ажиллагаа эхлүүлэхгүй байх үүрэгтэй, хэрэв:

- (1) тухайн үйл ажиллагааны хувьд нисэн гарах, эсхүл нисэн очих аэродром нь Монгол Улсын гадна бол;
- (2) нисэн очих аэродром нь ашиглаж байгаа нисэх онгоц буулт үйлдэхэд тохирсон хоёроос бага бие даасан ХБЗ-тай бол.

121.159. IFR нислэгийн аэродромын үйл ажиллагааны минима

(a) Хэрэв ойртолтын төгсгөлийн цэгийг (FAF) дайран өнгөрөхөөс өмнө, эсхүл ойртолтын төгсгөлийн сегментийг эхлүүлэхийн өмнө тухайн ашиглаж байгаа хэрэглэлийн ойртолтын журмаар аэродромын хараа нь холбогдох AIP-д хэвлэн нийтэлсэн хараанаас бага байгааг цаг уурын бодит мэдээ харуулж байгаа бол, нисэх онгоцны дарга FAF өнгөрч аэродром руу хэрэглэлийн ойртолтыг үргэлжлүүлэхгүй байх, эсхүл хэрэв FAF ашиглаагүй бол, хэрэглэлийн ойртолтын журмын ойртолтын төгсгөлийн сегментийг эхлүүлэхгүй байх үүрэгтэй.

(b) Энэ зүйлийн (a)-ийн зорилгоор, ойртолтын төгсгөлийн сегмент нь дараах цэгээс эхэлнэ:

- (1) хэрэглэлийн ойртолтын журамд заасан FAF, эсхүл байгууламжаас; эсхүл
- (2) хэрэв FAF нь хэрэглэлийн ойртолтын журамд заагдаагүй **боловч ба** тухайн журам нь **стандарт** эргэлтийг **хийх-журмыг** багтаасан бол тухайн нисэх онгоц нь **стандарт** эргэлт **хийх-журмыг**-гүйцэтгэж дуусаад **сан-ба** тухайн хэрэглэлийн ойртолтын журамд заасан зайд ойртолтын төгсгөлийн чиглэлд (final approach course) орсон цэгээс.

121.159A. Аэродром бүрд ашиглах аэродромын үйл ажиллагааны минима

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа хөлгийн дарга холбогдох AIP-д хэвлэн нийтэлсэн тухайн аэродромд хамаарах аэродромын үйл ажиллагааны минима-г мөрддөг болохыг бататгах үүрэгтэй.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт аэродромын үйл ажиллагааны ихэсгэсэн минима-г оруулснаар тухайн минима-г ихэсгэж болно.

(c) Аэродромын үйл ажиллагааны ихэсгэсэн минима-гийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа хөлгийн дарга нь үйл ажиллагаа эрхлэгчийн Ерөнхий зааварт заасан аэродромын үйл ажиллагааны ихэсгэсэн минима-гийн шаардлагыг мөрдөх үүрэгтэй.

121.161. IFR-аар нисэн гарах хязгаарлалт

Аэродром нь дараах нисэх онгоцонд тохиромжтой байхаас бусад тохиолдолд, арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь цаг агаарын нөхцөл нь ИНД-91.413-т заасан хөөрөлтийн минима-гийн шаардлагад, эсхүл түүнээс дээш ба ИНД-91.413-т заасан IFR буултын минима-гийн шаардлагаас доош байгаа үед тухайн аэродромоос IFR нислэг эхлүүлдэггүй болохыг бататгах үүрэгтэй:

- (1) хоёр-хөдөлгүүртэй нисэх онгоцны хувьд, тогтуун агаарт нэг хөдөлгүүр ажиллагаагүй үеийн аяллын нислэгийн хурдтайгаар нисэн гарах аэродромоос максимум 1 цагийн нислэгийн зайд байх; эсхүл
- (2) гурав, эсхүл түүнээс олон хөдөлгүүртэй нисэх онгоцны хувьд, тогтуун агаарт нэг хөдөлгүүр ажиллагаагүй үеийн аяллын нислэгийн хурдтайгаар нисэн гарах аэродромоос максимум 2 цагийн нислэгийн зайд байх.

121.163. Хөөрөлтийн багасгасан минима

(a) Хэрэв АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн үйл ажиллагааг Ерөнхий заавартаа заасан хөөрөлтийн багасгасан минима-гийн журмын дагуу гүйцэтгэж байгааг бататгасан бол АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь ИНД-91.413(f)-д зааснаас бага хөөрөлтийн минима-д нисэх онгоцоор үйл ажиллагаа гүйцэтгэж болно.

(b) Хөөрөлтийн багасгасан минима-гийн журамд дараах шаардлагыг заасан байх ёстой:

- (1) хөлгийн дарга болон хамтран нисгэгч нь 121.537-гийн дагуу хөөрөлтийн багасгасан минима-гаар мэргэшсэн байх;
- (2) ашиглах ХБЗ нь гол шугамын тэмдэглэгээ, эсхүл гол шугамын гэрэлтүүлэгтэй байх;
- (3) ашиглах ХБЗ-ны хөөрөлтийн багасгасан минима-г холбогдох AIP-д хэвлэн нийтэлсэн байх;
- (4) хэрэв нисэх онгоц нь хоёр сэнсэн-хөдөлгүүртэй нисэх онгоц бол, тухайн нисэх онгоцыг ажиллагаатай сэнсний авто-флюгерийн (auto-feather), эсхүл авто-өнцөг өөрчлөх (auto-coarse) системээр тоногдсон байх;
- (5) тухайн ХБЗ-ны харааг ХБЗ-ны ил харааны зайг (RVR) ашиглан тогтоосон байх;
- (6) хөөрөлт үйлдэхэд шаардлагатай хараа тохирч байгааг хянах болон бататгах арга нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх.

121.165. Нислэгийн замын зайн хязгаарлалт

(a) Тухайн нисэх онгоц нь 60 минутаас дээш нислэгийн цаг шаардсан (стандарт цаг агаарын нөхцөлд, тогтуун агаарт, нэг хөдөлгүүр ажиллагаагүй үеийн аяллын нислэгийн хурдтай байхаар тооцоолсон) нислэгийн замд тохирох аэродромоос поршинт-хөдөлгүүртэй нисэх онгоцоор арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэхийг АТ-ийн гэрчилгээ эзэмшигчид зөвшөөрөхгүй.

(b) Тухайн нисэх онгоц нь 60 минутаас дээш нислэгийн цаг шаардсан (стандарт цаг агаарын нөхцөлд, тогтуун агаарт, нэг хөдөлгүүр ажиллагаагүй үеийн аяллын нислэгийн хурдтай байхаар тооцоолсон) нислэгийн замд тохирох аэродромоос дараахаас бусад тохиолдолд, хоёр турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоцоор арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэхийг АТ-ийн гэрчилгээ эзэмшигчид зөвшөөрөхгүй:

- (1) 121.955(b)-д зааснаас бусад тохиолдолд, тухайн нисэх онгоц нь тохирох аэродромоос 60 минутаас дээш нислэгийн цаг үйл ажиллагаа гүйцэтгэхээр (стандарт цаг агаарын нөхцөлд, тогтуун агаарт, нэг хөдөлгүүр ажиллагаагүй үеийн аяллын нислэгийн хурдтай байхаар тооцоолсон) маягийн загварын тодорхойлолтод гэрчилгээжсэн байх;
- (2) гэрчилгээ эзэмшигч нь N Бүлгийн дагуу EDTO нислэг үйлдэх эрхтэй байх;
- (3) тухайн нисэх онгоц нь энэ Дүрэмд заасан холбогдох EDTO нислэгийн шаардлагын дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байх.

(с) Энэ зүйлийн (d)-г харгалзан, 180 минутаас дээш нислэгийн цаг шаардсан нислэгийн замд (стандарт цаг агаарын нөхцөлд, тогтуун агаарт, нэг хөдөлгүүр ажиллагаагүй үеийн аяллын нислэгийн хурдтай байхаар тооцоолсон), гэрчилгээ эзэмшигч нь N Бүлгийн дагуу EDTO нислэг үйлдэх болон тухайн нисэх онгоц нь энэ Дүрэмд заасан холбогдох EDTO нислэгийн шаардлагын дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байхаас бусад тохиолдолд, тохирох аэродромоос хоёроос олон турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоцоор арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэхийг АТ-ийн гэрчилгээ эзэмшигчид зөвшөөрөхгүй.

121.167. Нөөц

121.169. IFR-ийн журам

(а) Дараахаас бусад тохиолдолд, IFR-ийн дагуу арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны дарга, тухайн үйл ажиллагааг холбогдох AIP-д хэвлэн нийтэлсэн нислэгийн замаар гүйцэтгэх үүрэгтэй:

- (1) бодит аюултай нөхцөлөөс зайлсхийхэд шаардлагатай бол; эсхүл
- (2) НХУ-ний радарын хяналтад үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бол; эсхүл
- (3) НХУ-ын нэгжээс авсан нислэгийн замын гадуур нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бол; эсхүл
- (4) тухайн үйл ажиллагааг зөвшөөрдөг АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт өөрөөр заасан бол.

(b) Хяналттай агаарын зайд холбогдох НХУ-ын нэгжээс зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд хөлгийн дарга, ашиглаж байгаа аэродромд холбогдох AIP-д хэвлэн нийтэлсэн IFR-ийн нисэн гарах болон ойртолтын журмыг мөрдөх үүрэгтэй.

(с) Хяналтгүй агаарын зайд хөлгийн дарга, ашиглаж байгаа аэродромд холбогдох AIP-д хэвлэн нийтэлсэн IFR-ийн нисэн гарах болон ойртолтын журмыг мөрдөх үүрэгтэй.

121.171. Туйлын бүсийн арилжааны нислэгийн үйл ажиллагааны шаардлага

~~(a)~~ Дарга зөвшөөрснөөс бусад тохиолдолд, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь туйлын бүсэд арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэхгүй байх үүрэгтэй.

121.173. Туйлын бүсэд арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт

Туйлын бүсэд арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахаар хүсэлт гаргаж байгаа АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь төлөвлөсөн арилжааны нислэгийн үйл ажиллагаагаа эхлэхээс 90-ээс доошгүй хоногийн өмнө, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц богино хугацаанд дараах мэдээллийг Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (1) тухайн аэродром руу даялах нислэг үйлдэх цаг хугацаанд хангасан байх шаардлагатай, EDTO нислэгийн бэлтгэл аэродромын шалгуур болон тусгай үйл ажиллагааны шаардлагыг хангасан туйлын бүсийн аэродромын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (2) энэ зүйлийн (1)-ийн дагуу бэлтгэлээр сонгосон аэродромд нислэгийн үйл ажиллагааг сэргээх төлөвлөгөө (recovery plan);

- (3) түлшний хөлдөлтийг хянах журам болон түлшний хөлдөлтийн стратеги;
- (4) туйлын бүсэд арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байх үед 121.957(b)(2)(ii)-т шаардсан холбоо барих чадварыг хангаж байгааг бататгах төлөвлөгөө;
- (5) туйлын бүсэд арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэх сургалтын төлөвлөгөө;
- (6) нарны идэвхжлийн үед багийн гишүүдийг нарны туяаны нөлөөллөөс хамгаалах журам;
- (7) улирлын цаг агаарын нөхцөлөөс шалтгаалан Дарга дулаан хувцас шаардлагагүй гэж тогтоосноос бусад тохиолдолд, цаг агаарын хүндрэлтэй нөхцөлд аэродром дээр гадаа хийгдэх үйл ажиллагааны үед багийн гишүүдийг хүйтнээс хамгаалах хоёроос доошгүй дулаан хувцсыг туйлын бүсэд үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцонд авч явдаг болохыг бататгах журам.

121.175. Туйлын бүсийн арилжааны нислэгийн үйл ажиллагааны зөвшөөрөл

Хэрэв Дарга тухайн аэродром, мэдээллийн дэлгэрэнгүй болон 121.173-ын дагуу гэрчилгээ эзэмшигчийн хүргүүлсэн журам нь тухайн үйл ажиллагааны аюулгүй байдлыг бататгахад хангалттай гэж үзвэл, Дарга АТ-ийн гэрчилгээ эзэмшигчид туйлын бүсэд арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхийг зөвшөөрөх зорилгоор ИНД-119.15-д шаардсан Үйл ажиллагааны тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулж болно.

D Бүлэг - Нислэгийн үзүүлэлт

121.201. Зорилго

(a) Энэ Бүлэг нь дараах нисэх онгоцонд хамааралтай, нисэх онгоцны үйл ажиллагааны үзүүлэлтийн хязгаарлалтыг тогтооно:

- (1) арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашигладаг;
- (2) FAR-25-ын НТЧ-ын стандартын дагуу, эсхүл түүнтэй дүйцэх НТЧ-ын стандартын дагуу гэрчилгээжсэн, ИНД-125, эсхүл ИНД-135-ын дагуу гүйцэтгэж байгаа үйл ажиллагаанд ашигладаг:
 - (i) 20, эсхүл түүнээс дээш зорчигчийн суудлын конфигурацитай сэнсэн-хөдөлгүүртэй нисэх онгоц; эсхүл
 - (ii) турбо-жэт, эсхүл турбо-фэн олон-хөдөлгүүртэй нисэх онгоц.

(b) Энэ Бүлгийн шаардлагыг бүрэн хангаагүй нисэх онгоцыг өөр орлох үйл ажиллагааны үзүүлэлтийн хязгаарлалтын дагуу ашиглахыг зөвшөөрч болно.

121.203. Нөөц

121.205. Нисэх онгоцны ерөнхий үзүүлэлт

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагаандаа ашиглаж байгаа нисэх онгоцны хувьд дараах шаардлагыг бататгана:

- (1) дараах хүчин зүйлийг тооцон гүйцэтгэх нислэгийн хувьд, түүний хөөрөлт эхлэх үеийн хөөрөлтийн жин нь энэ Бүлгийн дагуу зөвшөөрсөн жингээс илүүгүй байх:
 - (i) тухайн нислэг үргэлжлэх явцад жин багасах баримжаа;
 - (ii) энэ Бүлгийн дагуу гүйцэтгэх түлш цацах ажиллагаа (fuel jettison).
- (2) энэ Бүлгийн үзүүлэлтийн шаардлагатай нийцэж байгааг тодорхойлоход ашигладаг техникийн өгөгдөл нь:
 - (i) тухайн нисэх онгоцны нислэгийн зааварт багтсан байх; эсхүл
 - (ii) тунадастай ХБЗ-ны буултын зайн өгөгдлийн хувьд, нисэх онгоц үйлдвэрлэгчээс хангагдсан ба Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх.

121.207. Хөөрөлтийн зай

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагаандаа ашиглаж байгаа нисэх онгоцны хөөрөлтийн жинг, тухайн нисэх онгоцны нислэгийн зааварт заасан хөөрөлтийн максимум жингээс хэтрээгүй болохыг бататгана.

(b) Энэ зүйлийн (a)-д нийцэж байгааг тогтоох зорилгоор АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь хөөрөлтийн максимум жинг тооцоолохдоо, эрсдэлтэй хөдөлгүүр (critical engine) V_{EF} хурдан дээр татгалзсан ба ганц V_1 -хурдыг ашиглаж байгаа гэж үзэн дараах шаардлагыг бататгана:

- (1) хөөрөлтийн гүйлтийг зогсоох шаардлагатай зай нь хөөрөлтийн гүйлтийг зогсоох боломжит зайнаас (ASDA) хэтрэхгүй байх;
- (2) хөөрөлтийн шаардлагатай зай нь хөөрөлтийн боломжит зайнаас (TODA) хэтрэхгүй байх;
- (3) TODA-гийн хэсгийг бүрдүүлж байгаа саадаас чөлөөтэй талбай нь хөөрөлтийн гүйлт үйлдэх боломжит зайн (TORA) уртын хагасаас хэтрэхгүй байх;
- (4) ХБЗ нь нойтон, эсхүл тунадастай үед хөөрөлтийн зайг багасгасан V_1 -хурдыг ашиглан нисэх онгоц хөөрөлтийн гадаргуугаас дээш 4,5 м-ийн (15 ft) өндөрт хүрэх цэг хүртэл тооцоолсон байх;
- (5) хөөрөлтийн гүйлт үйлдэх шаардлагатай зай нь татгалзсан ба үргэлжлүүлсэн хөөрөлт үйлдэхэд V_1 -хурдыг ашиглан TORA-гаас хэтрэхгүй байх;
- (6) нойтон болон тунадастай ХБЗ дээрх хөөрөлтийн жин нь ижил нөхцөлтэй хуурай ХБЗ-ны хөөрөлтийн зөвшөөрөгдсөн жингээс хэтрэхгүй байх.

(c) Энэ зүйлийн (b)-гийн дагуу хөөрөлтийн максимум жинг тооцоолохдоо АТ-ийн гэрчилгээ эзэмшигч дараах хүчин зүйлийг тооцож үзнэ:

- (1) аэродромын өндөрлөг;
- (2) Олон улсын стандарт атмосферийн (ISA) даралтаас тухайн атмосферийн даралт нь 1%-иас их ялгаатай бол, тухайн аэродромын даралтын **өндрийн-түвшин**;
- (3) тухайн аэродромын орчны агаарын хэм;
- (4) тухайн ХБЗ-ны гадаргуугийн төрөл болон ХБЗ-ны гадаргуугийн нөхцөл;

- (5) хөөрөлт үйлдэх чиглэл дэх ХБЗ-ны налуу;
- (6) мэдээнд өгөгдсөн ~~урдаас-чиглэсэн~~ **угтах** салхины бүрдэл хэсэг 50%-иас ихгүй, эсхүл арын ~~аас-чиглэсэн~~ салхины бүрдэл хэсэг 150%-иас багагүй байх.

121.209. ХБЗ-ны гадаргууг засаж тооцох хүчин зүйл

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь, өөр сонголт хийхийг зөвшөөрдөг техникийн өгөгдөл бэлэн байхаас бусад тохиолдолд 121.207(с)(4)-ийн дагуу тухайн ХБЗ-ны гадаргуугийн төрлийн тооцоолсон хөөрөлтийн зай болон 121.221(с)(3)-ын дагуу тооцоолсон буултын зайг бусад төрлийн ХБЗ-ны гадаргуугийн хувьд, Хүснэгт 1-д заасан хүчин зүйлийг ашиглан засаж тооцоолдог болохыг бататгана:

Хүснэгт 1.

Гадаргуугийн төрөл	Хөөрөлтийн зайн хүчин зүйл	Гүйлтийг зогсоох зайн хүчин зүйл	Буултын зайн хүчин зүйл
Хучилттай	x 1.00	x 1.00	x 1.00
Корал	x 1.00	x 1.03	x 1.05
Металл	x 1.05	x 1.06	x 1.08
Сайжруулсан хөрс	x 1.08	x 1.14	x 1.16
Зүлэг	x 1.14	x 1.20	x 1.18

121.211. Хөөрөлтийн үеийн нислэгийн аюулгүй зам

(а) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагаандаа ашиглаж байгаа нисэх онгоцны хувьд, эрсдэлтэй хөдөлгүүр ажиллагаагүй гэж үзэн, хөөрөлтийн үеийн нислэгийн аюулгүй замын бүх саадыг дараах зайнаас доошгүй босоо зайтай өнгөрдөг болохыг бататгана:

- (1) 10.5 м (35 ft) - 15°-аас хэтрэхгүй налуу өнцгөөр эргэлт хийхээр төлөвлөсөн нисэх онгоцоор хөөрөлт үйлдсэн тохиолдолд;
- (2) 4.5 м (15 ft) - дараах хөөрөлт үйлдсэн тохиолдолд:
 - (i) 15°-аас хэтрэхгүй налуу өнцгөөр эргэлт хийхээр төлөвлөсөн нисэх онгоцоор;
 - (ii) 121.207(б)(4)-ийн дагуу;
- (3) 15 м (50 ft) - 15°-аас хэтэрсэн налуу өнцгөөр эргэлт хийхээр төлөвлөсөн нисэх онгоцоор хөөрөлт үйлдсэн тохиолдолд;
- (4) 9 м (30 ft) - дараах хөөрөлт үйлдсэн тохиолдолд:
 - (i) 15°-аас хэтэрсэн налуу өнцгөөр эргэлт хийхээр төлөвлөсөн нисэх онгоцоор;
 - (ii) 121.207(б)(4)-ийн дагуу.

(b) Энэ зүйлийн (a)-ийн зорилгоор, хэрэв тухайн саадаас төлөвлөсөн нислэгийн шугам хүртэлх хажуугийн хэвтээ зай нь дараах зайнаас хэтрээгүй бол, тухайн саадыг хөөрөлтийн үеийн нислэгийн аюулгүй зам дээр байна гэж тооцно:

- (1) төлөвлөсөн нислэгийн зам нь 15° -аас хэтэрсэн чиглэлийн өөрчлөлт шаарддаггүй тохиолдолд:
 - (i) 75 м дээр нэмэх нь 0.125D-гээс максимум 600 м хүртэл, эсхүл хэрэв АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь нисгэгчид зориулсан ил харааны, эсхүл радио навигацыйн чиглэл дагах журмыг ашигладаг бол, максимум 300 м хүртэл; эсхүл
 - (ii) МСТOW нь 22 700 кг-аас хэтрээгүй нисэх онгоцоор, VMC-д, өдрийн цагаар гүйцэтгэх үйл ажиллагааны хувьд, 45 м дээр нэмэх нь 0.125D-гээс максимум 600 м хүртэл, эсхүл хэрэв АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь нисгэгчид зориулсан ил харааны, эсхүл радио навигацыйн чиглэл дагах журмыг ашигладаг бол, максимум 300 м хүртэл; эсхүл
- (2) төлөвлөсөн нислэгийн зам нь 15° -аас хэтэрсэн чиглэлийн өөрчлөлт шаарддаг тохиолдолд:
 - (i) 75 м дээр нэмэх нь 0.125D-гээс максимум 900 м хүртэл, эсхүл хэрэв АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь нисгэгчид зориулсан ил харааны, эсхүл радио навигацыйн чиглэл дагах журмыг ашигладаг бол, максимум 600 м хүртэл; эсхүл
 - (ii) МСТOW нь 22 700 кг-аас хэтрээгүй нисэх онгоцоор, VMC-д, өдрийн цагаар гүйцэтгэх үйл ажиллагааны хувьд, 45 м дээр нэмэх нь 0.125D-гээс максимум 900 м хүртэл, эсхүл хэрэв АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь нисгэгчид зориулсан ил харааны, эсхүл радио навигацыйн чиглэл дагах журмыг ашигладаг бол, максимум 600 м хүртэл.

(c) Энэ зүйлийн (b)-гийн зорилгоор, “D” гэж TODA-гийн төгсгөлөөс тухайн нисэх онгоц гүйх замын дагуух хэвтээ зайг ойлгоно.

(d) Энэ зүйлийн (a)-ийн дагуу хөөрөлтийн үеийн нислэгийн аюулгүй замыг тооцоолохдоо АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгана:

- (1) дараах хүчин зүйлийг тооцож үздэг байх:
 - (i) хөөрөлтийн гүйлт эхлэх үеийн хөөрөлтийн жин;
 - (ii) аэродромын өндөрлөг;
 - (iii) Олон улсын стандарт атмосферийн (ISA) даралтаас тухайн атмосферийн даралт нь 1%-иас их ялгаатай бол, тухайн аэродромын даралтын **өндрийн-түвшин**;
 - (iv) тухайн аэродромын орчны агаарын хэм;
 - (v) мэдээнд өгөгдсөн **урдаас-чиглэсэн** **үгтах** салхины бүрдэл хэсэг 50%-иас ихгүй, эсхүл **арын** **аас-чиглэсэн** салхины бүрдэл хэсэг 150%-иас багагүй байх.
- (2) хөөрөлтийн гадаргуугаас дээш 15 м-ийн (50 ft) өндөрт хүрэхээс өмнө 15° -аас хэтэрсэн чиглэлийн өөрчлөлтийг хийхгүй байх;
- (3) Дарга өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд:
 - (i) хөөрөлтийн гадаргуугаас дээш 15 м-ийн (50 ft) өндөр авахаас өмнө 15° -аас хэтэрсэн налуу өнцгөөр эргэлт хийхгүй байх;

- (ii) хөөрөлтийн гадаргуугаас дээш 120 м-ийн (400 ft) өндөр авах хүртэл 20°-аас хэтэрсэн налуу өнцгөөр эргэлт хийхгүй байх;
- (iii) хөөрөлтийн гадаргуугаас дээш 120 м-ээс (400 ft) дээш өндөрт 25°-аас хэтэрсэн налуу өнцгөөр эргэлт хийхгүй байх;
- (4) дараах зөвшөөрөгдөх хэмжээг тооцдог байх:
 - (i) үйл ажиллагааны хурд болон нислэгийн замд налуу өнцгийн эргэлтийн үзүүлэх нөлөө;
 - (ii) нэмэгдсэн нислэгийн хурднаас шалтгаалан зай нэмэгдэх;
 - (iii) 121.213-ын дагуу хурдны нуралтын (stall) нөөцийг хадгалах болон өндөр авалтын градиент алдах.
- (e) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах нөөц журмыг тогтооно:
 - (1) энэ Дүрмийн шаардлага хангах;
 - (2) саадыг тойрон аюулгүй нислэгийн замыг сонгох;
 - (3) 121.161-д шаардсан нисэх онгоц нисэн гарах аэродромд, эсхүл бэлтгэл аэродромд аюулгүй буулт үйлдэх боломжоор хангах.

121.213. Хөдөлгүүр ажиллагаагүй үеийн градиент болон хурдны нуралтыг засаж тооцох

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь өөр сонголт хийхийг зөвшөөрдөг техникийн өгөгдөл бэлэн байхаас бусад тохиолдолд 121.211(d)(4)(iii)-т нийцүүлэх зорилгоор, Хүснэгт 2-т заасан хүчин зүйлийг ашиглан хурдны нуралтын нөөцийг хадгалах болон өндөр авалтын градиентын алдагдлыг тооцоолно.

Хүснэгт 2.

Эргэлт хийх налуу өнцөг	Хурдны засвар	Градиентын засвар
15°-аас 19°	V_2	1 х Нисэх онгоцны нислэгийн заавар 15° градиент алдагдал
20°-аас 24°	$V_2 + 5$ кнот ($V_2 + 10$ км/цаг)	2 х Нисэх онгоцны нислэгийн заавар 15° градиент алдагдал
25°	$V_2 + 19$ кнот ($V_2 + 35$ км/цаг)	3 х Нисэх онгоцны нислэгийн заавар 15° градиент алдагдал

121.215. Нислэгийн замд эрсдэлтэй хөдөлгүүр ажиллагаагүй болох

- (a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагаандаа ашиглаж байгаа нисэх онгоцны хувьд, нислэгийн замд нэг хөдөлгүүр ажиллагаагүй болсон үеийн нислэгийн аюулгүй замын өгөгдлийг ашиглан дараах шаардлагыг бататгана:

- (1) энэ зүйлийн (b)-д өөрөөр зааснаас бусад тохиолдолд, тухайн нислэгийн зам нь хөдөлгүүр татгалзсаны дараа буулт үйлдэхээр тооцсон аэродромоос дээш 450 м-ийн (1500 ft) өндөрт, нисэхээр төлөвлөсөн нислэгийн чиглэлд 18.6 км-ийн (10 nm) дотор байгаа бүх газрын бартаа болон саадаас дээш 300 м-ээс (1000 ft) доошгүй **өндрийн**-түвшинд эерэг өндөр авах өнцөгтэй байх;
 - (2) энэ зүйлийн (b)-д өөрөөр зааснаас бусад тохиолдолд, нислэгийн аюулгүй зам нь төлөвлөсөн нислэгийн чиглэлд 18.6 км-ийн (10 nm) дотор босоогоор 600 м-ээс (2000 ft) доошгүй өндөрт байгаа бүх газрын бартаа болон саадаас чөлөөтэй байх;
 - (3) нислэгийн аюулгүй зам нь тухайн нисэх онгоцонд дараах нөхцөлийг тооцон, аяллын **өндрийн**-түвшнээс 121.221, эсхүл 121.223-ын аль хамаарах заалтын дагуу буулт үйлдэж чадах аэродром хүртэл нислэгээ үргэлжлүүлэх боломж олгодог байх:
 - (i) тухайн нислэгийн замын хамгийн эрсдэлтэй цэгт хөдөлгүүр татгалзах;
 - (ii) хэрэв цаг уурын нөхцөл нь түүнийг ажиллуулахыг шаарддаг бол, мөстөлтөөс хамгаалах системийн нөлөө;
 - (iii) урьдчилсан мэдээний орчны агаарын хэм;
 - (iv) нислэгийн замын дагуух салхины урьдчилсан мэдээний нөлөө;
 - (v) тухайн аэродромд нисэн хүрэх шаардлагад нийцсэн түлшний нөөцтэй байх зорилгоор түлш цацах;
 - (4) буулт үйлдэхээр тооцсон аэродромд хөдөлгүүр татгалзсаны дараа, дараах шалгуурыг хангасан байх:
 - (i) нислэгийн үзүүлэлт нь тухайн нисэх онгоцны баримжаат буултын жинд тохирч байх;
 - (ii) цаг агаарын мэдээ болон урьдчилсан мэдээ, эсхүл нэгдсэн мэдээ болон аэродромын нөхцөлийн мэдээ нь төлөвлөсөн буулт үйлдэх цагт аюулгүй буулт үйлдэх боломжтой болохыг харуулж байх.
- (b) Хэрэв нисгэгч нь радио навигацийн туслах төхөөрөмж ашиглан төлөвлөсөн нислэгийн чиглэлээ 9.3 км-ийн (5 nm) дотор хадгалах чадвартай бол энэ зүйлийн (a)(1), (2)-т шаардсан 18.6 км-ийн (10 nm) зайг 9.3 км (5 nm) хүртэл багасгаж болно.

121.217. Нислэгийн зам дагуух 90 минутын хязгаарлалт

- (a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагаандаа ашиглаж байгаа гурав, эсхүл түүнээс олон хөдөлгүүртэй нисэх онгоцыг баримжаат буултын жинд хамаатай, тухайн нисэх онгоцны нислэгийн зааварт заасан үзүүлэлтийн шаардлагад нийцсэн аэродромоос 90 минутаас холгүй зайд нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэдэг болохыг бататгана.
- (b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах нөхцөлийг хангасан бол гурав, эсхүл түүнээс олон хөдөлгүүртэй нисэх онгоцоор, баримжаат буултын жинд хамаатай, тухайн нисэх онгоцны нислэгийн зааварт заасан үзүүлэлтийн шаардлагад нийцсэн аэродромоос 90 минутаас хол зайд нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж болно:
- (1) нислэгийн замын дагуу хоёр хөдөлгүүр ажиллагаагүй үеийн тухайн нислэгийн замын өгөгдөл нь, таамаглаж байгаа цаг уурын нөхцөлд хоёр хөдөлгүүр зэрэг татгалзана гэж тооцсон цэгээс хоёр хөдөлгүүр ажиллагаагүйгээр буулт

- үйлдэхийг заасан журмыг ашиглан тухайн нисэх онгоц буулт үйлдэх боломжтой аэродром руу нислэгээ үргэлжлүүлэхийг зөвшөөрдөг байх;
- (2) хэрэв энэ зүйлийн (с)-д зааснаас бусад тохиолдолд, цаг уурын нөхцөл нь тэдний үйл ажиллагаа нь нисэхээр төлөвлөсөн нислэгийн чиглэлд 18.6 км-ийн (10 nm) дотор байгаа бүх газрын бартаа болон саадаас дээш 600 м-ээс (2000 ft) доошгүй өндөрт давах эерэг өндөр авах өнцөгтэй байхыг шаарддаг бол, нислэгийн аюулгүй замыг сонгохдоо мөстөлтөөс хамгаалах системийн нөлөөг тооцдог байх;
- (3) нислэгийн аюулгүй зам нь хоёр хөдөлгүүр татгалзсаны дараа, буулт үйлдэхээр тооцсон аэродромоос дээш 450 м-ийн (1500 ft) өндөрт эерэг өндөр авах өнцөгтэй байх;
- (4) хоёр хөдөлгүүр татгалзана гэж үзсэн цэгт тухайн нисэх онгоцны баримжаат жин нь, 450 м-ээс (1500 ft) доошгүй өндөрт тухайн аэродромын чанх дээр нисэн хүрсний дараа түвшнээ хадгалан 15 минут нисэн буулт үйлдэхээр тооцсон аэродромд хүрэх хангалттай түлшийг багтаасан жингээс багагүй байх.

(с) Хэрэв нисгэгч нь радио навигацийн туслах төхөөрөмж ашиглан төлөвлөсөн нислэгийн чиглэлээ 9.3 км-ийн (5 nm) дотор хадгалах чадвартай бол энэ зүйлийн (b)(2)-т шаардсан 18.6 км-ийн (10 nm) зайг 9.3 км (5 nm) хүртэл багасгаж болно.

(d) Энэ зүйлийн (b)-д нийцэж байгааг тооцоолохдоо АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь, тухайн нисэх онгоц баримжаат буултын жинд хамааралтай үзүүлэлтийн шаардлагад нийцсэн аэродромоос 90 минутаас хол зайд, стандарт агаарын хэм болон тогтуун агаарт бүх хөдөлгүүр алсын зайн аяллын нислэгийн хурдтай ажиллаж байх үед тухайн нислэгийн замын хэсгийн хамгийн эрсдэлтэй цэг дээр хоёр хөдөлгүүр татгалзана гэж тооцно.

121.219. Нисэн очих болон бэлтгэл аэродромд буултын үед өндөр авах

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагаандаа ашиглаж байгаа нисэх онгоцны хувьд дараах шаардлагыг бататгана:

- (1) нисэн очих болон бэлтгэл аэродромд буулт үйлдэх тооцоот цагт гадна орчны баримжаат агаарын хэм болон **эндрийн** түвшнийг тооцон, тухайн нисэх онгоцны буултын жин (landing weight) нь максимум ойртолтын жин (approach weight) болон буултын үед өндөр авах жингээс (landing-climb weight) хэтрэхгүй байх;
- (2) 60 м-ээс (200 ft) доош шийдвэр гаргах өндөрт хэрэглэлээр ойртолт үйлдэхэд хөөрөлтийн жин болон нислэгт зарцуулдаг баримжаат түлшийг тооцсон нисэх онгоцны ойртолтын жин нь, ойртолтын конфигурацид эрсдэлтэй хөдөлгүүрийг ажиллагаагүй гэж үзэн дараах, ойртолтоос 2-т гарах өндөр авалтын аюулгүй градиенттай нийцсэн байх:
- (i) 2.5%-иас доошгүй; эсхүл
- (ii) 121.211-ийн дагуу ойртолтоос 2-т гарах нислэгийн замын саадаас чөлөөтэй байх шаардлагатай өндөр авалтын аюулгүй градиентаас доошгүй.

121.221. ХБЗ-ны буултын зай

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагаандаа ашиглаж байгаа нисэх онгоцны буулт үйлдэх тооцоот цагийн буултын жинг тухайн нисэх онгоцны нислэгийн зааварт заасан буултын жингээс хэтрэхгүй байгааг бататгах үүрэгтэй.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь, тухайн ХБЗ дээр нисэх онгоцны буултын зайг тооцоолохдоо дараах журмыг ашиглах үүрэгтэй:

- (1) энэ зүйлийн (c)-гийн дагуу баталсан; эсхүл
- (2) Хавсралт D-д заасан.

(c) Дарга дараах нөхцөлийг тооцон үзсэний дараа хэрэв хангалттай гэж үзвэл, энэ зүйлийн (b)(1)-д заасан журамтай холбоотой, АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийн гаргасан хүсэлтийг зөвшөөрч болно:

- (1) санал болгосон тухайн нисэх онгоцонд нисгэгч, эсхүл нисэх баг ашиглах боломжтой, үйлдвэрлэгчийн хангасан журмын дагуу гаргасан техникийн өгөгдөл байгаа эсэх;
- (2) тухайн үйл ажиллагаа эрхлэгчид, дараах аль нэг мэдээллийг авч ашиглах найдвартай нэвтрэх эрх байгаа эсэх:
 - (i) ашиглахаар зөвшөөрөгдсөн журамд хамаарах ХБЗ-ны нөхцөлийн талаарх тухайн цаг хугацаанд тохирсон үнэн зөв тайлан мэдээ; эсхүл
 - (ii) үйл ажиллагаа эрхлэгч дүйцэх нөхцөлийг таньж тогтооход туслах өгөгдөл;
- (3) дараах нөхцөлийг тооцож үзэх ёстой зөвшөөрөгдсөн журмыг ашиглан буултын зайг тооцоолохдоо хэрэглэх алдааны нөөц хязгаар:
 - (i) буултын зайд нисгэгчийн ур чадварын үзүүлэх нөлөө;
 - (ii) нисэн очих аэродромын хүрээлэн буй орчны гэнэтийн нөхцөлийн нөлөө;
 - (iii) тооцоог нислэгт гаргах шатанд, эсхүл нислэгийн замд хийсэн эсэх;
 - (iv) алдааны нөөц хязгаар нь ХБЗ-ны нөхцөлийн мэдээнд тулгуурласан эсэх;
- (4) ХБЗ-ны нөхцөлийг мэдээлэх, өгөгдлийг тооцоолох болон нислэгийн үйл ажиллагаанд оролцдог ажилтнууд нь тухайн журмыг ашиглах холбогдох сургалтад хамрагдсан эсэх.

121.223. [Хүчингүй болсон]**121.225. Огцом ойртолт болон богино зайд буулт үйлдэх арга техник**

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд, 4.5°, эсхүл түүнээс илүү ойртолтын гулгах өнцгөөр, 15 м-ээс (50 ft) доош гэхдээ 10.5 м-ээс (35 ft) дээш **бөөгн заасан** өндөртэйгээр **(screen height) орох** огцом ойртолтын журмыг ашиглаж болно, хэрэв:

- (1) тухайн нисэх онгоцны нислэгийн зааварт огцом ойртолт үйлдэх онцгой нөхцөлийн журам, мөн огцом ойртолт үйлдэх шалгуурыг ашиглах үеийн газардах талбайн уртын өгөгдлийн нэмэлт өөрчлөлтийг багтаасан, максимум зөвшөөрөгдсөн ойртолтын гулгах өнцөг, бусад хязгаарлалт болон журмыг заасан бол;

- (2) IFR-ийн дагуу гүйцэтгэж байгаа арилжааны нислэгийн үйл ажиллагааны хувьд **огцом ойртолтын журмыг ашиглахаар төлөвлөсөн аэродромын ХБЗ-д VASIS, эсхүл түүнээс илүү системээс бүрдсэн ойртолтын налуу заагч систем** бэлэн байгаа бол;
- (3) IFR-ийн дагуу гүйцэтгэж байгаа арилжааны нислэгийн үйл ажиллагааны хувьд, огцом ойртолт үйлдэх ХБЗ-ны цаг агаарын минимал заасан бөгөөд зөвшөөрсөн бол;
- (4) IFR-ийн дагуу гүйцэтгэж байгаа арилжааны нислэгийн үйл ажиллагааны хувьд, дараах үзүүлэлтийг анхаарч үзсэн бол:
 - (i) саад;
 - (ii) ойртолтын налуу заагчийн төрөл болон ил харааны туслах хэрэгсэл MLS, GPS, ILS, LOC, VOR, эсхүл NDB зэрэг ХБЗ-ны чиглүүлэгч;
 - (iii) DH болон MDA-д шаардлагатай минимум ил харааны баримжаат цэг;
 - (iv) ашиглаж болох нислэгийн төхөөрөмж;
 - (v) нисгэгчийн мэргэшил болон аэродромын тусгай шаардлага;
 - (vi) тухайн нисэх онгоцны нислэгийн зааварт заасан хязгаарлалт болон журам;
 - (vii) ойртолтоос 2-т гарах шалгуур.

Е Бүлэг - Жин ба төвлөрөлт

121.301. Зорилго

Энэ Бүлэг нь нисэх онгоцны ачаалалтын хяналт болон жин ба төвлөрөлтийн зохицуулалтын шаардлагыг тогтооно.

121.303. Бараа, зорчигч болон тээшний жин

(a) Энэ зүйлийн (b), (c) болон (d)-г харгалзан, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд гүйцэтгэж байгаа арилжааны нислэгийн үйл ажиллагааны хувьд, нисэх онгоцонд тээвэрлэдэг дараах эд зүйлийн жинг тогтоосон болохыг бататгах үүрэгтэй:

- (1) барааны нийт бодит жин (тээш ороогүй);
- (2) зорчигчид болон тэдний гар тээшний нийт жин;
- (3) багийн гишүүд болон тэдний гар тээшний нийт жин;
- (4) үзлэг хийгдсэн тээшний нийт жин.

(b) Зорчигчид болон тэдний гар тээшний нийт жинг дараах нөхцөлийн зөвхөн нэгийг нь ашиглан тогтоосон байх ёстой:

- (1) зорчигч, түүний гар тээш нэг бүрийн бодит жин;
- (2) гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт заасан, гэрчилгээ эзэмшигчийн тогтоосон зорчигч, түүний гар тээш нэг бүрийн стандарт жин;
- (3) зорчигч, түүний гар тээш нэг бүрийн дараах стандарт жин:
 - (i) 2-оос доош насны хүүхэд - 15 кг;
 - (ii) 2-13 насны хүүхэд - 46 кг;
 - (iii) 13-аас дээш насны хүн - 86 кг.

(с) Багийн гишүүн болон тэдний гар тээшний нийт жинг дараах нөхцөлийн зөвхөн нэгийг нь ашиглан тогтоосон байх ёстой:

- (1) багийн гишүүн, түүний гар тээш нэг бүрийн бодит жин;
- (2) гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт заасан, гэрчилгээ эзэмшигчийн тогтоосон багийн гишүүн, түүний гар тээш нэг бүрийн стандарт жин;
- (3) багийн гишүүн, түүний гар тээш нэг бүрийн стандарт жин - 86 кг.

(d) Үзлэг хийгдсэн тээшний жинг дараах нөхцөлийг ашиглан тогтоосон байх ёстой:

- (1) тухайн тээшний бодит жин; эсхүл
- (2) Монгол Улсын гаднаас эхлэлтэй олон улсын нислэгийн хувьд, бодит жинг тодорхойлох боломжгүй тохиолдолд, гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт заасан, гэрчилгээ эзэмшигчийн тогтоосон стандарт жин.

(e) Энэ зүйлийн (b)(2), (c)(2), эсхүл (d)(2)-т заасан нөхцөлийг ашиглах зорилгоор гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт заасан байх шаардлагатай стандарт жинг тогтоохоор төлөвлөж байгаа АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц судалгааны хөтөлбөрийн дагуу холбогдох стандарт жинг тогтоосон байх үүрэгтэй.

(f) Энэ зүйлийн (b)(2), эсхүл (b)(3)-ын дагуу зорчигчдын, эсхүл (c)(2), эсхүл (c)(3)-ын дагуу багийн гишүүдийн стандарт жинг ашиглахаар төлөвлөж байгаа АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь хэрэв гар тээштэй зорчигч, эсхүл багийн гишүүний жин нь ашиглаж байгаа холбогдох стандарт жингээс илүү болох нь тодорхой байгаа бол тухайн этгээд, түүний гар тээшний бодит жингийн аль илүү хамааралтай жинг ашигладаг болохыг бататгах, Даргын хүлээн зөвшөөрөхүйц журмыг тогтоосон байх үүрэгтэй.

121.305. Нисэх онгоцны ачааллын хязгаарлалт

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгах үүрэгтэй:

- (1) нисэх онгоцны жин ба төвлөрөлттэй холбоотой тухайн нисэх онгоцны нислэгийн заавар, эсхүл бусад батлагдсан баримт бичигт заасан хязгаарлалтыг дагаж мөрдөх;
- (2) түлшгүй (zero fuel), маневрын, хөөрөлтийн болон буултын жин тус бүр нь зөвшөөрөгдсөн максимум жингээсээ хэтрэхгүй байх;
- (3) тухайн нисэх онгоцны хүндийн төв нь нисэн гарах үед энэ хэсгийн (1)-д заасан хязгаарын хүрээнд байх ба арилжааны нислэгийн үйл ажиллагааны туршид тухайн хязгаарын хүрээнд хадгалагдаж байх.

121.307. Ачааллын манифест

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгах үүрэгтэй:

- (1) арилжааны нислэгийн үйл ажиллагааны өмнө ачааллын манифестийг бүрэн гүйцэд бөглөсөн байх;
- (2) тухайн ачааллын манифестийг хөлгийн дарга баталдаг байх;
- (3) тухайн ачааллын манифест нь дараах дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан байх:
 - (i) хөлгийн даргын нэр;
 - (ii) үйл ажиллагаа гүйцэтгэх огноо;

- (iii) нисэх онгоцны маяг, бүртгэлийн дугаар;
- (iv) нисэн гарах болон нисэн очих аэродромын нэр, эсхүл таних код;
- (v) нислэгийн дугаар, эсхүл нисэн гарах тооцоот цаг;
- (vi) гэрчилгээ эзэмшигчийн өөр баримт бичигт заагдаагүй бол, багийн гишүүд болон зорчигчдын овог, нэр;
- (vii) нисэх онгоцны хоосон жин, салгаж болох төхөөрөмжийн жин, зарцуулах материалын жин болон багийн гишүүдийн жин;
- (viii) зорчигчид болон тэдний гар тээшний нийт жин, барааны нийт жин, үзлэг хийгдсэн тээшний нийт жин болон хэрэглэх боломжит түлшний нийт жин;
- (ix) тухайн нисэх онгоцны хөөрөлтийн жин;
- (x) гэрчилгээ эзэмшигч өөр баримт бичигт тэмдэглэдэг байхаас бусад тохиолдолд, нисэх онгоцны хүндийн төв нь тухайн нисэх онгоцны нислэгийн зааварт заасан хязгаарын хүрээнд байгааг нотлох баримт;
- (xi) түлшгүй жин, хөөрөлтийн болон буултын жинг багтаасан үйл ажиллагааны зөвшөөрөгдөх максимум жин;
- (xii) 121.303(f)-ийн дагуу тохируулга хийсэн нийт жин.

F Бүлэг - Хэрэглэл болон төхөөрөмж

121.351. Зорилго

Энэ Бүлэг нь нисэх онгоцонд шаардлагатай хэрэглэл болон төхөөрөмжийн шаардлагыг тогтооно.

121.353. Ерөнхий зүйл

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангаагүй бол агаарын тээврийн үйл ажиллагааг эхлүүлдэггүй болохыг бататгах үүрэгтэй:

- (1) нисэх онгоц нь дараах төхөөрөмжөөр тоноглогдсон байх:
 - (i) ИНД-91 F Бүлэг болон энэ Бүлэгт шаардсан төрлийн хэрэглэл болон төхөөрөмж;
 - (ii) 2008 оны 7 сарын 1-нээс хойш НТЧ-ын гэрчилгээ анх олгосон Монгол Улсаас, эсхүл Монгол Улс руу болон Монгол Улсын гадна тогтмол агаарын тээврийн үйлчилгээнд ашиглаж байгаа нисэх онгоцны хувьд:
 - (A) 3 ELT, үүнээс нэг нь ELT(AF) байх ёстой; эсхүл
 - (B) 2-оос доошгүй ELT - аюул тулгарсан үед үйл ажиллагаа эрхлэгч байршлыг тогтоох боломжтой мэдээллийг минут тутамд 1-ээс доошгүй удаа автоматаар дамжуулах чадвартай;

- (iii) холбооны, эсхүл навигацийн, эсхүл аль аль зорилгод шаардлагатай бие даасан системийн татгалзал нь нисэж байгаа нислэгийн замд холбоо барих болон нислэгийг аюулгүй үйлдэх чадваргүй болоход нөлөөлөхгүй болохыг бататгах тооны хэрэглэл болон төхөөрөмж;
 - (2) тухайн нисэх онгоцонд суурилуулсан хэрэглэл болон төхөөрөмж нь дараах шаардлагыг хангасан байх:
 - (i) дараах баримт бичигт заасан тодорхойлолт болон НТЧ-ын загварын стандарт:
 - (А) энэ Дүрмийн Хавсралт В;
 - (В) ИНД-21 Хавсралт С;
 - (С) ИНД-26; эсхүл
 - (ii) Даргын хүлээн зөвшөөрөхүйц, өөр орлох тодорхойлолт болон загварын стандарт;
 - (3) тухайн нисэх онгоц үйлдвэрлэгчийн зааварчилгаа, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц бусад зааварчилгааны дагуу суурилуулсан хэрэглэл болон төхөөрөмж;
 - (4) тухайн нисэх онгоцонд ашигладаг ИНД-91.539-ийн дагуу зөвшөөрөгдсөн MEL-д заасан байж болохоос бусад тохиолдолд, нисэх онгоцонд суурилуулсан хэрэглэл болон төхөөрөмж нь ажиллагаатай байх.
- (aa) Энэ зүйлийн (a)(1)(ii)-т заасан ELT нь ИНД-91 Хавсралт А.15-д заасан холбогдох стандартыг хангасан байх ёстой.
- (b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийг дараах тохиолдолд, ИНД-91.529(a)-д шаардсан AELS-ээр нисэх онгоцоо тоноглосон байхыг шаардахгүй, хэрэв:
- (1) тухайн нисэх онгоцны НТЧ-ын гэрчилгээг анх 2008 оны 7 сарын 1-нээс өмнө олгосон бол;
 - (2) тухайн нисэх онгоцыг Монгол Улсаас, эсхүл Монгол Улс руу болон Монгол Улсын гадна тогтмол агаарын тээврийн үйлчилгээнд ашиглаж байгаа бол;
 - (3) тухайн нисэх онгоцыг ИНД-91.529(a)-д шаардсан AELS-ийн оронд ИНД-91 Хавсралт А.15-д заасан ELT-д тавих шаардлагыг хангасан хоёр ELT-ээр тоноглосон бол.

121.355. Нэмэлт хэрэглэл

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь нисэх онгоц бүрийг дараах хэрэглэлээр тоноглосон болохыг бататгана:

- (1) ИНД-21 Хавсралт С (a)(1)(ii)-т заасан НТЧ-ын загварын стандартаар шаардсан, хүчний төхөөрөмжийн заах хэрэглэл;
- (2) сэнсний алганы өнцгөөр, эсхүл түүнтэй шууд холбоотой ажилладаг реверс алхамтай сэнсний хувьд, тухайн сэнс нь бета алхам, эсхүл реверс алхамд байгааг заах хэрэглэл.

121.357. Нэмэлт төхөөрөмж

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцыг дараах төхөөрөмжөөр тоногдсон болохыг бататгах үүрэгтэй:

- (1) нисгэгчийн бүхээгийн шил арчигч, эсхүл түүнтэй дүйцэх төхөөрөмж;
- (2) аливаа этгээд хөлгийн даргын зөвшөөрөлгүйгээр онгойлгохоос сэргийлдэг түгжих хэрэгсэлтэй нисэх багийн бүхээгийг зорчигчийн бүхээгээс тусгаарласан хаалга;
- (3) ослын гарцтай нисэх багийн бүхээгээс бусад, зорчигчийн бүхээгийг өөр бүхээгээс тусгаарладаг хаалганы хувьд:
 - (i) багийн гишүүд ашиглахад бэлэн түлхүүртэй байх;
 - (ii) тухайн хаалга хөөрөлт болон буулт үйлдэх үед нээлттэй байх ёстойг харуулсан зурагт хуудастай байх.

(b) Зорчигч тээвэрлэн агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан болохыг бататгах үүрэгтэй:

- (1) энэ зүйлийн (a)(2)-т шаардсан хаалга нь:
 - (i) 2009 оны 5 сарын 15-наас хүчинтэй болсон АНУ-ын холбооны дүрмийн эмхэтгэл 14-ийн §25.795(a)(1), (2) болон (3)-т заасан шаардлагыг хангасан байх;
 - (ii) аль ч нисгэгчийн суудлаас онгойлгодог ба түгждэг байх;
- (2) нисэх багийн бүхээгт орох гэж байгаа этгээдийг таних, эсхүл сэжигтэй нөхцөл байдал, эсхүл болзошгүй аюул, заналхийллийг илрүүлэх зорилгоор нисэх багийн бүхээгийн гадна орчныг хянах хэрэгслээр хангасан байх.

(c) Хамааралгүй

(d) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь нисэх багийн гишүүний суудлаас ажилладаг, бүхээгийн ажилтан болон нисэх багийн гишүүдийн хооронд харилцах нууц дохио ашиглан, тогтоосон аргаар холбогдох анхааруулах, эсхүл бататгах харилцаа холбооны тогтолцоотой болохыг бататгах үүрэгтэй.

121.359. Шөнийн нислэг

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь шөнөөр нислэгийн үйл ажиллагаанд ашигладаг нисэх онгоцоо дараах төхөөрөмжөөр тоногдсон болохыг бататгах үүрэгтэй **на**:

- (1) **хоёр** буултын гэрэл;
- (2) зорчигчийн бүхээгийн гэрэл.

121.361. Хэрэглэлийн нислэгийн дүрэм (IFR)

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд IFR-ийн дагуу үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцыг дараах төхөөрөмжөөр тоногдсон болохыг бататгах үүрэгтэй:

- (1) ИНД-91 F Бүлэгт шаардсан хэрэглэл болон төхөөрөмжөөс үл хамаарах, заавал нэмэх шаардлагатай дараах хэрэглэл:

- (i) чийг хуримтлагдах, эсхүл мөстөлт үүсэхээс шалтгаалан буруу ажиллагаас хамгаалагдсан, хурдыг кнот-оор (kts) хэмждэг агаарын хурдыг заах;
 - (ii) даралтаар илэрхийлдэг өндрийн-түвшнийг футээр (ft) хэмждэг заах;
- (2) нисэх багийн бүхээгийн хэрэглэлийн гэрэлтүүлгийн нөөц гэрэл;
 - (3) нөөц гал хамгаалагч.

(b) Энэ зүйлийн (a)(1)(i)-д шаардсан агаарын хурдыг заах нэмэлт хэрэглэлийн оронд ИНД-91 F Бүлэгт шаардсан байрлал заах хэрэгслэлийн цахилгаан эх үүсвэрээс тусдаа өөр цахилгааны эх үүсвэрээр тэжээгддэг, нисэх онгоцны байрлал заах нэмэлт хэрэглэл суурилуулж болно.

121.363. Усан дээгүүрх нислэг

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь усан дээгүүрх үргэлжилсэн нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэдэг гэрчилгээ эзэмшигчийн нисэх онгоцыг, хамгийн их тооцоолсон багтаамжтай нэг завиа алдсан тохиолдолд, тухайн нисэх онгоцны бүхээгт байгаа бүх хүнийг багтаах, хөвөх болон хэт ачаалал даах чадвартай хангалттай тооны аврах завиар тоногдсон болохыг бататгах үүрэгтэй.

121.365. Ослын төхөөрөмж

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараахаас бусад тохиолдолд, нисэх онгоцыг тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхэд ашигладаггүй болохыг бататгах үүрэгтэй:

- (1) тухайн нисэх онгоцыг ИНД-91.523(a) болон (b)-д заасан суудлын хуваарилалтыг үл харгалзан, ИНД-91.523-ын шаардлагын дагуу тоногдсон байх;
- (2) энэ зүйлийн (a)(1)-д шаардсан төхөөрөмж нь ИНД-91.523(d) болон (e)-гийн шаардлагыг хангасан байх.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь 120 минутаас дээш хугацаагаар нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэдэг нисэх онгоц бүрийг гэмтэл болон эмнэлгийн яаралтай тусламж үзүүлдэг эд зүйлийг багтаасан, мэргэшсэн эмнэлгийн ажилтан хэрэглэхэд тохиромжтой түргэн тусламжийн эмнэлгийн иж бүрдлээр тоногдсон болохыг бататгана.

121.367. Амьсгал хамгаалах төхөөрөмж (PBE)

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцыг дараах шаардлага хангасан амьсгал хамгаалах төхөөрөмжөөр тоногдсон болохыг бататгах үүрэгтэй:

- (1) дараах этгээд авч хэрэглэхэд тохиромжтой байдлаар байрлуулсан байх;
 - (i) үндсэн суудаг байрлалд байгаа нисэх багийн гишүүн;
 - (ii) багийн гишүүн;
- (2) дараах байрлалд суурилуулсан байх:
 - (i) нисэх багийн бүхээгт;

- (ii) зорчигчдын бүхээг бүрд гар-гал унтраагуураас 1 м-ийн дотор, эсхүл гал унтраагуураас Даргын хүлээн зөвшөөрөхүйц зайд;
 - (iii) гар-гал унтраагуур агуулсан гал тогооны шүүгээнд;
- (3) Ангилал-А, В болон Е ачааны бүхээгийн гадна талд, багийн гишүүд авч ашиглахад боломжтой байх.

121.369. Зарлан мэдээлэх болон багийн гишүүдийн дотоод холбооны систем

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь нисэх онгоц бүрийг дараах төхөөрөмжөөр тоноглон болохыг бататгах үүрэгтэй:

- (1) зарлан мэдээлэх систем;
- (2) багийн гишүүдийн дотоод холбооны систем.

121.371. Бүхээгийн дуу чимээ бичигч (CVR)

~~АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь нисэх онгоц бүрийг CVR-аар тоноглон болохыг бататгах үүрэгтэй.~~

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн нисэх онгоцыг Хавсралт В.5-д заасан CVR-аар тоноглон болохыг бататгах үүрэгтэй.

(b) Энэ зүйлийн (a)-г үл харгалзан, 2021 оны 02 сарын 04-ний ИНД-121-ийн нэмэлт, өөрчлөлт 10-ын Хавсралт В.5-д заасан шаардлагыг 2022 оны 12 сарын 31-нээс өмнө хангасан CVR-аар тоноглон нисэх онгоцыг 2023 оны 12 сарын 31 хүртэл Хавсралт В.5-д заасан шаардлагыг хангасанд тооцно.

(c) Энэ зүйлийн (b) заалт нь 2023 оны 12 сарын 31-нд хүчингүй болно.

121.373. Нислэгийн өгөгдөл бичигч (FDR)

~~АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь нисэх онгоц бүрийг FDR-аар тоноглон болохыг бататгах үүрэгтэй.~~

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн нисэх онгоцыг Хавсралт В.6-д заасан FDR-аар тоноглон болохыг бататгах үүрэгтэй.

(b) Энэ зүйлийн (a)-г үл харгалзан, 2021 оны 02 сарын 04-ний ИНД-121-ийн нэмэлт, өөрчлөлт 10-ын Хавсралт В.6-д заасан шаардлагыг 2022 оны 12 сарын 31-нээс өмнө хангасан FDR-аар тоноглон нисэх онгоцыг 2023 оны 12 сарын 31 хүртэл Хавсралт В.6-д заасан шаардлагыг хангасанд тооцно.

(c) Энэ зүйлийн (b) заалт нь 2023 оны 12 сарын 31-нд хүчингүй болно.

121.375. Нэмэлт байрлал заах хэрэгслэл (Additional attitude indicator)

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь турбо-фэн, эсхүл турбо-жэт хөдөлгүүртэй нисэх онгоц бүрийг гуравдагч байрлал заах хэрэгслэлээр тоноглон болохыг бататгана.

121.377. Цаг агаарын радар

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь IFR-ийн дагуу нислэгийн үйл ажиллагаанд ашигладаг турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоцыг цаг агаарын радараар тоногосон болохыг бататгана.

121.379. Газар ойртсоныг анхааруулах систем (GPWS)

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоцыг GPWS-ээр тоногосон болохыг бататгах үүрэгтэй.

(b) Хэрэв тухайн нисэх онгоцыг А ангиллын TAWS-аар тоногосон бол, АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийг энэ зүйлийн (a)-г мөрдөхийг шаардахгүй.

121.381. Газар мэдрэх ба анхааруулах систем (TAWS)

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь 2002 оны 4 сарын 1-нээс хойш үйлдвэрлэсэн, тухайн гэрчилгээний дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоцыг А ангиллын TAWS-аар тоногосон болохыг бататгах үүрэгтэй.

(b) Энэ зүйлийн (c)-д зааснаас бусад тохиолдолд, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь 2002 оны 4 сарын 1-нээс өмнө үйлдвэрлэсэн, тухайн гэрчилгээний дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоцыг 2005 оны 7 сарын 1-ний дотор А ангиллын TAWS-аар тоногосон болохыг бататгах үүрэгтэй.

(c) АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийг дараах тохиолдолд, 2002 оны 4 сарын 1-нээс өмнө үйлдвэрлэсэн турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоцыг 2007 оны 1 сарын 1 хүртэл А ангиллын TAWS-аар тоноглохыг шаардахгүй, хэрэв:

- (1) тухайн нисэх онгоц нь 40, эсхүл түүнээс цөөн зорчигчийн суудлын конфигурацитай бол;
- (2) тухайн нисэх онгоцны 47.55(b)-д заасан дэлгэрэнгүй мэдээлэл нь 2003 оны 8 сарын 1-нээс өмнө Монгол Улсын агаарын хөлгийн бүртгэлийн системд орсон бол;
- (3) тухайн нисэх онгоц нь 2005 оны 4 сарын 1-нээс өмнө тухайн гэрчилгээний хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бол;
- (4) 2005 оны 4 сарын 1-нээс өмнө А ангиллын TAWS-ийн шаардлагыг 2007 оны 1 сарын 1-нээс өмнө биелүүлнэ гэж бататгасан гэрчилгээ эзэмшигчийн баталсан төлөвлөгөөг Даргад бичгээр хүргүүлсэн бол;
- (5) 2005 оны 7 сарын 1-нээс хойш тухайн нисэх онгоцны нислэгийн үйл ажиллагааг Даргын хүлээн зөвшөөрөхүйц, газартай мөргөлдөх эрсдэлийн үнэлгээ болон эрсдэлийг бууруулах хөтөлбөрийн дагуу гүйцэтгэж байгаа бол.

(d) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа поршинт-хөдөлгүүртэй нисэх онгоцыг 2007 оны 1 сарын 1-ний дотор В ангиллын TAWS-аар тоногосон болохыг бататгах үүрэгтэй.

121.383. Агаарт мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх систем (ACAS II)

(a) Энэ зүйлийн (b) болон (c)-д зааснаас бусад тохиолдолд, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний дагуу үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцыг ACAS II-оор тоногловсон болохыг бататгах үүрэгтэй.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийг дараах тохиолдолд, тухайн нисэх онгоцыг ACAS II-оор тоноглохыг шаардахгүй, хэрэв:

- (1) тухайн нисэх онгоцны 47.55(b)-д заасан дэлгэрэнгүй мэдээлэл нь 2003 оны 8 сарын 1-нээс өмнө Монгол Улсын агаарын хөлгийн бүртгэлийн системд орсон бол, 2005 оны 1 сарын 1 хүртэл; эсхүл
- (2) 2007 оны 1 сарын 1 хүртэл, дараах тохиолдолд, хэрэв:
 - (i) тухайн нисэх онгоц нь 40, эсхүл түүнээс цөөн зорчигчийн суудлын конфигурацитай бол;
 - (ii) тухайн нисэх онгоцны 47.55(b)-д заасан дэлгэрэнгүй мэдээлэл нь 2003 оны 8 сарын 1-нээс өмнө Монгол Улсын агаарын хөлгийн бүртгэлийн системд орсон бол;
 - (iii) тухайн нисэх онгоц нь 2004 оны 10 сарын 1-нээс өмнө тухайн гэрчилгээний дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бол;
 - (iv) 2007 оны 1 сарын 1-нээс өмнө ACAS II-ын шаардлагыг 2007 оны 1 сарын 1-нээс өмнө биелүүлнэ гэж бататгасан гэрчилгээ эзэмшигчийн баталсан төлөвлөгөөг Даргад бичгээр хүргүүлсэн бол;
 - (v) 2005 оны 1 сарын 1-нээс хойших тухайн нисэх онгоцны үйл ажиллагааг Даргын хүлээн зөвшөөрөхүйц агаарт мөргөлдөх эрсдэлийн үнэлгээ болон эрсдэлийг бууруулах хөтөлбөрийн дагуу гүйцэтгэж байгаа бол.

Г Бүлэг - Техник үйлчилгээ**121.401. Зорилго**

Энэ Бүлэг нь энэ Дүрмийн дагуу нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны техник үйлчилгээнд тавих шаардлагыг тогтооно.

121.403. НТЧ-ын хариуцлага

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах НТЧ-ын хариуцлага хүлээнэ:

- (1) тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа нисэх онгоцны;
- (2) тухайн нисэх онгоцонд суурилуулсан, эсхүл бэхэлсэн төхөөрөмжийн.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлага хангасан болохыг бататгах үүрэгтэй:

- (1) тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа нисэх онгоцонд ИНД-119.63-т шаардсан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу техник үйлчилгээ хийдэг байх;
- (2) энэ техник үйлчилгээг дараах байгууллага гүйцэтгэдэг болохыг:
 - (i) ИНД-145-ын дагуу гэрчилгээжсэн техник үйлчилгээний байгууллага; эсхүл

- (ii) техникийн зохицуулалтын гэрээний дагуу өөр Улсад гүйцэтгэх техник үйлчилгээний хувьд, тухайн агаарын хөлгийн маягт техникийн зохицуулалтын гэрээнд заасан нөхцөлийн дагуу техник үйлчилгээ гүйцэтгэхээр тухайн Улсын эрх бүхий байгууллагаар гэрчилгээжсэн, эсхүл зохих ёсоор зөвшөөрөгдсөн техник үйлчилгээний байгууллага.

121.405. Нөхцөлөөр хянах техник үйлчилгээний хөтөлбөр

Тухайн нисэх онгоцны техник үйлчилгээний хөтөлбөрт нөхцөлөөр хянах техник үйлчилгээ ашигладаг АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан техник үйлчилгээний найдвартай ажиллагааны тайланг Даргад сар тутам хүргүүлэх үүрэгтэй:

- (1) нисэх онгоцны ашиглалт;
- (2) нисэх онгоцны НТЧ-тай холбоотой нисгэгчийн мэдээллийн хуудас;
- (3) нисэх онгоцны техникийн саатал болон нислэгийн цуцлалт;
- (4) агаарт хуваарьт бус хөдөлгүүр унтарсан;
- (5) хуваарьт бус хөдөлгүүр солилт;
- (6) хуваарьт бус бүрдэл хэсгийн солилт;
- (7) тогтоогдсон бүрдэл хэсгийн татгалзал;
- (8) нисэх онгоцны НТЧ-тай холбоотой зөрчил;
- (9) MEL ашиглалт.

121.407. EDTO нислэгийн техник үйлчилгээний элемент

(a) Энэ зүйлийн (b), (c), (d) болон (e)-г харгалзан, 2 турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоцоор EDTO нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх зөвшөөрөлтэй АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь EDTO нислэгт ашиглахыг зөвшөөрсөн нисэх онгоцны хувьд, ИНД-119.63-т шаардсан техник үйлчилгээний хөтөлбөрт дараах шаардлага багтсан болохыг бататгах үүрэгтэй:

- (1) СМР-д, эсхүл хүчилсэн бүтэц болон хөдөлгүүрийн хослолын маягийн загварын баримт бичигт заасан үзлэг шалгалт болон техник үйлчилгээний шаардлага;
- (2) нисэх онгоц тухайн EDTO нислэгт гарахын өмнө гүйцэтгэсэн байх ёстой дараах EDTO нислэгт нисэн гарахын өмнөх техник үйлчилгээний шалгалт:
 - (i) EDTO нислэгт нөлөөлөх системийг багтаасан тухайн нисэх онгоцны ажиллагаатай байдлыг бататгах;
 - (ii) үндсэн хөдөлгүүрийн болон АPU-гийн тосны түвшин нь хүлээн зөвшөөрөхүйц хязгаарын хүрээнд байгааг бататгах, хэрэв АPU нь EDTO нислэгт шаардлагатай бол;
- (3) EDTO нислэгт нөлөөлөх системд хуваарьт байдлаар гүйцэтгэх шаардлагатай техник үйлчилгээний ажлын хуваарь;
- (4) EDTO нислэгт нөлөөлөх системд техник үйлчилгээ гүйцэтгэх журам;
- (5) ~~хэд хэдэн ижил төстэй~~ төсөөтэй олон системийн техник үйлчилгээ гүйцэтгэх журам;
- (6) хөдөлгүүрийн нөхцөлөөр хянах хөтөлбөр (ECMP);

- (7) хэрэв хөдөлгүүр, эсхүл АPU-д нэмж байгаа тосны хэмжээ нь үйлдвэрлэгчийн зөвлөсөн хэмжээнээс хэтэрсэн бол анхааруулга өгдөг журмыг багтаасан хөдөлгүүрийн болон хэрэв EDTO нислэгт АPU шаардлагатай бол, АPU-гийн хөдөлгүүрийн тосны зарцуулалтыг хянах хөтөлбөр;
- (8) хэрэв EDTO нислэгийн үед агаарт АPU-г асаах чадвар шаардлагатай байдаг бол, хүйтэнд царцсан АPU-г нислэгт асаах болон ажиллуулах найдвартай ажиллагааны хөтөлбөр;
- (9) EDTO нислэгт нөлөөлөх системийн жагсаалт;
- (10) дараах шаардлагыг бататгах эд ангийн хяналтын хөтөлбөр:
- (i) тухайн нисэх онгоц нь маягийн гэрчилгээний стандартыг үргэлжлүүлэн хангаж байгааг,
 - (ii) EDTO нислэгт зөвшөөрөгдсөн хүчилсэн бүтэц/хөдөлгүүрийн конфигурацийг хадгалах зорилгоор эд ангийг зөв таньж тогтоох.
- (b) ~~Хэд хэдэн ижил төстэй~~ **Төсөөтэй олон** системийн техник үйлчилгээнээс бусад дараах тохиолдолд, хуваарьт техник үйлчилгээний аль ч үе шатанд EDTO нислэгт нөлөөлөх системийн хувьд, энэ зүйлийн (a)(3)-т шаардсан техник үйлчилгээний ажлын хуваарьт нисэх онгоцонд гүйцэтгэх ~~хэд хэдэн ижил төстэй~~ **Төсөөтэй олон** системийн техник үйлчилгээг оруулахгүй:
- (1) зайлсхийх аргагүй; эсхүл
 - (2) энэ зүйлийн (a)(2)-т шаардсан EDTO нислэгт нисэн гарахын өмнөх техник үйлчилгээний шалгалт хийх шаардлагатай тохиолдолд.
- (c) EDTO нислэгт нөлөөлөх системд техник үйлчилгээ гүйцэтгэх зорилгоор энэ зүйлийн (a)(4)-т шаардсан журам нь дараах шаардлагыг багтаасан байх ёстой:
- (1) EDTO нислэгт нөлөөлөх системд техник үйлчилгээ гүйцэтгэсний дараа тухайн нисэх онгоц нь EDTO нислэгт бэлэн байгааг бататгах арга;
 - (2) хэрэв энэ хэсгийн (1)-д заасан шаардлага нь газарт суурилсан тестийн журмыг хангаж чадахгүй бол, EDTO бататгах нислэг.
- (d) хэрэв EDTO нислэгт ашиглахаар зөвшөөрөгдсөн нисэх онгоцонд гүйцэтгэх техник үйлчилгээ нь ~~хэд хэдэн ижил төстэй~~ **Төсөөтэй олон** системийг задлахыг шаарддаг бол, техник үйлчилгээг энэ зүйлийн (a)(5)-д шаардсан ~~хэд хэдэн ижил төстэй~~ **Төсөөтэй олон** системийн техник үйлчилгээний журмын дагуу гүйцэтгэсэн байх ёстой.
- (e) Энэ зүйлийн (a)(5)-д шаардсан ~~хэд хэдэн ижил төстэй~~ **Төсөөтэй олон** системийн техник үйлчилгээний журам нь дараах шаардлагыг багтаасан байх ёстой:
- (1) EDTO нислэгт нөлөөлөх систем бүрийн техник үйлчилгээний ажлыг гүйцэтгэх зохих ёсоор зөвшөөрөгдсөн тусдаа этгээдийн;
 - (2) энэ зүйлийн (e)(1)-д шаардсан этгээдийн гүйцэтгэсэн техник үйлчилгээнд хараат бус бодит шалгалтыг хийх зорилгоор зохих ёсоор зөвшөөрөгдсөн бусад этгээдийн;
 - (3) техник үйлчилгээг гүйцэтгэсний дараа:
 - (i) системийг техник үйлчилгээний заавар болон холбогдох модификацийн зааварчилгааны дагуу тест хийх;
 - (ii) тухайн нисэх онгоц нь EDTO нислэгт бэлэн, ажиллагаатай байгааг бататгах газрын тест хийх;

- (iii) хэрэв тухайн нисэх онгоцыг EDTO нислэгт бэлэн, ажиллагаатай байгааг энэ хэсгийн (ii)-т заасан газрын тестээр бүрэн бататгаж чадахгүй бол EDTO **шалгах бататгах** нислэг хийдэг байх.

121.409. Нөөц

121.411. Нөөц

121.413. Нөөц

121.415. Техник үйлчилгээний дүгнэлт

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгах үүрэгтэй:

- (1) тухайн нисэх онгоцны техник үйлчилгээний дүгнэлтийг өмнөх 12 сарын дотор хийсэн байхаас бусад тохиолдолд, тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд нисэх онгоцоор үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байх;
- (2) хийгдсэн техник үйлчилгээний дүгнэлтийг энэ зүйлийн (d)-гийн дагуу гэрчилгээжүүлсэн байх.

(b) Энэ зүйлийн (c)-д зааснаас бусад тохиолдолд, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь сүүлд хийгдсэн техник үйлчилгээний дүгнэлтээс хойш, дараах шаардлагыг хангаагүй нисэх онгоцны техник үйлчилгээний дүгнэлтийг гэрчилгээжүүлдэггүй болохыг бататгах үүрэгтэй:

- (1) тухайн нисэх онгоцны холбогдох техник үйлчилгээний хөтөлбөрт заасан хийгдэх хугацаа нь болсон техник үйлчилгээг заасан хугацаанд нь хийсэн байх;
- (2) бүх хамааралтай НТЧ-ын Удирдамжийг (AD) ИНД-39-д заасан шаардлагын дагуу хэрэгжүүлсэн байх;
- (3) техникийн бүртгэлийн дэвтэрт (TLB) тэмдэглэсэн бүх дутагдлыг гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааврын дагуу зассан, эсхүл зохих журмын дагуу хойшлуулсан байх;
- (4) ашиглалтад шилжүүлэх гэрчилгээжүүлэлтийг ИНД-43 С Бүлгийн дагуу хийсэн байх.

(c) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд, Даргын хүлээн зөвшөөрөхүйц техник үйлчилгээний хөтөлбөрийн байнгын хэрэгжилтэд үндэслэн нисэх онгоцны техник үйлчилгээний дүгнэлтийг гэрчилгээжүүлж болно, хэрэв:

- (1) техник үйлчилгээний дүгнэлтийн хугацаанд энэ зүйлийн (b)-гийн бүх шаардлагыг тухайн техник үйлчилгээний хөтөлбөрт задалж харуулдаг бол;
- (2) техник үйлчилгээний дүгнэлтийг тухайн гэрчилгээ эзэмшигчийн нисэх онгоц бүрээр гэрчилгээжүүлдэг бол.

(d) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь нисэх онгоцны техник үйлчилгээний дүгнэлт хийх этгээдийг дараах шаардлага хангасан болохыг бататгах үүрэгтэй:

- (1) тухайн нисэх онгоцны маягийн хувьд, гэрчилгээ эзэмшигч зөвшөөрсөн ба холбогдох агаарын хөлгийн техник үйлчилгээний инженерийн үнэмлэхний

(AMEL) зэрэглэл эзэмшихэд шаардлагатай туршлагатай дүйцэх дадлага туршлагатай байх;

- (2) энэ зүйлийн (b), эсхүл (c)-гийн аль холбогдох шаардлагын дагуу техник үйлчилгээний дүгнэлт хийх;
- (3) техник үйлчилгээний бүртгэлийн дэвтэрт (MLB) дараах мэдэгдлийг гарын үсэг, зөвшөөрлийн дугаар болон хугацааны хамт оруулснаар техник үйлчилгээний дүгнэлтийг гэрчилгээжүүлдэг байх:

“ИТЧ-ын хадгалалтын шаардлагын дагуу тухайн нисэх онгоц болон түүний төхөөрөмжийн техник үйлчилгээний дүгнэлтийг ИНД-121.415-ын шаардлагын дагуу хийсэн.”

121.417. EDTO нислэгийн улирлын тайлан

EDTO нислэг үйлдэхээр зөвшөөрөгдсөн АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараагийн улирал эхлэх сарын 21-нээс өмнө Даргад дараах мэдээллийг багтаасан EDTO нислэгийн өмнөх 3 сарын нэгдсэн тайланг хүргүүлэх үүрэгтэй:

- (1) EDTO нислэгт ашиглахыг зөвшөөрсөн нисэх онгоцны ашиглалт болон үйл ажиллагааг;
- (2) EDTO нислэг үйлдэж байгаа нисэх онгоцны хөдөлгүүрийн ашиглалт болон үйл ажиллагааг;
- (3) техникийн шалтгааны улмаас цуцлагдсан, хойшилсон, эсхүл саатсан EDTO нислэг бүрийг;
- (4) бодит, эсхүл техникийн доголдлоос болсон байж болох EDTO нислэгийн замын төлөвлөгдөөгүй цуцлалт, эсхүл даялалт бүрийг;
- (5) нислэгт хөдөлгүүр ~~татгалзсан~~ унтарсан (IFSD) давтамж болон тохиолдол бүрийг;
- (6) хөдөлгүүр удирдах боломжгүй болсон, эсхүл гаргах ёстой чадлаа өгөөгүй тохиолдол бүрийг;
- (7) урьдчилан сэргийлэх зорилгоор хөдөлгүүрийн татах хүчийг багасгасан тохиолдол бүрийг (нислэгийн зааварт зөвшөөрсөн хэвийн дутагдал арилгахаас бусад тохиолдол);
- (8) татах хүчний төхөөрөмжийг нислэгт асаах чадвар буурсан тохиолдол бүрийг;
- (9) EDTO нислэгт ашиглахыг зөвшөөрсөн нисэх онгоцтой холбоотой болон зөрчил гарснаас хойш 72 цагийн дотор, ИНЕГ-т мэдэгдэхийг ИНД-12.55(e)-д шаардсан зөрчил бүрийг;
- (10) EDTO нислэгт нөлөөлөх системийн дутагдлын давтамж нь гэрчилгээ эзэмшигчийн тогтоосон анхааруулах түвшнээс хэтэрсэн тохиолдолд, тухайн системийн дутагдлын нэгдсэн тайланг;
- (11) EDTO нислэгт нөлөөлөх системийн MEL ашигласан тохиолдол бүрийг;
- (12) EDTO нислэгт нөлөөлөх системийн бүрдэл хэсгийг нисэх онгоцноос хуваарьт бусаар буулгасан тохиолдол бүрийг.

Н Бүлэг - Багийн гишүүдэд тавих шаардлага

121.501. Зорилго

Энэ Бүлэг нь АТ-ийн гэрчилгээний эрхийн хүрээнд нисэх онгоцоор арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа багийн гишүүдийг томилох зохицуулалтын шаардлагыг тогтооно.

121.503. Багийн гишүүдийг томилох

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны маягийн хувьд, арилжааны нислэгийн үйл ажиллагаанд багийн гишүүний гүйцэтгэх үйл ажиллагааны болон аюулгүй байдлын үүрэг гүйцэтгэх багийн гишүүн бүрийг бичгээр томилох үүрэгтэй.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлага хангаагүй этгээдийг тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны багийн гишүүний ажил үүрэг гүйцэтгэхээр томилдоггүй болохыг бататгах үүрэгтэй:

- (1) I Бүлгийн дагуу холбогдох сургалтын хөтөлбөрт амжилттай хамрагдсан ба J Бүлгийн дагуу багийн гишүүний ажил үүрэг гүйцэтгэх ур чадварын үнэлгээ хийлгэсэн байх; эсхүл
- (2) хэрэв нисгэгч нь 121.567-гийн дагуу нисгэгчийн шугамын нислэгийн сургалтад хамрагдаж байгаа, эсхүл 121.569-ийн дагуу нисгэгчийн зөөлтийн нислэгт нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэж байгаа бол:
 - (i) I Бүлгийн дагуу тухайн сургалтын хөтөлбөрийн холбогдох үе шатанд амжилттай хамрагдсан байх;
 - (ii) J Бүлгийн дагуу тухайн нисэх багийн гишүүний ажил үүрэг гүйцэтгэх ур чадварт үнэлгээ хийлгүүлсэн байх; эсхүл
- (3) M Бүлгийн дагуу мэргэшил дээшлүүлэх хөтөлбөрт оролцож байгаа болон ур чадвартай болохыг үнэлгээ хийж тогтоосон байх.

(c) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн эрсдэлтэй үе шатанд тухайн нисэх онгоцны аюулгүй үйл ажиллагаанд шаардлагагүй ажил үүрэг гүйцэтгэхийг багийн гишүүдээс шаардахгүй байх үүрэгтэй.

(d) Энэ зүйлийн (c)-д заасан нислэгийн эрсдэлтэй үе шатанд дараах үйл ажиллагаа багтана:

- (1) нисэх багийн гишүүдийн хувьд, аяллын нислэгээс бусад, нисэх онгоцыг зогсоолоос түрэх, явгалах, хөөрөлт, ойртолт, буулт үйлдэх болон AGL 3000 м-ээс (10 000 ft) доош өндөрт гүйцэтгэж байгаа үйл ажиллагаа;
- (2) бусад багийн гишүүдийн хувьд, нисэх онгоц үндсэн явгалах зам, ХБЗ руу орохоор апроноос хөдлөн AGL 300 м (1000 ft) өндөр авах хүртэл, AGL 1500 м-ээс доош (5000 ft) өндөр алдан ойртолт болон буулт үйлдэж дуусах хүртэлх нислэгийн үе шатыг багтаасан газрын үйл ажиллагаа.

121.505. Нисэх багийн гишүүдийг ажил үүрэгт томилох

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд гүйцэтгэж байгаа арилжааны нислэгийн үйл ажиллагааны хувьд, дараах этгээдийг бичгээр томилох үүрэгтэй:

- (1) хөлгийн даргаар томилогдсон, 121.507-д заасан шаардлагыг хангасан нисгэгч;
- (2) 121.507, эсхүл 121.509-д заасан шаардлагыг хангасан байх ёстой, тухайн нисэх онгоцны нислэгийн зааварт шаардсан нэмэлт нисгэгч;
- (3) хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхээр, эсхүл (a)(2)-ын дагуу шаардагдах нэмэлт нисгэгчээр мэргэшсэн, **тухайн** нисэх онгоцны нислэгийн зааварт заасан минимум нисэх багийн гишүүдн дээр тухайн гүйцэтгэх үйл ажиллагааны төрөлд **нэмэлтээр** шаардлагатай бусад нисгэгч;
- (4) хэрэв тухайн үйл ажиллагааны төрөлд шаардсан бол, дараах мэргэжлийн хүмүүс:
 - (i) 121.513-т заасан шаардлагыг хангасан нисэх-инженер; эсхүл
 - (ii) 121.511-ийн шаардлагыг хангасан аяллын орлон нисгэгч; эсхүл
 - (iii) нисэх-инженер болон аяллын орлон нисгэгчийн аль алиныг.

(b) Хэрэв энэ зүйлийн (a)(1), (2), болон (3)-т шаардсан нисгэгчийн тоо нь 2-оос дээш бол, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь томилогдсон хөлгийн дарга үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон тохиолдолд, энэ зүйлийн (a)(1), (2), эсхүл (3)-т шаардсан аль нисгэгч хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхийг бичгээр томилох үүрэгтэй.

121.507. Хөлгийн даргын туршлагад тавих шаардлага

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлага хангаагүй нисгэгчийг тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны даргын үүрэг гүйцэтгэхээр томилохгүй байх үүрэгтэй:

- (1) холбогдох агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй, хүчинтэй агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэх (нисэх онгоц) эзэмшдэг байх;
- (2) хүчинтэй хэрэглэлийн зэрэглэл эзэмшдэг байх;
- (3) I болон J Бүлэгт заасан холбогдох сургалт болон ур чадварын шаардлагыг амжилттай хангасан байх, эсхүл M Бүлэгт заасан мэргэшил дээшлүүлэх хөтөлбөрт амжилттай хамрагдаж, ур чадварын үнэлгээг амжилттай хийлгэсэн байх;
- (4) дараах цагийг багтаасан, нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн 1500 цагаас доошгүй нислэгийн цагийн туршлагатай байх:
 - (i) энэ Дүрэмд хамаарах, эсхүл түүнтэй дүйцэх Даргын хүлээн зөвшөөрөхүйц үйл ажиллагааны төрлийн 500 цаг;
 - (ii) бодит нислэгт гүйцэтгэсэн байх ёстой 50 цагаас доошгүй цагийг багтаасан хэрэглэлийн нислэгийн 100 цаг;
- (5) шөнийн нислэгийн үйл ажиллагааны хувьд, 100 цагаас доошгүй шөнийн нислэгийн цагийн туршлага хуримтлуулсан байх.

121.509. Хамтран нисгэгчийн туршлагад тавих шаардлага

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангаагүй нисгэгчийг тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэхээр томилохгүй байх үүрэгтэй:

- (1) холбогдох агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй хүчинтэй коммерийн нисгэгчийн үнэмлэх (нисэх онгоц) эзэмшдэг байх;
- (2) хүчинтэй хэрэглэлийн зэрэглэлтэй байх;
- (3) дараах шаардлагыг амжилттай хангасан байх:
 - (i) I болон J Бүлэгт заасан холбогдох сургалтад хамрагдаж, ур чадварын шаардлагыг хангасан байх, эсхүл ийм сургалтад хамрагдаж байгаа ба M Бүлэгт заасан мэргэшил дээшлүүлэх хөтөлбөрийн дагуу ур чадварын үнэлгээ хийлгэсэн байх; эсхүл
 - (ii) I Бүлэгт шаардсан нисэх багийн сургалтын хөтөлбөрийн холбогдох танилцах, шилжих, эсхүл шат ахих үе шат болон J Бүлгийн дагуу нисэх багийн гишүүний ажил үүрэг гүйцэтгэх ур чадварын үнэлгээ хийлгэсэн байх ба 121.567-д заасан нисгэгчийн шугамын нислэгийн **сургалт**, эсхүл 121.569-д заасан нисгэгчийн зөөлтийн нислэг **I** ~~ийн сургалтад~~ хамрагдсан байх.
- (4) хэрэв хөлгийн дарга үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон бол, дараах чадвартай байх:
 - (i) зонхилох болон өгөгдсөн цаг агаарын урьдчилсан мэдээний нөхцөлд нисэх онгоцоор аюулгүй үйл ажиллагаа гүйцэтгэх;
 - (ii) хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх;
 - (iii) төлөвлөсөн нисэн очих, эсхүл тохиромжтой бэлтгэл аэродромд тухайн нисэх онгоцоор буулт үйлдэх.

121.511. Аяллын орлон нисгэгчийн туршлагад тавих шаардлага

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангаагүй нисгэгчийг тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны аяллын орлон нисгэгчийн үүрэг гүйцэтгэхээр томилохгүй байх үүрэгтэй:

- (1) тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй, хүчинтэй коммерийн нисгэгчийн үнэмлэх (нисэх онгоц) эзэмшдэг байх;
- (2) хүчинтэй хэрэглэлийн зэрэглэл эзэмшдэг байх;
- (3) I болон J Бүлэгт заасан холбогдох сургалт болон ур чадварын шаардлагыг амжилттай хангасан байх;
- (4) 121.533(b)-д заасан аяллын нислэгийн үе шатанд, дараах нөхцөлд нисэх онгоцоор аюулгүй нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх чадвартай байх:
 - (i) хэрэв хөлгийн дарга үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон бол хамтран нисгэгчийг нисгэгчийн бүхээгт орж ирэх хүртэл; эсхүл
 - (ii) хэрэв хамтран нисгэгч үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон бол, хөлгийн даргыг нисгэгчийн бүхээгт орж ирэх хүртэл.

121.513. Нисэх-инженерийн туршлагад тавих шаардлага

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангаагүй этгээдийг тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны нисэх-инженерийн үүрэг гүйцэтгэхээр томилохгүй:

- (1) холбогдох агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй, хүчинтэй нисэх-инженерийн үнэмлэх эзэмшдэг ба I болон J Бүлэгт заасан холбогдох сургалт болон ур чадварын шаардлагыг амжилттай хангасан байх; эсхүл
- (2) хүчинтэй сурагч-нисэх инженерийн үнэмлэхтэй ба холбогдох агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй, хүчинтэй багш-нисэх-инженерийн зэрэглэл эзэмшдэг бөгөөд I болон J Бүлэгт заасан холбогдох сургалт болон ур чадварын шаардлагыг амжилттай хангасан нисэх-инженерийн шууд хяналтад байх.

121.515. Бүхээгийн ажилтны туршлагад тавих шаардлага

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь аливаа этгээд тухайн нисэх онгоцны маяг болон томилогдсон багийн гишүүний ажил үүргийн хувьд, 121.553-т шаардсан багийн гишүүний сургалтын хөтөлбөрийн холбогдох үе шатанд амжилттай хамрагдсан байхаас бусад тохиолдолд, тухайн этгээдийг арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны бүхээгийн ажилтны үүрэг гүйцэтгэхээр томилохгүй байх үүрэгтэй.

121.517. Шугамын хяналтын нисгэгчийн туршлагад тавих шаардлага

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангаагүй этгээдийг шугамын хяналтын нисгэгчийн үүрэг гүйцэтгэхээр томилохгүй байх үүрэгтэй:

- (1) тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа маягийн нисэх онгоцны даргын үүрэг гүйцэтгэхээр мэргэшсэн байх;
- (2) ИНД-61-д заасан D-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшдэг байх;
- (3) дараах цагийг багтаасан, нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн 2000 цагаас доошгүй нислэгийн цагийн туршлагатай байх:
 - (i) ашиглаж байгаа нисэх онгоцны тодорхой маягийн хувьд, 200 цагийн шугамын-үйл ажиллагааны нислэгийн цагийн туршлага; эсхүл
 - (ii) ИНД-61-д заасан багш-нисгэгчийн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэн I, эсхүл M Бүлгийн дагуу бусад маягийн нисэх онгоцоор арилжааны нислэгийн үйл ажиллагаанд зөөлтийн нислэг гүйцэтгэхэд хяналт тавьсан нисгэгчийн 100 цагийн;
- (4) хүний хүчин зүйл болон багийн нөөцийн удирдлагыг багтаасан тухайн нисэх онгоцны үйл ажиллагааны техникийн болон техникийн бус асуудлаар багийн гишүүний ур чадварын үнэлгээ хийх аргыг заах сургалтын курст амжилттай хамрагдсан байх.

121.519. Сургагч-нисгэгчийн туршлагад тавих шаардлага

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангаагүй нисгэгчийг энэ Дүрэмд шаардсан нисэх багийн гишүүний сургалтын хөтөлбөрт заасан сургагч-нисгэгчийн үүрэг гүйцэтгэхээр томилохгүй байх үүрэгтэй:

- (1) арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа маягийн нисэх онгоцны даргын үүрэг гүйцэтгэхээр мэргэшсэн байх;
- (2) ИНД-61-д заасан **А, В, эсхүл** D-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшдэг байх;
- (3) дараах цагийг багтаасан, нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн 3000 цагаас доошгүй нислэгийн цагийн туршлагатай байх:
 - (i) ашиглаж байгаа нисэх онгоцны тодорхой маягийн хувьд, 500 цагийн шугамын-үйл ажиллагааны нислэгийн цагийн туршлага; эсхүл
 - (ii) ИНД-61-д заасан **А, В, эсхүл** D-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэн I, эсхүл M Бүлгийн дагуу бусад нисэх онгоцны маягт зааварчилгаа өгсөн нисгэгчийн 100 цагийн;
- (4) хүний хүчин зүйл болон багийн нөөцийн удирдлагыг багтаасан тухайн нисэх онгоцны үйл ажиллагааны техникийн болон техникийн бус асуудлаар багийн гишүүний ур чадварын үнэлгээ хийх аргыг заах сургалтын курст амжилттай хамрагдсан байх.

121.521. Шалгагч-нисгэгчийн туршлагад тавих шаардлага

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангаагүй нисгэгчийг 121.567(е)(3), 121.569(а)(3)-т шаардсан чиглэлийн нислэгийн шалгалт, эсхүл J Бүлэгт шаардсан ур чадварын үнэлгээний хөтөлбөрт шалгагч-нисгэгчийн үүрэг гүйцэтгэхээр томилохгүй байх үүрэгтэй:

- (1) ИНД-61-д заасан, хүчинтэй агаарын тээврийн шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшдэг байх;
- (2) тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа маягийн нисэх онгоцны даргын үүрэг гүйцэтгэхээр мэргэшсэн байх;
- (3) дараах туршлагыг хуримтлуулсан байх:
 - (i) ашиглаж байгаа нисэх онгоцны тодорхой маягийн хувьд, ИНД-61-д заасан **А, В, эсхүл** D-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлсэн нислэгийн 200 цагийн; эсхүл
 - (ii) энэ Дүрэм хамаарах нисэх онгоцны маягаар ИНД-61-д заасан агаарын тээврийн шалгагч-нисгэгчийн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлсэн нислэгийн 100 цагийн; эсхүл
 - (iii) энэ Дүрэмд, эсхүл ИНД-125-д холбогдох, Даргын хүлээн зөвшөөрөхүйц маягийн нисэх онгоцны бусад туршлага;
- (4) хүний хүчин зүйл болон багийн нөөцийн удирдлагыг багтаасан, тухайн нисэх онгоцны үйл ажиллагааны техникийн болон техникийн бус асуудлаар багийн гишүүний ур чадварын үнэлгээ хийх аргыг заах сургалтын курст амжилттай хамрагдсан байх.

121.523. Симуляторын багш болон шалгагч-нисгэгчийн туршлагад тавих шаардлага

(а) Энэ зүйлийн (b) болон (c)-д зааснаас бусад тохиолдолд, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлага хангаагүй нисгэгчийг нислэгийн симулятор дээр нислэгийн зааварчилгаа өгөх, эсхүл нисэх багийн гишүүний ур чадварыг үнэлэх зорилгоор сургагч-нисгэгчийн, эсхүл шалгагч-нисгэгчийн үүрэг гүйцэтгэхээр томилохгүй байх үүрэгтэй:

- (1) 121.519, эсхүл 121.521-д заасан холбогдох шаардлагыг хангасан байх;
- (2) J Бүлэгт шаардсан стандартын дагуу нислэгийн симуляторт хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх ур чадвараа шалгуулсан байх;
- (3) нислэгийн симуляторын үйл ажиллагааны мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх;
- (4) хүний хүчин зүйл болон багийн нөөцийн удирдлагыг багтаасан тухайн нисэх онгоцны үйл ажиллагааны техникийн болон техникийн бус асуудлаар багийн гишүүний ур чадварын үнэлгээ хийх арга зүйн сургалтын курст амжилттай хамрагдсан байх.

(b) Хэрэв тухайн нисгэгч нь ур чадвараа дараах байдлаар хадгалж байгаа бол, хүчинтэй эрүүл мэндийн гэрчилгээ эзэмшдэггүй боловч өмнө нь энэ зүйлийн (a)-д заасан шаардлагыг хангаж байсан нисгэгч нислэгийн симулятор дээр сургагч-нисгэгч, эсхүл шалгагч-нисгэгчийн үүрэг гүйцэтгэж болно:

- (1) 121.553-т шаардсан сургалтын хөтөлбөрийн дагуу нислэгийн симуляторт нисэх багийн гишүүний сургалтад хамрагдаж;
- (2) J Бүлгийн дагуу ур чадварын үнэлгээ хийлгэж;
- (3) энэ Дүрэм болон ИНД-61-ийн дагуу багш-нисгэгчийн зэрэглэл, эсхүл шалгагч-нисгэгчийн зэрэглэлийн хүчинтэй байдлаа хадгалахад шаардлагатай бусад, холбогдох сургалтад хамрагдаж.

(c) Энэ зүйлийн (a)-г үл харгалзан, хэрэв АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь Даргад бичгээр хүсэлт гаргасан бол, хүчинтэй эрүүл мэндийн гэрчилгээ эзэмшдэггүй ба 121.519, эсхүл 121.521-д заасан шаардлагыг өмнө нь хангаагүй байсан нисгэгчийг хэрэв тухайн нисгэгч дараах шаардлагыг хангасан бол нислэгийн симулятор дээр сургагч-нисгэгч, эсхүл шалгагч-нисгэгчийн үүрэг гүйцэтгэхийг Дарга зөвшөөрч болно:

- (1) 5000 цагаас доошгүй арилжааны нислэгийн үйл ажиллагааны нислэгийн цагийн туршлагатай байх;
- (2) тухайн нисэх онгоцны маягийн нислэгийн симулятор дээр I болон J Бүлэгт шаардсан сургалтад амжилттай хамрагдаж, ур чадвараа шалгуулсан байх;
- (3) Даргын хүлээн зөвшөөрөхүйц нислэгийн зааварчилгаа өгөх, эсхүл нислэгийн шалгалт авах сургалтын курст амжилттай хамрагдсан байх;
- (4) нислэгийн симуляторын үйл ажиллагааны мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх;
- (5) энэ зүйлийн (b)-д заасан ур чадвараа үргэлжлүүлэн хадгалж байх.

121.525. Сургагч-бүхээгийн ажилтны туршлагад тавих шаардлага

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангаагүй бүхээгийн ажилтныг энэ Дүрэмд шаардсан нисэх багийн гишүүний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургагч-бүхээгийн ажилтны үүрэг гүйцэтгэхээр томилохгүй байх үүрэгтэй:

- (1) 121.553-т заасан багийн гишүүний сургалтын хөтөлбөрийн бүхээгийн ажилтны сургалтын үе шатанд амжилттай хамрагдсан байх;
- (2) хүний хүчин зүйл болон багийн нөөцийн удирдлагыг багтаасан тухайн нисэх онгоцны үйл ажиллагааны техникийн болон техникийн бус асуудлаар бүхээгийн ажилтны ур чадварын үнэлгээ хийх арга зүйн сургалтын курст амжилттай хамрагдсан байх.

121.527. Бүхээгийн ажилтанд үнэлгээ хийх этгээдийн туршлагад тавих шаардлага

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангаагүй бүхээгийн ажилтныг 121.611-ийн зорилгоор бүхээгийн ажилтанд үнэлгээ хийх этгээдийн үүрэг гүйцэтгэхээр томилохгүй байх үүрэгтэй:

- (1) 121.525-д заасан сургалтын үе шат болон сургалтын курст амжилттай хамрагдсан байх;
- (2) 121.575-д заасан шаардлагыг хангасан байх.

121.529. Онолын багшийн туршлагад тавих шаардлага

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах сургалтад хамрагдаагүй этгээдийг, 121.553-т шаардсан багийн гишүүний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх онолын багшийн үүрэг гүйцэтгэхээр томилохгүй байх үүрэгтэй:

- (1) Даргын хүлээн зөвшөөрөхүйц заах арга зүйн сургалтын курс;
- (2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц хүний хүчин зүйлийн сургалтын курс;
- (3) тухайн өгөх зааварчилгааны сэдвийн цогц сургалтын курс.

121.531. Нисэх баг бүрдүүлэхэд тавих хязгаарлалт

(а) Энэ зүйлийн (b)-гийн дагуу зөвшөөрснөөс бусад тохиолдолд, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь, I Бүлгийн сургалт болон зөөлтийн нислэгийн шаардлагыг **биелүүлэний хангасны** дараа, нисэх багийн аль нэг гишүүн дараах нислэгийн цагийн туршлага хуримтлуулаагүй бол арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэдэггүй болохыг бататгах үүрэгтэй:

- (1) тухайн үйл ажиллагаанд ашигладаг нисэх онгоцны маягаар 75 цаг; эсхүл
- (2) тухайн үйл ажиллагаанд ашигладаг нисэх онгоцны маягаар 75 нислэгийн цикл.

(b) Хэрэв АТ-ийн гэрчилгээ эзэмшигч Даргад бичгээр хүсэлт гаргасан бол, дараах нөхцөлд тохирох нэмэлт өөрчлөлтийг Үйл ажиллагааны тодорхойлолтод оруулснаар энэ зүйлийн (а)-ийн шаардлагаас хазайх зөвшөөрлийг Дарга гэрчилгээ эзэмшигчид олгож болно:

- (1) энэ зүйлийн (а)-д заасан минимум шаардлагыг шинэ гэрчилгээ эзэмшигч хангаж чадахгүй байх; эсхүл

(2) Дарга үйл ажиллагаандаа ашиглахыг өмнө нь зөвшөөрөөгүй нисэх онгоцны маягийг тухайн гэрчилгээ эзэмшигч худалдан авах.

(с) Энэ Дүрмийн М Бүлэгт шаардсан мэргэшил дээшлүүлэх хөтөлбөрт хамрагдаж байгаа нисэх багийн гишүүнд энэ зүйлийн (а)-д заасан нислэгийн цагийн туршлага хамаарна.

121.533. Нисгэгчийн үйл ажиллагааны хязгаарлалт

(а) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд гүйцэтгэж байгаа арилжааны нислэгийн үйл ажиллагааны хувьд, хөөрөлт болон буулт үйлдэх үед тухайн идэвхтэй нисгэгчийг (PF) дараах шаардлага хангасан болохыг бататгах үүрэгтэй:

(1) хөлгийн дарга байх; эсхүл

(2) энэ зүйлийн (с)-д заасан, хөлгийн даргаас бусад нисгэгч байх.

(b) Хэрэв аяллын орлон нисгэгчийг 121.505(а)(4)-ийн дагуу арилжааны нислэгийн үйл ажиллагаанд томилсон бол, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн аяллын орлон нисгэгч дараах тохиолдолд, нисгэгчийн суудал эзэлдэггүй болохыг бататгах үүрэгтэй:

(1) тухайн нисэх онгоц нь нислэгийн түвшин 6100 м-ээс доош (FL200), эсхүл шилжих түвшнээс (TL) доош түвшний аль илүү дээш түвшинд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бүх цаг хугацаанд; эсхүл

(2) дараах нисгэгч бусад нисэх багийн гишүүний суудал эзэлсэн байхаас бусад тухайн нислэгийн бүх цаг хугацаанд:

(i) хөлгийн дарга; эсхүл

(ii) аяллын орлон нисгэгчийг хянаж байхдаа, аяллын нислэгийн үе шатанд гэрчилгээ эзэмшигчээр хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхээр мэргэшсэн бөгөөд хөлгийн даргын томилсон.

(с) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь, нисэх онгоцны хөөрөлт, эсхүл буулт үйлдэх үед хөлгийн даргаас бусад идэвхтэй нисгэгчийн үүрэг гүйцэтгэх нисгэгч дараах шаардлага хангасан болохыг бататгах журмыг хэрэгжүүлэх үүрэгтэй:

(1) хөөрөлт, эсхүл буултыг бие даан гүйцэтгэх ур чадвартай байх;

(2) хөлгийн даргын хяналтад байх.

(d) Энэ зүйлийн (а)-д шаардсан журам нь дараах хүчин зүйлийг тооцон, эрсдэлийн удирдлагын зарчимд тулгуурласан байх ёстой:

(1) хөлгийн даргын мэргэшил;

(2) нисгэгчийн сургалт болон туршлага;

(3) агаарын хөлгийн төлөв болон үзүүлэлт;

(4) ХБЗ-ны хэмжээс болон нөхцөл;

(5) үүлний суурийн өндөр;

(6) зонхилох хараа;

(7) хөндлөнгийн салхины бүрдэл хэсэг.

121.535. Хэд хэдэн нисэх онгоцны маяг, эсхүл вариантаар үйл ажиллагаа гүйцэтгэх нисэх баг

(a) Хэрэв АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь нисэх багийн гишүүнийг нэгээс олон нисэх онгоцны маяг, эсхүл нэгээс олон вариантын нисэх онгоцны маягаар үйл ажиллагаа гүйцэтгүүлэхээр томилдог бол тухайн гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:

- (1) тухайн нисэх багийн гишүүн нь нисэх онгоцны маяг болон вариант бүрээр үйл ажиллагаа гүйцэтгэх сургалтад хамрагдсан ба мэргэшсэн болохыг бататгах;
- (2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц сургалтын болон ур чадварын үнэлгээний журмыг хэрэгжүүлэх.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (a)(2)-т шаардсан журамд дараах шаардлага багтсан болохыг бататгах үүрэгтэй:

- (1) нисэх багийн гишүүн нь нэгээс олон нисэх онгоцны маяг, эсхүл вариантаар нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэхээр томилогдохын өмнө, тухайн агаарын хөлөг үйлдвэрлэгчийн зөвлөмжийн дагуу, нисэх онгоцны тухайн маяг, эсхүл вариантаар үйл ажиллагаа гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох туршлагатай байх;
- (2) нисэх багийн гишүүн нь аливаа нэг нисэх онгоцны маяг, эсхүл вариантын сургалтад хамрагдахын өмнө, тухайн үйлдвэрлэгчийн зөвлөмжийн дагуу, өмнөх нисэх онгоцны маяг, эсхүл вариантаар хуримтлуулсан байхыг шаардсан, хангалттай туршлагатай байх;
- (3) аливаа нэг нисэх онгоцны маяг, эсхүл вариантаар мэргэшсэн нисэх багийн гишүүн нь өөр бусад нисэх онгоцны маяг, эсхүл вариантын сургалтад хамрагддаг бөгөөд мэргэшдэг байх;
- (4) нисэх багийн гишүүн нь:
 - (i) нисэх онгоцны маяг, эсхүл вариант тус бүрээр холбогдох ур чадварын болон нислэгийн туршлага хадгалах шаардлагыг хангасан байх; эсхүл
 - (ii) тухайн нисэх онгоцны маяг, эсхүл вариантын ур чадварын стандартыг хангасан гэж тооцдог өөр нэг нисэх онгоцны маяг, эсхүл вариантаар ур чадварын үнэлгээг амжилттай хийлгэсэн байх;
 - (iii) энэ хэсгийн (ii)-ын зорилгоор, тухайн өөр нисэх онгоцны маяг, эсхүл вариантыг тухайн нисэх онгоц үйлдвэрлэгч зөвлөсөн байх ёстой.

(c) Энэ зүйлийн (b)(1)-д заасан холбогдох туршлага нь, энэ Дүрэм хамаарах арилжааны нислэгийн үйл ажиллагаанд тухайн нисэх багийн гишүүн хуримтлуулах үүрэгтэй минимум нислэгийн цагийн туршлага, эсхүл нислэгийн циклийг багтаасан байх ёстой.

(d) Энэ зүйлийн (b)(2)-т заасан туршлага нь дараах нислэгийн цагийг багтаасан байх ёстой:

- (1) тухайн багийн гишүүн өмнө нисэж байсан энэ Дүрэмд хамаарах нисэх онгоцны маягаар хуримтлуулах үүрэгтэй минимум нислэгийн цагийн туршлага, эсхүл нислэгийн цикл;
- (2) шинэ нисэх онгоцны маяг, эсхүл вариантын сургалт эхэлсний дараа, тухайн нисэх багийн гишүүн бүгдийг нь тухайн шинэ нисэх онгоцны маяг, эсхүл вариантаар цуглуулах үүрэгтэй минимум нислэгийн цаг.

(е) Нэгээс олон нисэх онгоцны маяг, эсхүл вариантаар үйл ажиллагаа гүйцэтгэх нисэх багийн гишүүний хувьд, энэ зүйлийн (а)(2)-т шаардсан сургалт болон ур чадварын үнэлгээний журамд тухайн нисэх онгоцны маяг, эсхүл вариант хоорондын дараах ялгааг тооцон үзсэн байх ёстой:

- (1) нисэх онгоцны үйл ажиллагааны журам;
- (2) нисэх онгоцны систем;
- (3) нисэх онгоцны үзүүлэлтийн хязгаарлалт;
- (4) нисэх онгоцны жолоодлогын үзүүлэлт (handling characteristics).

(f) ИНД-61.37-г үл харгалзан АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь, нисэх онгоцны хэд хэдэн маяг, эсхүл вариантаар нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэхээр томилогддог, аяллын орлон нисгэгчээс бусад нисэх багийн гишүүн дараах шаардлага хангасан болохыг бататгах үүрэгтэй:

- (1) нисэх онгоцны маяг, эсхүл вариант бүрээр ИНД-61-д шаардсан нислэгийн туршлага хадгалах; эсхүл
- (2) нисэх онгоцны маяг, эсхүл вариант бүрээр энэ зүйлийн (b)(4)-т шаардсан журамд заасан нислэгийн туршлага хадгалах шаардлага.

121.537. САТ II, эсхүл САТ III нарийвчлалтай ойртолтын журмаар болон хөөрөлтийн багасгасан минима-гаар нислэг үйлдэх нисэх баг

(а) Хөлгийн дарга болон хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэж байгаа нисгэгч нь хоёулаа тухайн ойртолтын, эсхүл нисэн гарах журмыг ашиглахад мэргэшсэн байхаас бусад тохиолдолд, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны нисгэгчийг САТ II, эсхүл САТ III-аар нарийвчлалтай ойртолтын журам, эсхүл хөөрөлтийн багасгасан минима-гаар нисэн гарах журмыг ашигладаггүй болохыг бататгах үүрэгтэй.

(b) Энэ зүйлийн (а)-ийн зорилгоор:

- (1) хэрэв хөлгийн дарга нь зөвхөн САТ II, эсхүл САТ III-аар нарийвчлалтай ойртолтын журмаар, эсхүл хөөрөлтийн багасгасан минима-гаар нисэх идэвхтэй нисгэгчээр мэргэшсэн бол, хөлгийн дарга тухайн ойртолтын журам болон хөөрөлтийн багасгасан минима-гаар нисэн гарахдаа идэвхтэй нисгэгчийн үүрэг гүйцэтгэх үүрэгтэй;
- (2) хэрэв хамтран нисгэгч нь зөвхөн САТ II, эсхүл САТ III-аар нарийвчлалтай ойртолтын журмаар, эсхүл хөөрөлтийн багасгасан минима-гаар нисэх ажиглагч нисгэгчээр (PNF) мэргэшсэн бол, хөлгийн дарга тухайн ойртолтын журам болон хөөрөлтийн багасгасан минима-гаар нисэн гарахдаа идэвхтэй нисгэгчийн үүрэг гүйцэтгэх үүрэгтэй.

(c) Энэ зүйлийн (b)-г үл харгалзан, нисэх онгоцны нисгэгч нь дараах тохиолдолд, САТ II, эсхүл САТ III-аар нарийвчлалтай ойртолтын журмаар, эсхүл хөөрөлтийн багасгасан минима-гаар нисэн гарахдаа ойртолт, эсхүл хөөрөлт үйлдэх идэвхтэй нисгэгч, эсхүл ажиглагч нисгэгчийн (PNF) үүрэг гүйцэтгэж болно, хэрэв:

- (1) хөлгийн дарга болон хамтран нисгэгч нь энэ зүйлийн (а)-д заасны дагуу мэргэшсэн бол;
- (2) хөлгийн дарга нь:

- (i) 21.517-д заасны дагуу шугамын хяналтын нисгэгчээр мэргэшсэн бол; эсхүл
- (ii) 121.519-д заасны дагуу сургагч-нисгэгчээр мэргэшсэн бол; эсхүл
- (iii) 121.521-д заасны дагуу шалгагч-нисгэгчээр мэргэшсэн бол.

121.539. Бүхээгийн ажилтныг ажил үүрэгт томилох

(а) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь минимум тооны бүхээгийн ажилтныг дараах шаардлагын дагуу багийн гишүүнээр томилсноос бусад тохиолдолд, нисэх онгоцоор тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд зорчигч тээвэрлэн арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэдэггүй болохыг бататгах үүрэгтэй:

- (1) тухайн ашиглаж байгаа нисэх онгоцны конфигурацийн хувьд, үйлдвэрлэгчийн зөвлөсөн онцгой нөхцөлийн нүүлгэн шилжүүлэлтийн журамд заасан;
- (2) тухайн нисэх онгоцны хувьд, батлагдсан загварын шалгуураар тогтоосон;
- (3) зорчигчтой бүхээг нь 1-ээс доошгүй бүхээгийн ажилтантай байх;
- (4) Хүснэгт 3-т заасан минимум тооны дагуу байх.

Хүснэгт 3. Шаардлагатай бүхээгийн ажилтан

Нисэх онгоцны зорчигчийн багтаамж	Шаардлагатай бүхээгийн ажилтан
15 - 50	1
51 - 100	2
101 - 150	3
151 - 200	4
201 - 250	6
251 - 300	7
301 - 350	9
351 - 400	10
401 - 450	11
451 - 500	12
500-аас дээш	12 дээр нэмэх нь 500-аас дээших нэмэлт 50 зорчигч тутамд, эсхүл 50 зорчигчийн бүрдэл хэсэг бүрд 1

- (b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах этгээдийг томилох үүрэгтэй:
- (1) 2 ба түүнээс дээш бүхээгийн ажилтан шаардлагатай арилжааны нислэгийн үйл ажиллагааны хувьд, бүхээгийн ажилтны үйл ажиллагааны болон аюулгүй байдлын үүрэгт ажлыг хөлгийн даргын өмнө хариуцсан бүхээгийн ахлах ажилтныг;
 - (2) 6 ба түүнээс дээш бүхээгийн ажилтан шаардлагатай арилжааны нислэгийн үйл ажиллагааны хувьд, бүхээгийн ахлах ажилтны орлогчийг.
- (c) Энэ зүйлийн (a)(4)-ийг үл харгалзан, хэрэв шаардлагатай бүхээгийн ажилтан нь үүрэг гүйцэтгэх хугацаанд өвчин, эсхүл бэртлийн улмаас ажиллах чадваргүй болсон бол, арилжааны нислэгийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх зорилгоор Хүснэгт 3-т шаардсан бүхээгийн ажилтны тоог 1-ээр багасгаж болно, хэрэв:
- (1) энэ зүйлийн (a)(1), (2), болон (3)-ын шаардлагыг хангаж чадах бол;
 - (2) бүхээгийн ажилтан нэгээр багассан үед үлдсэн бүхээгийн ажилтнууд нь гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт заасан журмын дагуу үйл ажиллагааг аюулгүй гүйцэтгэх сургалтад хамрагдсан ба чадвартай бол;
 - (3) 121.515-д заасан шаардлагыг хангасан бүхээгийн ажилтан, үүрэг гүйцэтгэх чадваргүй болсон бүхээгийн ажилтныг солихоор буулт үйлдэх эхний аэродромд бэлэн байгаа бол.

I Бүлэг - Сургалт

121.551. Зорилго

Энэ Бүлэг нь М Бүлэгт заасан мэргэшил дээшлүүлэх хөтөлбөрт хамрагдаагүй нисэх багийн гишүүд болон бүхээгийн ажилтны энэ Бүлэгт заасан сургалтын хөтөлбөрийг тогтоох, түүнийг хэрэгжүүлэх зохицуулалтын шаардлагыг тогтооно.

121.553. Багийн гишүүний сургалтын хөтөлбөр

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь, арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны багийн гишүүний үүрэг гүйцэтгэхээр томилогдсон нисэх багийн гишүүн, бүхээгийн ажилтан болон М Бүлэгт заасан мэргэшил дээшлүүлэх хөтөлбөрт хамрагдаагүй этгээдийг томилогдсон ажил үүргээ гүйцэтгэх сургалтад хамрагдсан болохыг бататгах зорилгоор энэ Бүлгийн дагуу багийн гишүүний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (a)-д шаардсан сургалтын хөтөлбөрийг зохион байгуулалттай хэлбэрээр, тухайн төхөөрөмж болон ажилтан, эсхүл гуравдагч этгээдэд хүлээн зөвшөөрөхүйц бус эрсдэлгүйгээр аюулгүй гүйцэтгэдэг болохыг бататгах үүрэгтэй.

(c) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (a)-д шаардсан сургалтын хөтөлбөр дараах үе шатыг багтаасан болохыг бататгах үүрэгтэй:

- (1) танилцах сургалт;
- (2) шилжих сургалт;

- (3) шат ахих сургалт;
- (4) давтан сургалт.

(d) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (а)-д шаардсан сургалтын хөтөлбөрт хүний хүчин зүйл нь энэ зүйлийн (с)-д заасан сургалтын үе шат бүрийн бүрдэл хэсэгт багтсан болохыг бататгах үүрэгтэй.

(e) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь, танилцах сургалт, шилжих сургалт, эсхүл шат ахих сургалтын үе шатанд амжилттай хамрагдсан тухайн нисгэгчийг мөн 121.567-д заасан нисгэгчийн шугамын нислэгийн сургалтын болон 121.569-д заасан нисгэгчийн зөөлтийн нислэгийн шаардлагыг хангасан болохыг бататгах үүрэгтэй.

(f) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь, нисэх багийн сургалтын хөтөлбөр хариуцсан этгээдийг хүчинтэй шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшдэг болохыг бататгах үүрэгтэй.

(g) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь бүхээгийн ажилтны сургалтын хөтөлбөр хариуцсан этгээдийг 121.525, эсхүл 121.527-д заасны дагуу мэргэшсэн, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц мэргэшил болон туршлагатай болохыг бататгах үүрэгтэй.

(h) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (а)-д шаардсан сургалтын хөтөлбөрт хяналт тавих үүрэгтэй.

(i) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь:

- (1) энэ зүйлийн (а)-д шаардсан сургалтын хөтөлбөрийн дагуу тухайн сургалтыг зохион байгуулж болно; эсхүл
- (2) хэрэв ИНД-141-ийн гэрчилгээ нь тухайн төрлийн сургалт зохион байгуулахыг гэрчилгээ эзэмшигчид зөвшөөрдөг бол ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигчтэй энэ зүйлийн (а)-д шаардсан сургалтын хөтөлбөрийн дагуу тухайн сургалтыг зохион байгуулахаар гэрээ байгуулж болно; эсхүл
- (3) Монгол улсын гадна зохион байгуулдаг сургалтын хувьд, энэ зүйлийн (а)-д шаардсан нисэх багийн гишүүний сургалтын хөтөлбөрийн дагуу тухайн сургалтыг зохион байгуулахаар ИНД-141-д заасантай дүйцэх стандартыг хангасан байгууллагатай гэрээ байгуулж болно.

(j) Багийн гишүүн тухайн сургалтын хөтөлбөрийн сургалтын үе шатанд амжилттай хамрагдсаны дараа АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгах үүрэгтэй:

- (1) багийн гишүүний сургалтын бүртгэлд тухайн сургалтаар олж авсан мэргэшлийн дэлгэрэнгүй мэдээллийг оруулж шинэчилсэн байх;
- (2) тухайн сургалтын бүртгэл болон энэ хэсгийн (1)-д заасан тухайн мэргэшлийн дэлгэрэнгүй мэдээллийг ИНД-119.67-д заасан журмын дагуу хадгалсан байх;
- (3) багийн гишүүнд тухайн мэргэшил эзэмшсэнийг мэдэгдсэн байх.

121.555. Багийн гишүүний сургалтын хөтөлбөрийн сэдэв

(а) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь нисэх багийн гишүүн болон бүхээгийн ажилтны сургалтын хөтөлбөрийн үе шат бүрийг гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаанд тохирсон бөгөөд Даргын хүлээн зөвшөөрөхүйц сэдвийн задаргааг багтаасан болохыг бататгах үүрэгтэй.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан сэдвийн задаргаа нь дараах холбогдох сургалтын элементийг багтаасан байх ёстой:

- (1) төлөвлөсөн үйл ажиллагаанд зориулан суурилуулсан тусгай төхөөрөмжийг багтаасан, ашиглах нисэх онгоцны маяг;
- (2) төлөвлөсөн үйл ажиллагаанд тохирох нислэгийн зам болон аэродром;
- (3) багийн гишүүний томилгоо, үйл ажиллагаа, үүрэг хариуцлага болон ялангуяа хэвийн бус, эсхүл онцгой нөхцөлийн журмын хувьд, бусад багийн гишүүдийн томилгоо, үйл ажиллагаа, үүрэг хариуцлагатай хамааралтай тэдний харилцаа холбоо;
- (4) хөдөлгүүр, хүчилсэн бүтэц, эсхүл системийн доголдол, гал, эсхүл бусад хэвийн бус байдлаас шалтгаалсан бүх төрлийн онцгой нөхцөлийн болон хэвийн бус нөхцөлийн сургалт;
- (5) багийн гишүүн ашиглахад бэлэн байдаг ослын төхөөрөмжийн байрлал болон үйл ажиллагаа;
- (6) хүчилтөрөгчийн төхөөрөмжийн байрлал болон ашиглалт;
- (7) нүүлгэн шилжүүлэх гулсуур болон ослын гарцын олсыг багтаасан бүх энгийн болон ослын гарцын байрлал болон ашиглалт;
- (8) хүний хүчин зүйлийн болон багийн нөөцийн удирдлагын сургалт;
- (9) заналхийллийн болон алдааны удирдлагыг багтаасан эрсдэлийг удирдах стратегийн сургалт;
- (10) аюултай бараа тээвэрлэх ИНД-92-ын шаардлага;
- (11) ИНД-119.75-д шаардсан агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийн дагуу аюулгүйн хамгаалалтын сургалт;
- (12) гэрчилгээ эзэмшигчийн арилжааны нислэгийн үйл ажиллагааны бодлого болон журам.

121.557. Багийн гишүүний танилцах сургалт

(a) Энэ зүйлийн (b) болон (c)-г харгалзан, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд арилжааны нислэгийн үйл ажиллагаанд мэргэшээгүй ба багийн гишүүний үүрэг гүйцэтгээгүй нисгэгч, эсхүл бүхээгийн ажилтныг 121.555-д шаардсан сэдвийн задаргааны дагуу 121.553-т шаардсан сургалтын хөтөлбөрийн танилцах үе шатанд амжилттай хамрагдсан болохыг бататгах үүрэгтэй.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь, хэрэв тухайн өөрчлөлтийн дэлгэрэнгүй мэдээлэл болон шалтгааныг багийн гишүүний сургалтын бүртгэлд бүртгэж баталгаажуулдаг бол, тухайн эзэмшигчийн Ерөнхий зааварт байгаа багийн гишүүний сургалтын хөтөлбөрийн танилцах үе шатны сэдвийн задаргааг Даргын урьдчилсан зөвшөөрөлтэйгээр өөрчилж болно.

(c) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн сургалтын хөтөлбөрийн танилцах үе шатанд хүний хүчин зүйлийн болон багийн нөөцийн удирдлагын сургалт багтсан болохыг бататгах үүрэгтэй.

(d) Нисгэгч нь дараах шаардлагыг хангаагүй бол, энэ зүйлийн (a)-ийн дагуу сургалтын хөтөлбөрийн танилцах үе шатанд хамрагдахгүй:

- (1) нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн 500 цагаас доошгүй нислэгийн цагийн туршлагатай байх; эсхүл
- (2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц, гэрчилгээ эзэмшигчийн агаарын тээврийн нисгэгчийн сургалтын хөтөлбөрт амжилттай хамрагдсан байх;
- (3) хүчинтэй хэрэглэлийн зэрэглэл эзэмшдэг байх;
- (4) нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн 25 цагаас доошгүй шөнийн нислэгийн цагийн туршлагатай байх.

121.559. Багийн гишүүний шилжих сургалт

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, дараах тохиолдолд АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь мэргэшсэн бөгөөд арилжааны нислэгийн үйл ажиллагаанд багийн гишүүний үүрэг гүйцэтгэж байгаа нисгэгч, эсхүл бүхээгийн ажилтныг 121.553-т шаардсан сургалтын хөтөлбөрийн шилжих үе шатанд амжилттай хамрагдсан болохыг бататгах үүрэгтэй, хэрэв:

- (1) тухайн багийн гишүүн нь нэг нисэх онгоцны маяг, эсхүл вариантаас өөр маяг, эсхүл вариантанд шилжиж байгаа бол; эсхүл
- (2) тухайн нисэх онгоцны маяг, эсхүл вариантанд нөлөөлөхөөр тухайн үйл ажиллагааны шинж чанарт өөрчлөлт орсон, эсхүл шинэ төхөөрөмж нэвтрүүлж ашигласан бол.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан сургалтын хөтөлбөрийн шилжих үе шат нь дараах сэдвийг хамарсан байх ёстой:

- (1) тухайн нисэх онгоцны маяг, эсхүл вариантанд хамааралтай бүх аюулгүй байдлын төхөөрөмж, ослын төхөөрөмж болон журмыг ашиглах;
- (2) ашиглаж байгаа нисэх онгоцны маяг, эсхүл вариантанд ашиглаж эхэлсэн шинэ журам, эсхүл төхөөрөмж;
- (3) өөр нисэх онгоц, төхөөрөмж, эсхүл журмаас үүдэн гарсан хүний хүчин зүйлийн болон багийн нөөцийн удирдлагын шаардлагатай сургалт.

121.561. Багийн гишүүний шат ахих сургалт

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, дараах тохиолдолд АТ-ийн гэрчилгээ эзэмшигч, тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд гүйцэтгэж байгаа арилжааны нислэгийн үйл ажиллагаанд багийн гишүүний үүрэг гүйцэтгэж байгаа нисгэгч, эсхүл бүхээгийн ажилтан нь мэргэшсэн ба ижил маягийн нисэх онгоцоор 121.553-т шаардсан сургалтын хөтөлбөрийн шат ахих үе шатанд амжилттай хамрагдсан болохыг бататгах үүрэгтэй, хэрэв:

- (1) тухайн нисгэгч нь ижил маягийн нисэх онгоцны багийн гишүүний ажил үүргээс илүү хариуцлагатай багийн гишүүний өөр ажил үүрэг гүйцэтгэхээр шилжиж байгаа бол; эсхүл
- (2) тухайн бүхээгийн ажилтан нь илүү хариуцлагатай ажил үүрэг гүйцэтгэхээр дэвшиж байгаа бол.

(b) Шат ахих сургалт нь тухайн нисэх онгоцонд шат ахиж байгаа, шинэ нисэх багийн ажил үүрэгт шилжих нисгэгч, эсхүл илүү хариуцлагатай ажил үүрэгт дэвшиж байгаа бүхээгийн ажилтанд хамаарах бүх аюулгүй байдлын төхөөрөмж, ослын төхөөрөмж болон журмын ашиглалтыг хамарсан байх ба дараах сургалтыг багтаасан байх ёстой:

- (1) нисэх багийн өөр ажил үүрэг болон шинэ үүрэг хариуцлагатай холбоотой өөрчлөлтийг онцгойлон багтаасан хүний хүчин зүйл болон багийн нөөцийн удирдлагын сургалт;
- (2) хяналтын ажил үүргийн ур чадварын сургалт.

121.563. Багийн гишүүний давтан сургалт

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь багийн гишүүн үүрэг гүйцэтгэх нисэх онгоцны маяг, багийн гишүүний ажил үүрэг, үйл ажиллагааны төрөлд тухайн багийн гишүүн чадвартай байх болон мэргэшихийн тулд гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны нисгэгч, эсхүл бүхээгийн ажилтныг 121.553-т шаардсан сургалтын хөтөлбөрийн давтан сургалтын үе шатанд амжилттай хамрагдсан болохыг бататгах үүрэгтэй.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь давтан сургалтын үе шатанд нисэх багийн гишүүний дараах нислэгийн сургалт багтсан болохыг бататгах үүрэгтэй:

- (1) IFR-ийн дагуу үйлдэх арилжааны нислэгийн үйл ажиллагааны хувьд, 6 сар тутамд;
- (2) VFR-ийн дагуу үйлдэх арилжааны нислэгийн үйл ажиллагааны хувьд, 12 сар тутамд.

(c) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь 121.565-д заасан сургалтын төхөөрөмжийг ашиглан, тухайн нисгэгчийг сургалтын хөтөлбөрийн давтан сургалтын үе шатанд амжилттай хамрагдсан болохыг бататгах үүрэгтэй.

(d) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь сургалтын хөтөлбөрийн давтан сургалтын үе шатанд хүний хүчин зүйл болон багийн нөөцийн удирдлагын сургалт багтдаг болохыг бататгах үүрэгтэй.

121.565. Нисэх багийн сургалтын төхөөрөмж

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь нисэх багийн гишүүний 121.553-т шаардсан багийн гишүүний сургалтын хөтөлбөрт дараах төхөөрөмжийг ашигладаг онолын болон нислэгийн зааварчилгаа багтсан болохыг бататгах үүрэгтэй:

- (1) нислэгийн сургалтын хэрэгсэл;
- (2) ашиглаж байгаа тухайн маягийн нисэх онгоцны нислэгийн симулятор.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь түүний сургалтын хөтөлбөрт ашигладаг нислэгийн симулятор болон нислэгийн сургалтын хэрэгсэл дараах шаардлага хангасан болохыг бататгах үүрэгтэй:

- (1) гэрчилгээ эзэмшигч ашиглахыг зөвшөөрсөн байх;
- (2) тухайн сургалт, эсхүл шалгалт авч байгаа нисэх онгоцны маяг болон хэрэв хамааралтай бол тухайн маягийн тодорхой вариантын хувьд, зөвшөөрөгдсөн байх;

- (3) гүйцэтгэх тодорхой маневр, журам, эсхүл багийн гишүүний ажил үүргийн хувьд, зөвшөөрөгдсөн байх;
- (4) ИНД-119.81-д шаардсан Ерөнхий зааварт заагдсан байх.

(с) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь сургалтын хөтөлбөрийн нислэгийн сургалтад ашигладаг нислэгийн симулятор, эсхүл нислэгийн сургалтын хэрэгслийг дараах шаардлага хангасан болохыг бататгах үүрэгтэй:

- (1) зөвшөөрөл авахад шаардлагатай гүйцэтгэлийн, ажиллагааны болон бусад үзүүлэлтийг хадгалдаг байх;
- (2) зөвшөөрөл авахад шаардлагатай гүйцэтгэлийн, ажиллагааны болон бусад үзүүлэлтэд нөлөөлөх өөрчлөлтийг дуурайлгаж байгаа нисэх онгоцны модификацитай нийцэж байхаар өөрчилсөн байх;
- (3) ашиглахын өмнө, нислэгийн өмнөх үйл ажиллагааны үзлэгийг хийдэг байх ба нислэгийн үнэлгээ, эсхүл сургалтын төгсгөлд сургагч-нисгэгч, эсхүл шалгагч-нисгэгч ашиглалтын явцад илрүүлсэн үл тохирлыг бүртгэдэг байх.

(d) Нисэх багийн сургалтыг зөвхөн дан ганц сургалтад ашигладаггүй төхөөрөмж, эсхүл эх үүсвэр ашиглан зохион байгуулдаг бол АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь сургалтыг дараах байдлаар гүйцэтгэж дуусгах боломжийг бататгах зорилгоор тухайн төхөөрөмж, эсхүл эх үүсвэрийг ашиглах хангалттай бололцоотой болохыг бататгах үүрэгтэй:

- (1) төлөвлөгөөт бус тасалдалгүй;
- (2) тухайн сургалтын сэдвийн аюулгүй байдлын үр дүн болон зорилгод нийцэх таатай орчинд.

(e) Тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны хувьд, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн маягийн нисэх онгоцны нислэгийн симуляторыг сургалтын хөтөлбөрийн нисэх багийн сургалтын бүрдэл хэсэгт ашигладаг болохыг бататгах үүрэгтэй.

(f) Энэ зүйлийн (e)-г үл харгалзан, хэрэв тодорхой маягийн нисэх онгоцны хувьд, нислэгийн симулятор ашиглах боломжгүй байгаа бол, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн сургалтыг нисэх онгоцоор хийхээр сургалтын хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтийг Даргад гаргаж болно.

(g) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (f)-д заасан нисэх онгоцоор хийх сургалтыг Даргын хүлээн зөвшөөрөхүйц аюулгүй нислэг үйлдэх практик гарын авлагын дагуу гүйцэтгэж байгааг бататгах үүрэгтэй.

121.567. Нисгэгчийн шугамын нислэгийн сургалт

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь, 121.557-гийн дагуу танилцах сургалтын үе шат, эсхүл 121.559-ийн дагуу шилжих сургалтын үе шат, эсхүл 121.553-т шаардсан сургалтын хөтөлбөрийн шат ахих үе шатанд 121.561-ийн дагуу амжилттай хамрагдсан, аяллын орлон нисгэгчээс бусад нисгэгчийг дараах шаардлагыг хангасан болохыг бататгах үүрэгтэй:

- (1) энэ зүйлийн (b)-д заасан нисгэгчийн шугамын нислэгийн сургалт эхлэхийн өмнө J Бүлгийн дагуу ур чадвараа амжилттай шалгуулсан байх;

- (2) энэ зүйлийн (b)-д заасан нисгэгчийн шугамын нислэгийн сургалтад амжилттай хамрагдсан байх.
- (b) Энэ зүйлийн (a)(2)-т шаардсан нисгэгчийн шугамын нислэгийн сургалт нь дараах хэсгээс бүрдсэн байх ёстой:
- (1) дараах танилцах сургалтын үе шат:
- (i) турбо-проп олон-хөдөлгүүртэй нисэх онгоцны хувьд 10 хөөрөлт, буултыг багтаасан 20 нислэгийн цаг, үүнээс 6-гаас доошгүй хөөрөлт, буултад идэвхтэй нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн байх ёстой;
 - (ii) турбо-жэт болон турбо-фэн хөдөлгүүртэй нисэх онгоцны хувьд 10 хөөрөлт, буултыг багтаасан 25 нислэгийн цаг, үүнээс 6-гаас доошгүй хөөрөлт, буултад идэвхтэй нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн байх ёстой;
 - (iii) бүх нисэх онгоцны хувьд, энэ хэсгийн (i) болон (ii)-ыг багтаасан 4 нислэгийн цикл, үүнээс 2-оос доошгүй циклд идэвхтэй нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн байх ёстой.
- (2) дараах шилжих, эсхүл шат ахих сургалтын үе шат:
- (i) турбо-проп олон-хөдөлгүүртэй нисэх онгоцны хувьд 10 хөөрөлт, буултыг багтаасан 12 нислэгийн цаг, үүнээс 6-гаас доошгүй хөөрөлт, буултад идэвхтэй нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн байх ёстой;
 - (ii) турбо-жэт болон турбо-фэн хөдөлгүүртэй нисэх онгоцны хувьд, хөлгийн дарга нь 10 хөөрөлт, буултыг багтаасан 20 нислэгийн цаг, үүнээс 6 хөөрөлт, буултад идэвхтэй нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн байх ёстой; эсхүл хамтран нисгэгч нь 10 хөөрөлт, буултыг багтаасан 10 нислэгийн цаг, үүнээс 6-гаас доошгүй хөөрөлт, буултад идэвхтэй нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн байх ёстой;
 - (iii) бүх нисэх онгоцны хувьд, энэ хэсгийн (i) болон (ii)-ыг багтаасан 4 нислэгийн цикл, үүнээс 2-оос доошгүй нислэгийн циклд идэвхтэй нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн байх ёстой.
- (c) Энэ зүйлийн (b)-д шаардсан нисгэгчийн шугамын нислэгийн сургалтыг:
- (1) арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцон дээр хийсэн байх;
- (2) дараах багшийн хяналтад гүйцэтгэсэн байх ёстой:
- (i) 121.519-д заасан шаардлагыг хангасан; эсхүл
 - (ii) Дарга шинэ нисэх онгоцны маяг танилцуулах сургалт зохион байгуулах зөвшөөрөл олгосон.
- (d) Энэ зүйлийн (c)(1)-ийн зорилгоор, (c)(2)-т шаардсан сургагч-нисгэгч нь дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:
- (1) нислэгийн бүх хугацааны турш хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх;
 - (2) хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэх зорилгоор шугамын нислэгийн сургалтад хамрагдаж байгаа нисгэгчид хяналт тавьж байх үедээ нисгэгчийн суудал эзэлсэн байх;
 - (3) хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх зорилгоор шугамын нислэгийн сургалтад хамрагдаж байгаа нисгэгчид хяналт тавьж байх үед, тухайн нисгэгч дараах туршлагыг хуримтлуулах хүртэл нисгэгчийн суудал эзэлсэн байх:

- (i) хөлгийн даргаар мэргэшсэн байхыг шаардсан маягийн нисэх онгоцны идэвхтэй нисгэгчээр 2-оос доошгүй хөөрөлт, буулт үйлдсэн байх;
 - (ii) тухайн маягийн нисэх онгоцны даргын ажил үүрэг гүйцэтгэх чадвараа сургагч-нисгэгчид шалгуулсан байх;
- (4) хэрэв энэ хэсгийн (3)-ын шаардлагыг хангасан бол, ажиглагчийн суудал эзэлж болно.
- (е) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь 121.557-д заасан танилцах сургалтын үе шат, эсхүл 121.559-д заасан шилжих сургалтын үе шатанд амжилттай хамрагдсан аяллын орлон нисгэгчийг дараах шаардлагыг хангасан болохыг бататгах үүрэгтэй:
- (1) энэ зүйлийн (b)-д заасан нисгэгчийн шугамын нислэгийн сургалт эхлэхийн өмнө J Бүлгийн дагуу ур чадварын үнэлгээ хийлгэсэн байх;
 - (2) 6-гаас доошгүй үйл ажиллагааны хэсэгт нисгэгчийн аль нэг суудлаас аяллын орлон нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн байх;
 - (3) энэ хэсгийн (2)-т заасан нисгэгчийн шугамын нислэгийн сургалтын дараа J Бүлгийн дагуу чиглэлийн нислэгийн шалгалтыг (route check) амжилттай өгсөн байх.
- (f) Аяллын орлон нисгэгчийн хувьд, энэ зүйлийн (е)(2)-т шаардсан нисгэгчийн шугамын нислэгийн сургалт нь дараах нөхцөлд зохион байгуулагдсан байх ёстой:
- (1) 121.519-д заасан шаардлагыг хангасан сургагч-нисгэгчийн хяналтад;
 - (2) тухайн сургалтад хамаарах нисэх онгоцны тодорхой маягаар арилжааны нислэгийн үйл ажиллагаанд.

121.569. Нисгэгчийн зөөлтийн нислэг

- (a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь 121.553-т шаардсан сургалтын хөтөлбөрийн 121.557-д шаардсан танилцах үе шат болон 121.559-д шаардсан шилжих үе шат, эсхүл 121.561-д шаардсан шат ахих үе шатанд амжилттай хамрагдсан аяллын орлон нисгэгчээс бусад нисгэгчийг дараах шаардлага хангасан болохыг бататгах үүрэгтэй:
- (1) энэ зүйлийн (b)-д заасан зөөлтийн нислэг эхлэхийн өмнө 121.567-д шаардсан нисгэгчийн шугамын нислэгийн сургалтад амжилттай хамрагдаж, шилжих болон шат ахих сургалтын үе шатны хувьд, J Бүлгийн дагуу чиглэлийн нислэгийн шалгалтыг (route check) амжилттай өгсөн байх;
 - (2) зөөлтийн нислэгийн нисгэгчийн мэдлэг болон ур чадварын хувьд, энэ зүйлийн (b), (c)-гийн дагуу холбогдох багийн ажил үүрэг гүйцэтгэсэн 100 цагаас доошгүй нислэгийн цагийн туршлага, эсхүл 75-аас доошгүй нислэгийн циклийг гүйцэтгэсэн байх;
 - (3) танилцах сургалтын үе шатны хувьд, зөөлтийн нислэгийн дараа J Бүлгийн дагуу чиглэлийн нислэгийн шалгалтыг өгсөн байх.
- (b) Энэ зүйлийн (a)-д шаардсан мэдлэгийн болон ур чадварын зөөлтийн нислэг үйлдэж байгаа нисгэгч нь:
- (1) танилцах, эсхүл шилжих сургалтын үе шатанд амжилттай хамрагдсанаас хойш 120 хоногийн дотор нислэгийн 100 цаг, эсхүл 75 нислэгийн циклийг гүйцэтгэх үүрэгтэй;

- (2) зөөлтийн нислэгийн үе шатанд зөвхөн тухайн сургалтад хамаатай нэг нисэх онгоцны маягаар үйл ажиллагаа гүйцэтгэх үүрэгтэй;
 - (3) энэ зүйлийн (а)-ийн шаардлагыг хангахад, 121.567-д шаардсан нисгэгчийн шугамын нислэгийн сургалтын явцад хуримтлуулсан нислэгийн цаг, эсхүл нислэгийн циклийг тооцож болно;
 - (4) хэрэв тухайн нисгэгч нь сургалтын хөтөлбөрийн танилцах үе шатны дараа зөөлтийн нислэг гүйцэтгэж байгаа бол энэ зүйлийн (а)-д шаардсан нислэгийн туршлагыг дараах нисгэгчийн хяналтад хуримтлуулах үүрэгтэй:
 - (i) 121.517-д заасан шаардлагыг хангасан шугамын хяналтын нисгэгч; эсхүл
 - (ii) 121.519-д заасан шаардлагыг хангасан сургагч-нисгэгч; эсхүл
 - (5) хэрэв тухайн нисгэгч нь сургалтын хөтөлбөрийн шилжих, эсхүл шат ахих үе шатанд амжилттай хамрагдсаны дараа зөөлтийн нислэг үйлдэж байгаа бол энэ зүйлийн (а)-д шаардсан нислэгийн туршлагыг дараах нисгэгчийн хамт хуримтлуулах үүрэгтэй:
 - (i) 121.531(а)-д заасан шаардлагыг хангасан нисэх багийн гишүүн; эсхүл
 - (ii) 121.517(а)-д заасан шаардлагыг хангасан шугамын хяналтын нисгэгч; эсхүл
 - (iii) 121.519-д заасан шаардлагыг хангасан сургагч-нисгэгч.
- (с) Хэрэв тухайн нисгэгчийн мэдлэгийн болон ур чадварын зөөлтийн нислэгийг энэ зүйлийн (b)(1)-д шаардсаны дагуу 120 хоногийн дотор гүйцэтгэж чадаагүй бол, зөөлтийн нислэг дуусах хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж болно, хэрэв нисгэгч нь:
- (1) сургалтын хөтөлбөрийн бусад бүх шаардлагыг үргэлжлүүлэн хангаж байгаа бол;
 - (2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц сэргээх сургалтын курст, эсхүл дараах нисгэгчийн хяналтад шугамын-үйл ажиллагааны нислэгт амжилттай хамрагдсан бол:
 - (i) 121.517-д заасан шаардлагыг хангасан шугамын хяналтын нисгэгч; эсхүл
 - (ii) 121.519-д заасан шаардлагыг хангасан сургагч-нисгэгч; эсхүл
 - (iii) 121.521-д заасан шаардлагыг хангасан шалгагч-нисгэгч.

121.571. Нисэх-инженерийн зөөлтийн нислэг

- (а) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь 121.553-т шаардсан сургалтын хөтөлбөрийн 121.557-д шаардсан танилцах үе шат, эсхүл 121.559-д шаардсан шилжих үе шатанд амжилттай хамрагдсан нисэх-инженерийг гэрчилгээ эзэмшигчийн тогтоосон зөөлтийн нислэгийн хөтөлбөрийн дагуу зөөлтийн нислэг гүйцэтгэсэн болохыг бататгах үүрэгтэй.
- (b) Энэ зүйлийн (а)-д шаардсан зөөлтийн нислэгийн хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:
- (1) зөвхөн нисэх онгоцны тодорхой маягаар гүйцэтгэсэн байх минимум нислэгийн цаг, эсхүл нислэгийн циклийн тоог заах;
 - (2) зөөлтийн нислэг дуусах максимум хугацааг заах;
 - (3) зөөлтийн нислэгийн туршид хяналт тавих шаардлагыг заах;

(4) зөөлтийн нислэг дуусахад ур чадварын үнэлгээ хийх.

(с) Энэ зүйлийн (а)-д шаардсан зөөлтийн нислэгийн хөтөлбөр нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх бөгөөд гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт багтсан байх ёстой.

121.573. Бүхээгийн ажилтны сургалтын хөтөлбөр

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь 121.533 553-т шаардсан багийн гишүүний сургалтын хөтөлбөрийг бүхээгийн ажилтны дараах шаардлагыг хамардаг болохыг бататгах үүрэгтэй:

- (1) нисэх онгоцны багийн гишүүдийн эрх мэдлийн шатлалын бүтэц;
- (2) бүхээгийн ажилтны ажлын байранд оноосон ажил үүрэгт хамаатай байж болох хүний хүчин зүйл болон багийн нөөцийн удирдлагын сургалт;
- (3) онцгой нөхцөлийн үеийн багийн гишүүдийн томилгоо, үйл ажиллагаа болон үүрэг, хариуцлага;
- (4) онцгой нөхцөлийн журам болон гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааврын дагуу тусгай ангиллын зорчигчтой харьцахад дагаж мөрдөх журмыг багтаасан зорчигч үйлчилгээний журам;
- (5) зорчигчдод зааварчилгаа өгөх;
- (6) бүхээгийн ажилтан, эсхүл багийн бусад гишүүд ашиглахад бэлэн байх ослын төхөөрөмжийн байрлал болон үйл ажиллагаа;
- (7) бүхээгийн төхөөрөмжийг зөв ашиглах болон удирдах;
- (8) хүчилтөрөгчийн төхөөрөмжийн байрлал болон ашиглах;
- (9) нүүлгэн шилжүүлэх гулсуур болон ослын гарцын олсыг багтаасан бүх энгийн болон ослын гарцын байрлал болон ашиглалт;
- (10) ICAO Doc 10002 “Cabin Crew Safety Training Manual”, Chapter 9-ийн дагуу бүхээгийн эрүүл ахуй болон анхны тусламж;
- (11) гэрчилгээ эзэмшигчийн баримт бичиг болон журам;
- (12) холбогдох ИНД болон бусад дагалдах баримт бичиг.

121.575. Бүхээгийн ажилтны үйл ажиллагааны туршлага

(а) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн этгээд дараах шаардлагыг хангасан байхаас бусад тохиолдолд, арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцонд бүхээгийн ажилтны үүрэг гүйцэтгэхээр томилдоггүй болохыг бататгах үүрэгтэй:

- (1) 121.553-т шаардсан багийн гишүүний сургалтын хөтөлбөрийн холбогдох үе шатанд амжилттай хамрагдсан байх;
- (2) 121.553-т заасан сургалтын хөтөлбөрийн 121.557-д шаардсан танилцах үе шат, эсхүл 121.559-д шаардсан шилжих үе шатанд амжилттай хамрагдсаны дараа:
 - (i) тухайн маягийн нисэх онгоцонд болон тухайн этгээд үүрэг гүйцэтгэхээр томилогдсон багийн гишүүний ажил үүрэг гүйцэтгэсэн, 2-оос доошгүй

нислэгийн циклийг багтаасан, 5 цагийн шугамын-үйл ажиллагааны нислэгийн цагийн туршлага хуримтлуулсан байх; эсхүл

- (ii) энэ Дүрмийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа өөр маягийн нисэх онгоцонд болон тухайн этгээд үүрэг гүйцэтгэхээр томилогдсон багийн гишүүний ажил үүрэг гүйцэтгэсэн, бүхээгийн ажилтны үйл ажиллагааны Даргын хүлээн зөвшөөрөхүйц туршлагатай байх.

(b) энэ зүйлийн (a)(2)(i)-д шаардсан шугамын-үйл ажиллагааны нислэгийн цагийн туршлага нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- (1) 121.525-д заасан шаардлагыг хангасан сургагч-бүхээгийн ажилтны, эсхүл 121.527-д заасан шаардлагыг хангасан бүхээгийн ажилтанд үнэлгээ хийх этгээдийн хяналтан дор хуримтлуулсан байх;
- (2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц бодит хэмжээтэй, тухайн маягт тохирсон, бүхээгийн сургалтын хэрэгсэл дээр хуримтлуулсан 2.5 цагаас ихгүй нислэгийн цагийн туршлагыг багтаасан байх.

121.577. Багийн гишүүдийн сургалтын бүртгэл

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь түүний багийн гишүүний ИНД-119.67-д заасны дагуу гүйцэтгэсэн, энэ Бүлгээр шаардсан бүх сургалт болон зөөлтийн нислэгийн бүртгэлийг хадгалах үүрэгтэй.

Ж Бүлэг - Багийн гишүүдийн ур чадварт тавих шаардлага

121.601. Зорилго

Энэ Бүлэг нь I Бүлгийн дагуу сургалтад хамрагдсан нисэх багийн гишүүд болон бүхээгийн ажилтны ур чадварын үнэлгээний зохицуулалтын шаардлагыг тогтооно.

121.603. Ерөнхий зүйл

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцонд багийн гишүүний үүрэг гүйцэтгэхээр томилогдсон этгээд томилогдсон багийн гишүүний ажил үүргээ гүйцэтгэх ур чадвартай болохыг бататгах зорилгоор энэ Бүлгийн дагуу багийн гишүүний ур чадварын үнэлгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

(b) Багийн гишүүний ур чадварын үнэлгээний хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- (1) Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх;
- (2) гэрчилгээ эзэмшигчийн хяналтад байх;
- (3) тухайн нисэх онгоцны маяг, эсхүл вариантдад тохирсон байх;
- (4) 121.607(2), (3) болон (5)-д шаардсан нисэх багийн гишүүний ур чадварын үнэлгээг хийхдээ нислэгийн симуляторт гүйцэтгэсэн байх.

(с) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь:

- (1) тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд энэ зүйлийн (а)-д шаардсан багийн гишүүний ур чадварын үнэлгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж болно; эсхүл
- (2) хэрэв ИНД-141-ийн гэрчилгээ нь ур чадварын үнэлгээ хийхийг гэрчилгээ эзэмшигчид зөвшөөрдөг бол ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигчтэй энэ зүйлийн (а)-д шаардсан нисэх багийн гишүүний ур чадварын үнэлгээний хөтөлбөрийн дагуу ур чадварын үнэлгээ хийх гэрээ байгуулж болно; эсхүл
- (3) Монгол улсын гадна хийдэг ур чадварын үнэлгээний хувьд, ИНД-141-д заасантай дүйцэх стандартыг хангасан байгууллагатай энэ зүйлийн (а)-д шаардсан багийн гишүүний ур чадварын үнэлгээний хөтөлбөрт заасан холбогдох шаардлагын дагуу үнэлгээ хийх гэрээ байгуулж болно.

(d) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь нисэх багийн гишүүний ур чадварын үнэлгээний хөтөлбөрийг хариуцсан этгээдийг хүчинтэй шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшдэг болохыг бататгах үүрэгтэй.

(e) Энэ зүйлийн (b)(4)-ийг үл харгалзан, хэрэв тухайн нисэх онгоцны маягийн нислэгийн симулятор байхгүй бол, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн симулятор ашиглахгүйгээр ур чадварын үнэлгээ хийх зорилгоор тухайн нисэх онгоцны маягийн ур чадварын үнэлгээний хөтөлбөрт өөрчлөлт оруулах хүсэлтийг Даргад гаргаж болно.

(f) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (e)-д заасан ур чадварын үнэлгээг Даргын хүлээн зөвшөөрөхүйц аюулгүй нислэг үйлдэх практик гарын авлагын дагуу гүйцэтгэсэн болохыг бататгах үүрэгтэй.

(g) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (b)(4)-т заасан ур чадварын үнэлгээнд ашигладаг нислэгийн симулятор, эсхүл нислэгийн сургалтын хэрэгсэл дараах шаардлага хангасан болохыг бататгах үүрэгтэй:

- (1) зөвшөөрөл авахад шаардлагатай гүйцэтгэл, ажиллагааны болон бусад үзүүлэлтийг хадгалдаг байх;
- (2) зөвшөөрөл авахад шаардлагатай гүйцэтгэл, ажиллагааны болон бусад үзүүлэлтэд нөлөөлөх өөрчлөлтийг дуурайлгаж байгаа нисэх онгоцны модификацитай нийцэж байхаар өөрчилсөн байх;
- (3) ашиглахын өмнө, нислэгийн өмнөх үйл ажиллагааны үзлэгийг хийдэг байх ба нислэгийн үнэлгээ, эсхүл сургалтын төгсгөлд сургагч-нисгэгч, эсхүл шалгагч-нисгэгч ашиглалтын явцад илрүүлсэн үл тохирлыг бүртгэдэг байх.

121.605. Ур чадварын үнэлгээний хөтөлбөрийн үүрэг хариуцлага

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь 121.603-т шаардсан багийн гишүүний ур чадварын үнэлгээний хөтөлбөрийн нийцэл болон хэрэгжилтэд эцсийн хариуцлага хүлээх үүрэгтэй.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь ур чадварын үнэлгээнд хамрагдах багийн гишүүнийг тухайн хөтөлбөрийн дагуу үнэлгээ хийлгэсэн болохыг бататгах үүрэгтэй.

121.607. Нисэх багийн гишүүдийн ур чадварын үнэлгээ

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгах үүрэгтэй:

- (1) гэрчилгээний эрхийн хүрээнд арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны даргын үүрэг гүйцэтгэж байгаа нисгэгч өмнө үргэлжилсэн 12 сарын дотор, шалгагч-нисгэгчийн зохион байгуулсан аэродромын ур чадварын шалгалтыг багтаасан нисэх онгоцоор гүйцэтгэсэн чиглэлийн нислэгийн шалгалтыг амжилттай өгсөн байх ба тухайн шалгалт нь:
 - (i) нэг нислэгийн замын сегментийн дээгүүр хийх 1-ээс доошгүй нислэг болон нислэг үйлдэхээр сонгосон аэродромд үйлдэх 1, эсхүл түүнээс олон буултаас бүрддэг байх;
 - (ii) гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны тодорхойлолтод зөвшөөрсөн арилжааны нислэгийн үйл ажиллагааны төрөлд тохирсон арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны даргын үүрэг болон хариуцлагыг амжилттай гүйцэтгэж чадах нисгэгчийг тогтоодог байх;
- (2) VFR-ийн дагуу арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэж байгаа нисгэгчийг өмнө үргэлжилсэн 12 сарын дотор, шалгагч-нисгэгчийн зохион байгуулсан дараах сэдвийг хамарсан ур чадварын үнэлгээг амжилттай хийлгэсэн байх:
 - (i) онцгой нөхцөлийн журмыг багтаасан журам;
 - (ii) тухайн нисгэгч арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ихэвчлэн ашигладаг нисэх онгоцны маягаар тухайн нисгэгчийн нисэх ур чадвар;
 - (iii) хүний хүчин зүйл болон багийн нөөцийн удирдлага;
- (3) IFR-ийн дагуу арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэж байгаа нисгэгч өмнө үргэлжилсэн 6 сарын дотор, шалгагч-нисгэгчийн зохион байгуулсан дараах ур чадварын үнэлгээг амжилттай хийлгэсэн байх:
 - (i) гэрчилгээ эзэмшигч тухайн нисгэгчийг томилсон үйл ажиллагааны төрөл болон нисэх онгоцонд суурилуулсан төхөөрөмжтэй холбоотой онцгой нөхцөлийн журмыг багтаасан журмуудыг хамарсан;
 - (ii) хүний хүчин зүйл болон багийн нөөцийн удирдлагыг багтаасан;
- (4) арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэж байгаа нисгэгч өмнө үргэлжилсэн 12 сарын дотор, нисгэгчийн дараах онолын бичгэн, эсхүл аман шалгалтыг амжилттай өгсөн байх:
 - (i) холбогдох иргэний нисэхийн дүрэм;
 - (ii) гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны тодорхойлолт болон Ерөнхий заавар;
 - (iii) тухайн нисгэгчийн ихэвчлэн нисдэг нисэх онгоцны маягийн хувьд, тухайн нисэх онгоцны систем, үзүүлэлт, үйл ажиллагааны журам болон нислэгийн зааврын агуулга;
 - (iv) навигаци, НХҮ болон цаг уур;
 - (v) тухайн нисгэгчийн ихэвчлэн гүйцэтгэдэг үйл ажиллагааны төрөлд хамаарах тусгай нислэгийн үйл ажиллагаа;
 - (vi) шинэ төхөөрөмж, журам болон арга барил;

- (vii) тухайн нисгэгчийн ихэвчлэн нисдэг маягийн нисэх онгоцонд суурилуулсан ослын төхөөрөмжийн байрлал болон үйл ажиллагаа;
- (5) арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэж байгаа нисэх-инженер өмнө үргэлжилсэн 12 сарын дотор, шалгагч-нисэх-инженерийн зохион байгуулсан тухайн нисэх онгоцонд суурилуулсан төхөөрөмжтэй холбоотой онцгой нөхцөлийн журам, хүний хүчин зүйл, багийн нөөцийн удирдлага болон гэрчилгээ эзэмшигчийн томилсон нисэх-инженерийн үйл ажиллагааны төрлийг багтаасан журмыг хамарсан ур чадварын үнэлгээг амжилттай хийлгэсэн байх;
- (6) арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэж байгаа нисэх-инженер өмнө үргэлжилсэн 12 сарын дотор, дараах нисэх-инженерийн мэдлэгийн бичгэн, эсхүл аман шалгалтыг амжилттай өгсөн байх:
- (i) холбогдох иргэний нисэхийн дүрэм;
 - (ii) гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны тодорхойлолт болон Ерөнхий заавар;
 - (iii) нисэх-инженер ихэвчлэн томилогддог нисэх онгоцны маягийн хувьд, нисэх онгоцны систем, үзүүлэлт, үйл ажиллагааны журам болон нислэгийн зааврын агуулга;
 - (iv) нисэх-инженер ихэвчлэн томилогддог үйл ажиллагааны төрөлд хамаарах тусгай нислэгийн үйл ажиллагаа;
 - (v) шинэ төхөөрөмж, журам болон аргачлал.

121.609. Сургагч-нисгэгч, шугамын хяналтын нисгэгч, симуляторын багш болон шалгагч-нисгэгчийн ур чадварын үнэлгээ

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь сургалт, эсхүл ур чадварын үнэлгээний хөтөлбөрт сургагч-нисгэгч, шугамын хяналтын нисгэгч, симуляторын багш, эсхүл шалгагч-нисгэгчийн үүрэг гүйцэтгэж байгаа нисгэгч дараах шаардлагад нийцсэн зааварчилгаа авсан ба ур чадвараа хадгалж байгааг бататгах үүрэгтэй:

- (1) тухайн нисэх онгоцны маягийн, эсхүл вариантын аюулгүй үйл ажиллагааг хэрхэн бататгах болон хэрхэн гүйцэтгэх талаар зааварчилгаа өгөх арга;
- (2) хүний хүчин зүйл болон багийн нөөцийн удирдлагыг багтаасан тухайн нисэх онгоцны үйл ажиллагааны техникийн болон техникийн бус асуудлаар багийн гишүүний ур чадварыг дүгнэх болон үнэлгээ хийх арга;
- (3) буруу удирдсан, хэвийн бус болон онцгой нөхцөлийн маневраас нисэх онгоцыг хэвийн үйл ажиллагаанд оруулах арга;
- (4) хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн дагуу гүйцэтгэх нислэгийн үйл ажиллагаа, журам болон маневрыг багтаасан, ашиглаж байгаа нисэх онгоц, эсхүл Даргын зөвшөөрсөн нислэгийн симулятор болон тухайн төхөөрөмжийн үйл ажиллагаа.

121.611. Бүхээгийн ажилтны ур чадварын үнэлгээ

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны багийн гишүүний үүрэг гүйцэтгэж байгаа бүхээгийн ажилтныг өмнө үргэлжилсэн 12 сарын дотор, тухайн этгээдэд оноосон үүрэг хариуцлагатай холбоотой дараах сэдвийг хамарсан, 121.527-д заасан шаардлагыг хангасан бүхээгийн ажилтанд үнэлгээ хийх этгээдийн зохион байгуулсан нислэгийн үнэлгээг багтаасан ур чадварын үнэлгээг амжилттай хийлгэсэн болохыг бататгах үүрэгтэй:

- (1) хөлгийн даргын эрх;
- (2) аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй этгээдтэй харьцах журмыг багтаасан зорчигч үйлчилгээний журам;
- (3) бусдын туслалцаа шаардлагатай этгээдийн нүүлгэн шилжүүлэлтийг багтаасан онцгой нөхцөлийн үеийн багийн гишүүний томилгоо, үйл ажиллагаа болон үүрэг хариуцлага;
- (4) хүний хүчин зүйл болон багийн нөөцийн удирдлага;
- (5) зорчигчид өгөх зааварчилгаа;
- (6) бүхээгийн төхөөрөмж болон удирдлага;
- (7) ослын төхөөрөмжийн эд зүйлийн байрлал болон ажиллагаа;
- (8) хүчилтөрөгчийн төхөөрөмжийн байрлал болон ажиллагаа;
- (9) нүүлгэн шилжүүлэх гулсуур болон ослын гарцын олсыг багтаасан бүх энгийн болон ослын гарцын байрлал болон ашиглалт;
- (10) туслалцаа шаардлагатай байж болзошгүй этгээдийг суулгах;
- (11) ICAO Doc 10002 Cabin Crew Safety Training Manual, Chapter 9-ийн дагуу бүхээгийн эрүүл ахуй болон анхны тусламж;
- (12) бүхээгийн ахлах ажилтан болон түүний орлогчийн хувьд, үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бусад бүхээгийн ажилтанд хяналт тавих чадвар.

121.613. Ур чадварын болон шалгалтын бүртгэл

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь ИНД-119.67-гийн дагуу тогтоосон журмын дагуу түүний багийн гишүүний өгсөн бүх ур чадварын үнэлгээ, чиглэлийн нислэгийн шалгалт болон тестийн үнэн зөв бүртгэлийг хөтөлж, хадгалах үүрэгтэй.

К Бүлэг - Багийн гишүүдийн ажил, амралтын цагийн зохицуулалт

121.801. Зорилго

Энэ Бүлэг нь арилжааны нислэгийн үйл ажиллагаанд оролцож байгаа нисэх онгоцны багийн гишүүдийн алжаал ядаргааг багасгах зорилгоор нислэгийн цагийн хязгаарлалт болон бусад шаардлагыг тогтооно.

121.803. Үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэг хариуцлага

(a) Нисэх онгоцоор үйл ажиллагаа эрхлэгч нь нь дараахаас бусад тохиолдолд, нисэх онгоцоор арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхгүй, эсхүл гүйцэтгэхийг зөвшөөрөхгүй байх үүрэгтэй:

- (1) нисэх онгоцны багийн гишүүнээр нисэж байгаа этгээдийн нислэгийн болон ажил үүргийн цагийн зохицуулалтын хуваарийг тогтоосон байх;
- (2) тухайн хуваарьт үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагааны төрөлд тохирсон дараах хүчин зүйлийг заасан байх:
 - (i) нислэгийн өмнөх амралтын хугацаа;
 - (ii) тухайн орчинд дасан зохицох;
 - (iii) цагийн бүс;
 - (iv) шөнийн үйл ажиллагаа;
 - (v) нислэгийн үе шатны максимум тоо;
 - (vi) ганц нисгэгчтэй үйл ажиллагаа;
 - (vii) хоёр нисгэгчтэй үйл ажиллагаа;
 - (viii) хоёр нисгэгч дээр нэмэгдэх нэмэлт нисэх багийн гишүүн;
 - (ix) нисэх багийн гишүүний мэргэшил;
 - (x) хамтатгасан ажил үүрэг;
 - (xi) нислэгийн үүрэг гүйцэтгэхийн өмнө, эсхүл дараа зорчигчоор аялах (dead-head transportaion);
 - (xii) нөөцөд, эсхүл хүлээлгэд бэлэн байх хугацаа;
 - (xiii) нислэгийн үүрэг гүйцэтгэх хугацаа (flight duty period);
 - (xiv) нислэгийн үед амрах (in-flight relief);
 - (xv) үйл ажиллагааны төрөл;
 - (xvi) нийт үүрэг гүйцэтгэх цаг;
 - (xvii) нийт нислэгийн цаг;
 - (xviii) нислэгийн цагийн хязгаарлалт, эсхүл нислэгийн үүрэг гүйцэтгэх хугацааны хязгаарлалт, эсхүл аль алийг нь тусгай шийдвэрээр нэмэгдүүлэх;
 - (xix) биоритм (Circadian Rhythm);
 - (xx) амралтын өдөр;
 - (xxi) бүртгэл хөтлөлт;
- (3) тухайн хуваарь нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх.

(b) Арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцоор үйл ажиллагаа эрхлэгч нь хэрэв аливаа этгээд нислэгийн үед нисэх онгоц, эсхүл түүний бүхээгт байгаа хүмүүсийн аюулгүй байдалд аюул учруулж болохоор алжааж ядарсан, эсхүл тухайн гүйцэтгэх нислэгийн нөхцөл байдлаас шалтгаалан ядарч болохыг мэдэж

байгаа, эсхүл ядарна гэж үзэх шалтгаан байгаа бол тухайн этгээдийг нисэх онгоцонд багийн гишүүнээр томилдоггүй, эсхүл нисэхийг зөвшөөрдөггүй байх үүрэгтэй.

(с) Арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцоор үйл ажиллагаа эрхлэгч нь дараах үүрэгтэй:

- (1) багийн гишүүний нислэгийн цаг болон үүрэг гүйцэтгэх цагийн үнэн зөв бүртгэлийг хадгалах;
- (2) энэ зүйлийн (с)(1)-д шаардсан нислэгийн цаг болон үүрэг гүйцэтгэх цагийн бүртгэлийг тухайн бүртгэл хийсэн өдрөөс хойш 12 сарын хугацаанд хадгалах.

121.805. Нисэх багийн гишүүний үүрэг хариуцлага

(а) Хэрэв тухайн этгээд нисэх онгоц, эсхүл түүний бүхээгт байгаа хүмүүсийн аюулгүй байдалд аюултай байж болохоор ядарсан, эсхүл тухайн гүйцэтгэх нислэгийн нөхцөлөөс шалтгаалан ядарна гэдгээ мэдэж байгаа, эсхүл ийм сэжиг байгаа бол, тухайн этгээд нь арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэхгүй байх үүрэгтэй.

(b) Арилжааны нислэгийн үйл ажиллагаан дээр нэмж нисэх болон ажил үүрэг гүйцэтгэх нь нисэх багийн гишүүнд хамаарах 121.803(а)(1)-д шаардсан хуваарьт заасан нислэгийн болон ажил үүргийн цагийн хязгаарлалтаас хэтрэх бол, тухайн нисэх багийн гишүүн нь агаарын тээвэрлэгчид үндсэн ажилтнаар, эсхүл гэрээгээр ажиллаж байхдаа бусад хөлс, эсхүл шан урамшуулалтай нислэгт үүрэг гүйцэтгэхгүй байх үүрэгтэй.

(с) Аливаа этгээд 121.803(а)(1)-ээр шаардсан, түүнд хамаарах хуваарьт заасан хязгаарлалт хэтрээгүй болохыг бататгаснаас бусад тохиолдолд, тухайн этгээд нь арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэхгүй байх үүрэгтэй.

(d) Хэрэв нислэг эхлэхэд, тухайн этгээдийн арилжааны нислэгийн үйл ажиллагааны өмнөх болон төлөвлөсөн нислэгийн нийт цаг нь дараах хязгаарлалтаас хэтэрсэн бол, тухайн этгээд нь арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэхгүй байх үүрэгтэй:

- (1) тухайн нислэг эхлэх өдрийг багтаасан дараалсан 28 хоногт - 100 цаг; эсхүл
- (2) тухайн нислэг эхлэх өдрийг багтаасан дараалсан 365 хоногт - 1000 цаг.

(3) 60-аас дээш настай нисэх багийн гишүүний хувьд, нислэгийн нийт цаг нь энэ зүйлийн (d)(1), (2)-т заасан хязгаарлалтын 80%-иас ихгүй байна. (ИНД-125-д адилхан)

121.807. Бүхээгийн ажилтны ажил, амралтын цагийн зохицуулалт

(а) Бүхээгийн ажилтан нь дараах үүрэг гүйцэтгэх цагийн хязгаарлалтыг хэтрүүлэн арилжааны нислэгийн үйл ажиллагаанд оролцож байгаа нисэх онгоцны багийн гишүүний үүрэг гүйцэтгэхгүй байх үүрэгтэй:

- (1) дараалсан 28 хоногт - 110 цаг; эсхүл
- (2) дараалсан 365 хоногт - 1100 цаг.

(b) Арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцоор үйл ажиллагаа эрхлэгч нь хэрэв 121.539(a)(4)-д заасан бүхээгийн ажилтны минимум тооноос олон бүхээгийн ажилтныг тухайн нислэгт томилдог бол, энэ зүйлийн (a)(1)-д заасан хязгаарлалтыг дараалсан 2 сарын хугацаанд 120 цаг хүртэл нэмэгдүүлж болно.

L Бүлэг - Заавар, бүртгэлийн дэвтэр болон бүртгэл

121.851. Зорилго

Энэ Бүлэг нь арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхэд шаардлагатай заавар, нислэгийн дэвтэр болон бүртгэлийг ашиглах, хадгалах зохицуулалтын шаардлагыг тогтооно.

121.853. Үйл ажиллагааны мэдээлэл

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн өмнөх төлөвлөлтийн болон нислэгийн үед, багийн гишүүдийн ажил үүрэгтэй холбоотой гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааврын хэсэг хүчинтэй ба нисэх багийн гишүүд түүнийг ашиглах боломжтой болохыг бататгана.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь түүний нислэгийн үйл ажиллагааны ажилтнууд хэрэгжүүлэхээр өгөгдсөн, AIP-ын мэдээллийг зөв татаж авсан ба хүчинтэй болохыг бататгана.

(c) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн Улс гаргаагүй нислэгийн зураг (chart) болон нислэгийн баримт бичгийг ашиглахаар сонгосон бол тухайн баримт бичиг нь агуулгын хувьд, холбогдох Улсын баримт бичигтэй ижил болохыг бататгана.

(d) Арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь дээрх баримт бичигт хийгдсэн аливаа нэмэлт, өөрчлөлтийг зохих ёсоор үйлдсэн ба хүчинтэй хэвээр байгааг бататгана.

121.855. Бүхээгт авч явах баримт бичиг

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь арилжааны нислэгийн үйл ажиллагаанд дараах баримт бичгийг авч явдаг болохыг бататгах үүрэгтэй:

- (1) нислэгийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дэлгэрэнгүй;
- (2) тухайн нислэгийн үйл ажиллагаанд хамаарах NOTAM болон **нисэхийн мэдээллийн үйлчилгээ НМУ**-ний зааварчилгааны баримт бичиг;
- (3) тухайн нислэгийн үйл ажиллагаатай холбоотой цаг уурын мэдээ;
- (4) ачааллын манифестийн хуулбар;
- (5) аюултай барааны мэдэгдэл;
- (6) холбогдох нислэгийн зургийн хуулбар;
- (7) тогтмол агаарын тээврийн үйлчилгээний хувьд, нисэж байгаа бүх чиглэл болон ашиглаж болох бэлтгэл аэродромыг хамарсан нислэгийн замын гарын авлага.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (a)(6)-д заасан баримт бичгийн тусдаа хуулбарыг тухайн нислэгт нисэх багийн үүрэг гүйцэтгэж байгаа нисгэгч авч хэрэглэхэд бэлэн байгааг бататгах үүрэгтэй.

121.857. Үйл ажиллагааны бүртгэл

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь гүйцэтгэж байгаа арилжааны нислэгийн үйл ажиллагааны хувьд дараах бүртгэлийг үнэн зөв хөтөлнө:

- (1) тухайн нислэгийн үйл ажиллагааны төлөвлөсөн асуудал;
- (2) тухайн нислэгийн үйл ажиллагааны бодит гүйцэтгэл.

(b) Тухайн бүртгэл нь байнгын арилдаггүй хэлбэртэй байна.

121.859. Хадгалалтын хугацаа

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах мэдээллийг бүртгэсэн өдрөөс хойш 12 сарын хугацаанд хадгалдаг болохыг бататгана:

- (1) үйл ажиллагааны бүртгэл;
- (2) ачааллын манифест;
- (3) аюултай барааны мэдэгдэл.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь нисэх багийн гишүүдийн нислэгийн болон үүрэг гүйцэтгэх цагийн бүртгэлийг тухайн бүртгэл хийгдсэн өдрөөс хойш 12 сарын хугацаанд хадгалдаг болохыг бататгана.

(c) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь багийн гишүүний сургалт, шалгалт болон мэргэшлийн бүртгэлийг, тухайн багийн гишүүн гэрчилгээ эзэмшигчийн ажилтан байхаа больсноос хойш 12 сар хүртэл хугацаанд хадгалдаг болохыг бататгана.

М Бүлэг - Мэргэшил дээшлүүлэх хөтөлбөр

121.901. Зорилго

Энэ Бүлэг нь багийн гишүүд болон бусад ажилтныг мэргэшүүлэх, сургах, гэрчилгээжүүлэх болон бусад хэлбэрээр ур чадварыг нь бататгах зорилгоор мэргэшил дээшлүүлэх хөтөлбөрийн хэрэгжилт болон үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг тогтооно.

121.903. Ерөнхий зүйл

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь энэ Бүлгийн дагуу мэргэшил дээшлүүлэх хөтөлбөр, эсхүл I Бүлгийн дагуу сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь энэ Бүлгийн дагуу хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ одоо ашиглаж байгаа сургалтын хөтөлбөрөөс мэргэшил дээшлүүлэх хөтөлбөрт шилжих шилжилтийн төлөвлөгөөг гаргана.

(с) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн хөтөлбөрийг төхөөрөмж болон ажилтан, эсхүл гуравдагч этгээдэд хүлээн зөвшөөрөгдөхүйц бус эрсдэлгүйгээр, аюулгүй гүйцэтгэдэг болохыг бататгана.

(d) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн хөтөлбөрийг хариуцсан этгээдийг шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшдэг болохыг бататгана.

(e) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн хөтөлбөрийг гэрчилгээ эзэмшигч хянадаг болохыг бататгана.

(f) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь энэ Бүлэгт хамааралтай бүх этгээдийг тухайн хөтөлбөрийн бүх шаардлагыг хангаж байгааг бататгана.

(g) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь мэргэшил дээшлүүлэх хөтөлбөр нь дараах бүх ажлын байрыг хамарсан болохыг бататгана:

- (1) нисэх багийн гишүүд;
- (2) багш-нисгэгч;
- (3) шалгагч-нисгэгч;
- (4) дүгнэгч-нисгэгч.

(h) Энэ зүйлийн (g)-д ажлын байр нь заагдаагүй тохиолдолд, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь бүхээгийн ажилтан болон бусад нислэгийн үйл ажиллагааны ажилтнуудын тухайн ажлын байр нь мэргэшил дээшлүүлэх хөтөлбөрт багтсан болохыг бататгана.

121.905. Хөтөлбөрт өөрчлөлт оруулах

(a) Мэргэшил дээшлүүлэх сургалтын сэдвийг тогтоож, эсхүл өөрчилдөг АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн сургалтын сэдэв Даргын хүлээн зөвшөөрөхүйц болох хүртэл Н, I, болон J Бүлгийг дагаж мөрдөнө.

(b) Хэрэв Дарга АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхгүй байгааг тогтоосон бол, гэрчилгээ эзэмшигчид дараах шаардлагыг тавьж болно:

- (1) Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр хөтөлбөртөө өөрчлөлт оруулах; эсхүл
- (2) мэргэшил дээшлүүлэх хөтөлбөрийг I болон J Бүлгийн шаардлагыг хангасан сургалтын хөтөлбөрөөр солих.

(c) Хэрэв энэ зүйлийн (b)-гийн заалтыг хэрэгжүүлэх бол, Дарга АТ-ийн гэрчилгээ эзэмшигчээс одоо мөрдөж байгаа мэргэшил дээшлүүлэх хөтөлбөрөөс өөр хөтөлбөрт шилжих Даргын хүлээн зөвшөөрөхүйц төлөвлөгөөг шаардаж болно.

121.907. Хөтөлбөрийн сэдэв

(a) Мэргэшил дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн хөтөлбөрт дараах сэдэв багтсан болохыг бататгана:

- (1) энэ Бүлэгт шаардсан;
- (2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн хөтөлбөрийн сэдэв нь дараах шаардлага хангасан болохыг бататгана:

- (1) тухайн сэдвээр солигдож болох ИНД-61, эсхүл ИНД-121-ийн I болон J Бүлгийн шаардлагын аль холбогдохыг харуулсан байх;
- (2) тухайн сэдвээр солигдож болох ИНД-61, эсхүл ИНД-121-ийн I болон J Бүлгийн шаардлага бүрийн хувьд, тухайн сэдэв нь аюулгүй байдлын дүйцэх түвшнийг хэрхэн хангахыг харуулсан байх;
- (3) тухайн сэдэвт тусгайлан тусгаагүй ИНД-61, эсхүл ИНД-121-ийн I болон J Бүлгийн холбогдох шаардлагыг багтаасан байх;
- (4) дараах мэдээллийг заасан байх:
 - (i) хийц, загвар болон нисэх онгоцны маяг, эсхүл вариант;
 - (ii) тухайн сэдэвт хамрагдах нисэх багийн гишүүд болон бусад этгээдийн ажил үүрэг.

121.909. Шаардлагатай сэдвийн агуулга

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь түүний мэргэшил дээшлүүлэх хөтөлбөр үзэл баримтлалын, мэргэшүүлэх болон мэргэшил хадгалахад зориулсан тусдаа сэдэвтэй болохыг бататгана.

(b) Үзэл баримтлалын сургалтын сэдвийг мэргэшээгүй, гэрчилгээ эзэмшигчийн гэрчилгээнд зөвшөөрсөн албан тушаалын ажил үүрэг гүйцэтгээгүй этгээдэд дараах мэдээлэл өгдгийг бататгах хэлбэрээр боловсруулсан байна:

- (1) гэрчилгээ эзэмшигчийн бодлого болон үйл ажиллагааны практик арга барил;
- (2) үйл ажиллагааны ерөнхий мэдлэг;
- (3) тухайн этгээдийн ажлын байранд зайлшгүй шаардлагатай нисэхийн ерөнхий мэдлэг, тусгай мэдээлэл.

(c) Мэргэшүүлэх сургалтын сэдвийг гэрчилгээ эзэмшигчийн гэрчилгээнд зөвшөөрсөн албан тушаалын ажил үүрэг гүйцэтгэж байгаа, мэргэшээгүй этгээд бүр томилогдсон ажил үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай стандартын дагуу техникийн сургалтад хамрагдаж, дүгнэлт гаргуулан, гэрчилгээждэг болохыг бататгах зорилгоор боловсруулсан байна.

(d) Мэргэшил хадгалах сургалтын сэдвийг гэрчилгээ эзэмшигчийн гэрчилгээнд зөвшөөрсөн албан тушаалын үүрэг гүйцэтгэж байгаа, өмнө бэлтгэгдэж мэргэшсэн этгээд бүр тухайн ажлын байрны тогтмол сургалтад хамрагддаг ба шаардлагатай стандартын дагуу оноосон ажил үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэдэг болохыг бататгах зорилгоор боловсруулсан мэргэшүүлэх давтамжид үндэслэсэн байна.

121.911. Үзэл баримтлалын сургалтын сэдэв

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь үзэл баримтлалын сургалтад дараах сэдэв багтсан болохыг бататгана:

- (1) тухайн хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдаж байгаа ажилтны хувьд, гэрчилгээ эзэмшигчийн бодлого, үйл ажиллагааны практик арга барил болон ерөнхий үйл ажиллагааны мэдлэг;

- (2) тухайн хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдаж байгаа нисэх багийн гишүүн болон нислэгийн үйл ажиллагааны ажилтнуудын хувьд, энэ зүйлийн (1) дээр нэмж ерөнхий нисэхийн мэдлэг;
- (3) тухайн хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдаж байгаа багшийн хувьд, энэ хэсгийн (1) дээр нэмж:
 - (i) заах ба сургах арга зүйн суурь зарчим;
 - (ii) заах арга зүйн онол болон аргачлал;
 - (iii) мэргэшил дээшлүүлэх сургалтын сэдэвт нисэх онгоц, нислэгийн сургалтын хэрэгсэл, нислэгийн симулятор болон бусад сургалтын төхөөрөмжийг ашиглахад шаардлагатай мэдлэг;
- (4) тухайн хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдаж байгаа шалгагч-нисгэгч болон дүгнэгч-нисгэгчийн хувьд, энэ зүйлийн (1) дээр нэмж:
 - (i) батлагдсан хичээлийн сэдэв бүрээр дүгнэлт хийхэд тавих шаардлага;
 - (ii) багийн гишүүд болон нислэгийн үйл ажиллагааны ажилтнуудыг дүгнэх арга;
 - (iii) тухайн мэргэшил дээшлүүлэх хөтөлбөрийн сэдэв бүрээр дүгнэлт хийхэд ашигладаг бодлого болон аргачлал.

121.913. Мэргэшүүлэх сургалтын сэдэв

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь мэргэшүүлэх сургалтын сэдэвт дараах шаардлага багтсан болохыг бататгах үүрэгтэй:

- (1) тухайн хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдаж байгаа этгээдийн хувьд:
 - (i) гэрчилгээ эзэмшигчийн сургалт, дүгнэлт болон хяналттай хийгдэх үйл ажиллагааны туршлага хуримтлуулах төлөвлөсөн цаг;
 - (ii) хүн бүрийн ажлын байрны онцлогт хамаарах сургалт, мэргэшил болон гэрчилгээжүүлэлтийн үйл ажиллагааны жагсаалт;
 - (iii) хүн бүрийн ажлын байрны онцлогт хамаарах сургалт, мэргэшил болон гэрчилгээжүүлэлтийн үйл ажиллагааны тайлбар мэдээлэл.
- (2) тухайн хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдаж байгаа багийн гишүүд болон нислэгийн үйл ажиллагааны ажилтнуудын хувьд, энэ зүйлийн (а)(1) дээр нэмж гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг тогтоож, дэлгэрэнгүй заах үүрэгтэй:
 - (i) тодорхой хийц, загвар болон серийн нисэх онгоц, эсхүл вариантын үйл ажиллагаатай холбоотой ажил үүрэг гүйцэтгэх албан тушаалд, эсхүл гүйцэтгэх үүрэгт, тухайн этгээдийг тусгайлан мэргэшүүлэх нисэх онгоц болон төхөөрөмжийн сургалт, дүгнэлт болон гэрчилгээжүүлэлтийн ажиллагаа;
 - (ii) мэдлэгт тавих шаардлага, сургалтын материал, ажлын ур чадвар болон сурсан ба дүгнүүлсэн байх шаардлагатай бүх маневр болон журам;
 - (iii) ИНД-61-ийн шаардлага дээр нэмж, эсхүл түүнийг хэрэгжүүлэх практик тестийн шаардлага болон хяналттай үйл ажиллагааны туршлага хуримтлуулах жагсаалт болон тайлбар мэдээлэл;
- (3) хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдаж байгаа багшийн хувьд, энэ зүйлийн (а)(1)-ийн шаардлага дээр нэмж, гэрчилгээ эзэмшигч нь тодорхой хийц, загвар болон сери, эсхүл вариантын нисэх онгоцыг хэрхэн ажиллуулах болон аюулгүй үйл

ажиллагааг бататгах зааварчилгаа өгөх этгээдийг мэргэшүүлэх сургалт болон дүгнэлтэд ашигласан дэлгэрэнгүй мэдээллийг бичиж, тайлбарлах үүрэгтэй;

- (4) хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдаж байгаа шалгагч-нисгэгч болон дүгнэгч-нисгэгчийн хувьд, энэ зүйлийн (а)(1)-ийн шаардлага дээр нэмж, гэрчилгээ эзэмшигч нь тодорхой хийц, загвар болон сери, эсхүл вариантын нисэх онгоцыг ажиллуулах, эсхүл аюулгүй үйл ажиллагааг бататгах ажилтны ур чадварт дүгнэлт хийх этгээдийг мэргэшүүлэх тусгайлан шаардлагатай нисэх онгоц, төхөөрөмжийн сургалт, дүгнэлт болон гэрчилгээжүүлэлтийн ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг бичиж, тайлбарлах үүрэгтэй.

121.915. Мэргэшил хадгалах сургалтын сэдэв

Мэргэшүүлэх давтамж

(а) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь мэргэшил хадгалах сургалтын сэдвийг дараах шаардлагад нийцсэн мэргэшүүлэх давтамжид суурилсан болохыг бататгана:

- (1) үе шат бүрийн үед, тухайн хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдаж байгаа этгээд нь үндсэн мэргэшилд шаардлагатай бүх тохиолдол болон сэдвийн, зохистой харьцааг хослуулсан сургалтад хамрагдаж болон дүгнэлт хийлгэдэг байх;
- (2) тухайн хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдаж байгаа этгээд нь үндсэн мэргэшилд шаардлагатай минимум мэргэжлийн ур чадвар, мэдлэгийн түвшин, ур чадвар болон зан чанарыг хангасан байх;
- (3) тухайн хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдаж байгаа нисэх багийн гишүүд нь ИНД-61.37-д заасан туршлага хадгалах шаардлагыг хангасан байх.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь мэргэшил хадгалах сургалтын давтамжийн хугацааг эхний үе шатанд хуанлийн 26 сараас хэтрэхгүй байхыг бататгах ба хэрэв Дарга хүлээн зөвшөөрөхүйц бол, үүний дараа мэргэшил хадгалах сургалтын давтамжийг дараах тохиолдолд, сунгаж болно, хэрэв:

- (1) гэрчилгээ эзэмшигч сунгалт хийх хангалттай үндэслэлийг харуулсан бол;
- (2) сунгалтыг хуанлийн 3 сараас хэтрүүлэн нэмээгүй бол;
- (3) мэргэшил хадгалах сургалтын давтамж нь максимум хуанлийн 29 сараас хэтрээгүй бол.

(c) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч мэргэшил хадгалах сургалтын сэдэв нь, мэргэшил хадгалах шаардлагыг хангаагүй багийн гишүүн, нисэх онгоцны диспатчер, эсхүл бусад нислэгийн үйл ажиллагааны ажилтнуудыг дахин мэргэшүүлэх шаардлагыг багтаасан болохыг бататгана.

Мэргэшил хадгалах дүгнэлтийн хугацаа

(d) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь мэргэшил хадгалах сургалтын давтамж бүрд мэргэшил дээшлүүлэх хөтөлбөрийн дагуу мэргэшсэн этгээдийг сургалтын байгууллагад нэгээс доошгүй удаа сургалтын хичээлд хамрагдан, мэргэжлийн ур чадварын дүгнэлт хийлгэх дүгнэлтийн хугацааг багтаасан болохыг бататгана.

(e) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (d)-д шаардсан дүгнэлтийн хугацааг эхний үе шатанд хуанлийн 13 сараас хэтрэхгүй байхыг бататгах ба хэрэв Дарга хүлээн

зөвшөөрөхүйц бол, дараах тохиолдолд, мэргэшил хадгалах сургалтын давтамжийг сунгаж болно, хэрэв:

- (1) гэрчилгээ эзэмшигч сунгалт хийх хангалттай үндэслэлийг харуулсан бол;
- (2) сунгалтыг хуанлийн 3 сараас хэтрүүлэн нэмээгүй бол;
- (3) тухайн дүгнэлтийн хугацаа нь максимум хуанлийн 26 сараас хэтрээгүй бол.

Сургалтын хичээлийн дүгнэлтийн хугацаа

(f) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч, сургалтын хичээл, түүний тоо болон давтамжийг агуулсан энэ зүйлийн (d)-д шаардсан дүгнэлтийн хугацаа нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой болохыг бататгана.

(g) Тухайн хичээлийн үед хийсэн мэргэжлийн ур чадварын дүгнэлтийг багтаасан сургалтын хичээлийг, шалгалтын сүүлчийн хугацаа дуусахаас 60 хоногийн өмнөх аль ч хугацаанд хийсэн бол тухайн АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийг шаардсан дүгнэлтийн хугацаанд нь хийлгэсэнд тооцно.

(h) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдаж байгаа этгээд сургалтын хичээлийн явцад дараах мэдлэгийг олж авсан болохыг бататгана:

- (1) хөлгийн дарга, хамтран нисгэгч, нисэх-инженер, багш болон дүгнэгч-нисгэгчийн хувьд, дараах сэдвийг багтаасан үндсэн мэргэшилд нь шаардлагатай бүх хичээл болон үндсэн сэдвийн сургалт:
 - (i) мэргэшүүлэх сургалтаар олж авдаг мэдлэг болон ур чадварын ерөнхий дүгнэлтийг багтаасан газрын бэлтгэл сургалт;
 - (ii) шинээр боловсруулсан журам болон аюулгүй байдлын мэдээллийн шинэчилсэн мэдээлэл;
- (2) багийн гишүүд, нисэх онгоцны диспатчер, багш, дүгнэгч-нисгэгч болон бусад нислэгт ажил үүрэг гүйцэтгэдэг нислэгийн үйл ажиллагааны ажилтнуудын хувьд, нисэх онгоц, нислэгийн сургалтын хэрэгсэл дээр гүйцэтгэх ур чадварын сургалт, эсхүл онцгой нөхцөлийн нислэгийн журам болон маневрыг багтаасан нислэгийн симулятор дээр гүйцэтгэх журмын сургалтыг багтаасан үндсэн мэргэшилд нь шаардлагатай бүх хичээл болон үндсэн сэдвийн сургалт;
- (3) нислэгийн симулятор дээр үүрэг гүйцэтгэхээр хязгаарлагдсан багш болон дүгнэгч-нисгэгчийн хувьд, дараах сэдэвт багтсан үндсэн мэргэшилд нь шаардлагатай бүх хичээл болон үндсэн сэдвийн сургалт:
 - (i) сургалтын төхөөрөмжийн үйл ажиллагаатай холбоотой нислэгийн симуляторт хийх ур чадварын сургалт;
 - (ii) хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн дагуу гүйцэтгэх нислэгийн үйл ажиллагаа, журам болон маневр;
- (4) нислэгийн сургалтын хэрэгсэл дээр үүрэг гүйцэтгэхээр хязгаарлагдсан багш болон дүгнэгч-нисгэгчийн хувьд, дараах сэдэвт багтсан үндсэн мэргэшилд нь шаардлагатай бүх хичээл болон үндсэн сэдвийн сургалт:
 - (i) сургалтын төхөөрөмжийн үйл ажиллагаатай холбоотой нислэгийн сургалтын хэрэгсэл дээр хийх ур чадварын сургалт;
 - (ii) хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн дагуу гүйцэтгэх нислэгийн үйл ажиллагаа, журам болон маневр.

Мэргэжлийн ур чадварын дүгнэлтийн хугацаа

(i) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч, дүгнэлтийн хугацаа нь тухайн хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдаж байгаа этгээд амжилттай хамрагдсан байх шаардлагатай сургалтын хичээлийн явцад авдаг мэргэжлийн ур чадварын дүгнэлтийг багтаадаг болохыг бататгана.

(j) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь сургалтын хичээлд дараах шалгалт багтдаг болохыг бататгана:

- (1) хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдаж байгаа этгээдийн хувьд, үндсэн мэргэшилд шаардлагатай бүх тохиолдол болон үндсэн сэдвийн мэргэжлийн ур чадварын дүгнэлт;
- (2) хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдаж байгаа хөлгийн дарга болон нисэх багийн гишүүдээс бусад шаардлагатай гишүүдийн хувьд, шугамын-үйл ажиллагааны нислэгийн цагийн дүгнэлт.

(k) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь мэргэжлийн ур чадварын дүгнэлтийг дараах хэлбэрээр хийдэг болохыг бататгана:

- (1) тухайн хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдаж байгаа хөлгийн дарга, хамтран нисгэгч болон нисэх-инженерийн хувьд, гэрчилгээ эзэмшигчийн сургалтын сэдвийн дагуу нисэх онгоц, нислэгийн симулятор, эсхүл нислэгийн сургалтын хэрэгсэл, эсхүл хослол дээр;
- (2) тухайн хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдаж байгаа бусад этгээдийн хувьд, үйл ажиллагааны хүрээнд тогтоосон тэдний ажил үүргийн гүйцэтгэлийн ур чадварыг дүгнэх хэрэгсэл.

Шугамын-үйл ажиллагааны нислэгийн цагийн дүгнэлтийн хугацаа

(l) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдаж байгаа хөлгийн дарга бүрийг шугамын-үйл ажиллагааны нислэгийн цагийн дүгнэлтийг дараах дүгнэлтийн үе шат бүрд нэг удаа амжилттай хийлгэдэг болохыг бататгана:

- (1) арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцоор эсхүл арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашигладаг нисэх онгоцоор хөөх нислэгт, эсхүл бататгах нислэгт гүйцэтгэдэг;
- (2) сарын дунд цэгийг багтаасан тухайн дүгнэлт хийх хугацааны хуанлийн сард хийлгэдэг;
- (3) шалгалт өгөх хугацаандаа амжилттай хийлгэдэг.

(m) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь, шугамын-үйл ажиллагааны нислэгийн цагийн дүгнэлт хийх үед, тухайн нислэгт хөлгийн дарга, хамтран нисгэгч, эсхүл нисэх-инженерийн үүрэг гүйцэтгэж байгаа этгээдийг дараах шаардлагыг хангасан эсэхийг хүн нэг бүрээр дүгнэлт хийж тогтоодог болохыг бататгана:

- (1) тухайн этгээдийн үүрэг гүйцэтгэдэг тухайн нисэх онгоц, багийн ажил үүрэг болон үйл ажиллагааны төрлийн хувьд, зохих ёсоор сургалтад хамрагдсан ба мэргэшсэн хэвээр байх;
- (2) багийн гишүүнээр үр дүнтэй ажиллах хангалттай мэдлэг болон ур чадвартай байх.

(н) Энэ зүйлийн (л)(3)-ын зорилгоор, шаардсан өдрөөс хойш хуанлийн нэг сарын дотор хийлгэсэн шугамын-үйл ажиллагааны нислэгийн цагийн дүгнэлтийг хугацаанд нь хийлгэсэнд тооцно.

(о) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь хөлгийн дарга, хамтран нисгэгч болон хэрэв гэрчилгээ эзэмшигч сонгосон бол нисэх-инженерийг ИНД-61.37, эсхүл ИНД-63.157-д заасан туршлага хадгалах шаардлагын аль хамааралтайг хангасан болохыг бататгана.

121.917. Багийн нөөцийн удирдлагын шаардлага (CRM)

(а) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь үзэл баримтлал, мэргэшүүлэх болон мэргэшил хадгалах сургалтын сэдэвт дараах сургалт болон үнэлгээ багтсан болохыг бататгана:

- (1) тухайн сургалтад зориулсан ажлын байранд тохирох багийн нөөцийн удирдлагын (CRM) сургалт;
- (2) багийн гишүүний багийн нөөцийн удирдлагын ур чадвараа хэрэгжүүлэх сургалт болон сургалтад оролцсон этгээдийн ур чадвар болон мэргэжлийн ур чадварын дүгнэлт;
- (3) бодит, эсхүл дуураймал шугамын-үйл ажиллагааны нислэгийн цагт нисэх багийн гишүүний нислэгийн, эсхүл бусад техникийн ур чадварын сургалт болон дүгнэлт.

(б) Нисэх багийн гишүүдийн хувьд, энэ сургалт болон дүгнэлтийг нислэгийн сургалтын хэрэгсэл, эсхүл нислэгийн симулятор дээр гүйцэтгэнэ.

121.919. Өгөгдөл цуглуулах шаардлага

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн хөтөлбөрийн ерөнхий зорилгыг хэрэгжүүлэхээр сургалт болон дүгнэлт хийдэг эсэхийг тогтоох боломжийг ИНЕГ-т олгох мэдээллийг түүний нисэх багийн гишүүд, багш болон дүгнэгч-нисгэгчээс цуглуулдаг болохыг бататгана.

121.921. Гэрчилгээжүүлэлт

Хөтөлбөрт хамрагдсан этгээд нь дараах тохиолдолд, тухайн хөтөлбөрийн хүрээнд сургалтад амжилттай хамрагдсан ба дүгнэлт хийлгэснийг үндэслэн коммерийн, эсхүл агаарын тээврийн нисгэгчийн, нисэх-инженерийн, эсхүл зохих зэрэглэлийг эзэмших эрхтэй, хэрэв:

- (1) тухайн хөтөлбөрийн дагуу шаардлагатай мэдлэг, ур чадварын сургалт болон дүгнэлт нь ИНД-61, эсхүл ИНД-63-т тогтоосон минимум гэрчилгээжүүлэлтийн болон зэрэглэлийн шалгуурыг хангасан бол;
- (2) хүсэлт гаргагч нь зохих мэргэшүүлэх сургалтын сэдвээр амжилттай хамрагдсан бол;
- (3) хүсэлт гаргагч нь шаардлагатай техникийн мэдлэг, ур чадвар болон багийн нөөцийн удирдлагын мэдлэг, ур чадвараа хамтад нь хэрэгжүүлэх чадвартай болохоо шалгалтаар харуулсан бол;

- (4) хүсэлт гаргагч нь ИНД-61, эсхүл ИНД-63-ын холбогдох шаардлагын дагуу өөр хэлбэрээр эрх эзэмшдэг бол.

121.923. Гэрээгээр сургалт хийх этгээдэд зөвшөөрөл олгох

(а) ИНД-141-ийн гэрчилгээ нь тухайн эзэмшигчид энэ Бүлгийн шаардлагыг хангасан хөтөлбөрийн дагуу мэргэшил дээшлүүлэх хөтөлбөрийн сургалт зохион байгуулах, мэргэшүүлэх, эсхүл дүгнэлт хийхийг зөвшөөрдөг бол, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигчтэй гэрээ байгуулж болно.

(b) Энэ зүйлийн (а)-ийн дагуу ИНД-141-ээр гэрчилгээжсэн байгууллагатай гэрээ хийхээр сонгосон АТ-ийн гэрчилгээ эзэмшигч дараах шаардлагыг бататгана:

- (1) ИНД-141-ээр гэрчилгээжсэн байгууллагын багш, эсхүл дүгнэгч-нисгэгч нь гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны мэдлэгийг багтаасан сургалтад хамрагдаж байгаа АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийн ажилтнуудад хамаарах мэргэшүүлэх болон мэргэшил хадгалах бүх шаардлагыг хангасан байх;
- (2) ИНД-141-ээр гэрчилгээжсэн гэрээт байгууллага нь энэ Бүлгийн сургалт, мэргэшил болон гэрчилгээжүүлэлтийн шаардлагын дагуу мэргэшил дээшлүүлэх хөтөлбөрийн дагуу мэргэшсэн этгээдийн сургалт, мэргэшил болон гэрчилгээжүүлэлтийн дэлгэрэнгүй мэдээллийн бүртгэлийг хөтөлж, хадгалдаг байх.

N Бүлэг - EDTO нислэгийн эрх болон шаардлага

121.951. Ерөнхий зүйл

(а) Энэ дүрмийн 121.165(d)-д зааснаас бусад тохиолдолд, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараахаас бусад тохиолдолд нисэх онгоцоор EDTO нислэг үйлдэхгүй байх үүрэгтэй:

- (1) гэрчилгээ эзэмшигч нь энэ Бүлгийн дагуу EDTO нислэг үйлдэхээр зөвшөөрөгдсөн байх;
- (2) ИНД-119.15-д шаардсан гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны тодорхойлолт нь:
 - (i) төлөвлөсөн EDTO нислэг үйлдэхийг зөвшөөрдөг байх;
 - (ii) EDTO нислэгт тухайн нисэх онгоцны хүчилсэн бүтэц болон хөдөлгүүрийн хослолыг ашиглахыг зөвшөөрдөг байх;
- (3) ИНД-119.81-д шаардсан гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт энэ Бүлгийн EDTO нислэгийн шаардлага хангасан журмыг дэлгэрэнгүй заасан байх.

(b) Хэрэв үйл ажиллагаа эрхлэгчийн гаргасан, дараах шаардлагыг хамарсан аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний нотлох баримтыг хангалттай гэж үзвэл, АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийн EDTO нислэг үйлдэх бичгээр гаргасан хүсэлтийн дагуу нислэгийн зааварт заасан тухайн нисэх онгоцны хамгийн их цагийн хязгаарлалттай системийн цагийн хязгаарыг давсан арилжааны нислэгийн үйл ажиллагааг Дарга зөвшөөрч болно:

- (1) EDTO нислэг үйлдэх үйл ажиллагаа эрхлэгчийн чадвар;

- (2) EDTO нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх нисэх онгоцны найдвартай байдал;
- (3) EDTO нислэгийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэх нисэх онгоцны цагийн хязгаарлалттай системийн найдвартай байдал;
- (4) EDTO нислэгтэй холбоотой нисэх онгоц үйлдвэрлэгчийн мэдээлэл;
- (5) гэрчилгээ эзэмшигчийн авч хэрэгжүүлэх нөлөөг бууруулах тусгай арга хэмжээ.

121.953. Хоёр-хөдөлгүүртэй нисэх онгоцны 180 минутын даялах максимум хугацаатай EDTO нислэгийн шаардлага

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь хоёр турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоцоор 180 минутын даялах максимум даялах хугацаатай EDTO нислэг үйлдэх EDTO нислэгийн зөвшөөрөл авах хүсэлтийг Даргад бичгээр гаргаж болно.

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу EDTO нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх зөвшөөрөл авахаар хүсэлт гаргаж байгаа АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь төлөвлөсөн EDTO нислэг эхлэхээс 90-ээс доошгүй хоногийн өмнө, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц богино хугацаанд Даргад дараах мэдээллийг хүргүүлэх үүрэгтэй:

- (1) EDTO нислэгийн зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэх нисэх онгоцны хүчилсэн бүтэц болон хөдөлгүүрийн хослолын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (2) тохиромжтой аэродромоос 60 минутаас их нислэгийн цагт EDTO нислэгт ашиглаж байгаа нисэх онгоцны хувьд, энэ хэсгийн (1)-ийн дагуу санал болгосон, хүчилсэн бүтэц болон хөдөлгүүрийн хослолын үйл ажиллагааны хязгаарлалт, маягийн загварын зөвшөөрлийн нотлох баримт болон дэлгэрэнгүй мэдээлэл;
- (3) энэ хэсгийн (1)-ийн дагуу санал болгосон хүчилсэн бүтэц болон хөдөлгүүрийн хослолын SMP-ийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- (4) EDTO нислэгт санал болгосон даялах максимум хугацаа нь 180 минутаас ихгүй байх ёстой;
- (5) даялалтын нислэгийн замыг багтаасан EDTO-оор нисэх нислэгийн замд хамаарах минимум өндрийн түвшин;
- (6) 121.975-ын шаардлагыг хангахад шаардлагатай түлшний бодлогын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (7) 121.407-гийн шаардлагыг хангахад шаардлагатай техник үйлчилгээний хөтөлбөрийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- (8) I Бүлгийн дагуу шаардсан сургалтын хөтөлбөр, энэ хэсгийн (4)-ийн дагуу санал болгосон даялах максимум хугацаа болон EDTO нислэгт хамаарах дэлгэрэнгүй мэдээлэл;
- (9) энэ хэсгийн (4)-ийн дагуу санал болгосон даялах максимум хугацаатай холбоотой MEL-ийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- (10) тухайн нисэх онгоц нь ИНД-26 Хавсралт D, D5(a)(2)-т заасан ачаа, тээшний бүхээгийн гал илрүүлэх, унтраах хязгаарлалт, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц дүйцэх стандартыг хангаж байгааг нотлох баримт;
- (11) тухайн нисэх онгоцны цагийн хязгаарлалттай системийн чадвар дээр нэмж хүлээх нислэг, ойртолт болон буулт үйлдэх зорилгоор олгосон 15 минутын

- зөвшөөрөгдөх хэмжээ нь энэ хэсгийн (4)-ийн дагуу санал болгосон **даялах** максимум хугацаанаас багагүй байгаа болохыг нотлох баримт;
- (12) тухайн нисэх нислэгийн замд шаардлагатай EDTO нислэгийн бэлтгэл аэродром болон энэ хэсгийн (4)-ийн дагуу санал болгосон **даялах** максимум хугацааны дэлгэрэнгүй мэдээлэл;
- (13) дараах дэлгэрэнгүй мэдээлэл:
- (i) энэ хэсгийн (12)-ын дагуу дэлгэрэнгүй мэдээлсэн EDTO нислэгийн бэлтгэл аэродром нь зорчигчид болон багийн гишүүдийн аюулгүй байдлыг бүрэн хангах байгууламжтай болохыг бататгах;
 - (ii) зорчигчид болон багийн гишүүдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор өөр газар тээвэрлэх хүртэл тухайн аэродромд, эсхүл түүний ойролцоох бүсэд байгаа тэдний аюулгүй байдлыг бүрэн хангаж байгааг бататгах, EDTO нислэгийн бэлтгэл аэродром руу даялах нислэгийн үйл ажиллагааг сэргээх төлөвлөгөөний (the recovery plan).
- (14) тухайн нисэх онгоцны хувьд, буцах боломжгүй болох цэгийн дэлгэрэнгүй мэдээлэл (хэрэв мэдэгдэж байгаа бол).

121.955. Хоёр-хөдөлгүүртэй нисэх онгоцны 180 минутын **даялах максимум хугацаатай EDTO нислэгийн зөвшөөрөл**

(a) Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, Дарга 180 минут хүртэл **даялах** максимум хугацаатай EDTO нислэгт хоёр турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоц ашиглан арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхийг АТ-ийн гэрчилгээ эзэмшигчид зөвшөөрөх зорилгоор ИНД-119.15-д шаардсан Үйл ажиллагааны тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулж болно:

- (1) хүчилсэн бүтэц болон хөдөлгүүрийн хослолыг гэрчилгээ эзэмшигчийн хүсэлт гаргасан **даялах** максимум хугацаагаар үйл ажиллагаанд ашиглахыг Зохион бүтээгч Улс зөвшөөрсөн бол;
- (2) энэ Дүрмийн холбогдох шаардлагыг хангасан бол.

(b) Энэ зүйлийн (a)(1)-ийг үл харгалзан, хэрэв тухайн нисэх онгоц нь хоёр турбо-жэт, эсхүл турбо-фэн хөдөлгүүртэй ба тухайн санал болгосон хүчилсэн бүтэц /хөдөлгүүрийн хослолд Зохион бүтээгч Улсаас зохих аэродромоос 60 минутын нислэгийн цагаас (стандарт цаг агаарын нөхцөлд, тогтуун агаарт, нэг хөдөлгүүр ажиллагаагүй үеийн аяллын нислэгийн хурдтай байхаар тооцоолсон) их даялах хугацааны зөвшөөрөл олгоогүй боловч, Дарга төлөвлөсөн EDTO нислэгт тохирно гэж үзсэн бол, тухайн нисэх онгоцыг 75 минутаас ихгүй **даялах** максимум хугацаатай EDTO нислэгт ашиглахыг АТ-ийн гэрчилгээ эзэмшигчид зөвшөөрөх зорилгоор Дарга энэ зүйлийн (a)-ийн дагуу Үйл ажиллагааны тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулж болно.

121.957. Хоёр-хөдөлгүүртэй нисэх онгоцны 240 минутын даялах максимум хугацаатай EDTO нислэгийн шаардлага

(a) ИНД-121.955-ын дагуу хоёр турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоцоор 180 минут хүртэл даялах максимум хугацаатай EDTO нислэг үйлдэхээр зөвшөөрөгдсөн АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь хоёр турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоцоор 240 минутын даялах максимум хугацаатай EDTO нислэг үйлдэх EDTO нислэгийн зөвшөөрөл авах хүсэлтийг Даргад бичгээр гаргаж болно.

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу EDTO нислэгийн зөвшөөрөл авах хүсэлт гаргаж байгаа АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах мэдээллийг Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (1) 240 минутаас ихгүй байх EDTO нислэгт санал болгосон даялах максимум хугацаанд хамааралтай, 121.953(b)-д шаардсан мэдээлэл;
- (2) тухайн нисэх онгоцыг дараах холбооны системээр тоногдсон болохыг нотлох баримт:
 - (i) ИНД-91.519 болон 121.353-т шаардсанаас гадна, нэмэлт холбооны төхөөрөмж;
 - (ii) нисэх багийн гишүүн ба холбогдох НХҮ-ний нэгж, болон нисэх багийн гишүүн ба агаарын тээвэрлэгчийн хооронд газрын утсан холбоотой дүйцэх дууны чанартай шууд холбоогоор хангах чадвартай.

121.959. Хоёр-хөдөлгүүртэй нисэх онгоцны 240 минутын даялах максимум хугацаатай EDTO нислэгийн зөвшөөрөл

Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, Дарга 240 минут хүртэл даялах максимум хугацаатай EDTO нислэгт хоёр турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоц ашиглан арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхийг АТ-ийн гэрчилгээ эзэмшигчид зөвшөөрөх зорилгоор ИНД-119.15-д шаардсан Үйл ажиллагааны тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулж болно:

- (1) гэрчилгээ эзэмшигч нь ИНД-121.955-ын дагуу олгосон 180 минутын EDTO нислэгийн зөвшөөрлийн хүрээнд EDTO нислэг гүйцэтгэх ур чадвараа харуулсан бол;
- (2) EDTO нислэгт ашиглах нисэх онгоцны хүчилсэн бүтэц болон хөдөлгүүрийн хослолд гэрчилгээ эзэмшигчийн хүсэлт гаргасан даялах максимум хугацаагаар үйл ажиллагаанд ашиглахыг Зохион бүтээгч Улс зөвшөөрсөн бол;
- (3) 121.957(b)-гийн шаардлагыг хангасан бол.

121.961. Хоёр-хөдөлгүүртэй нисэх онгоцны 240 минутын даялах максимум хугацаатай EDTO нислэгийн шаардлага

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь EDTO 240 минутаас их даялах максимум хугацаатай нислэгт хоёр турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоцоор, EDTO нислэгийн зөвшөөрөл авах хүсэлтийг Даргад бичгээр гаргаж болно, хэрэв хүсэлт гаргахын өмнө, гэрчилгээ эзэмшигч нь:

- (1) дараалсан 24 сарын хугацаанд, 121.955, эсхүл ИНД-121.959-ийн дагуу Даргын олгосон EDTO нислэгийн зөвшөөрлийн хүрээнд EDTO нислэг үйлдсэн бол;

(2) дараалсан 12 сарын хугацаанд, 121.959-ийн дагуу Даргын олгосон EDTO нислэгийн зөвшөөрлийн хүрээнд тухайн нисэх онгоцны хүчилсэн бүтэц/хөдөлгүүрийн хослолыг ашиглан 180 минутаас их EDTO нислэг үйлдсэн бол.

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу EDTO нислэгийн зөвшөөрөл авах хүсэлт гаргаж байгаа АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах мэдээллийг Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (1) санал болгосон EDTO нислэгийн **даялах** максимум хугацаанд тохирох, 121.953(b)-д шаардсан мэдээлэл;
- (2) тухайн нисэх онгоцыг 121.957(b)(2)-т шаардсан холбооны системээр тоноглосон болохыг нотлох баримт.

121.963. Хоёр-хөдөлгүүртэй нисэх онгоцны 240 минутын **даялах максимум хугацаатай EDTO нислэгийн зөвшөөрөл**

Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, Дарга 240 минутаас их **даялах** максимум хугацаатай EDTO нислэгт хоёр турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоц ашиглан арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхийг АТ-ийн гэрчилгээ эзэмшигчид зөвшөөрөх зорилгоор ИНД-119.15-д шаардсан Үйл ажиллагааны тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулж болно:

- (1) гэрчилгээ эзэмшигч нь 121.961(a)-д шаардсан EDTO нислэг гүйцэтгэх ур чадвараа харуулсан байх;
- (2) EDTO нислэгт ашиглах нисэх онгоцны хүчилсэн бүтэц болон хөдөлгүүрийн хослолд гэрчилгээ эзэмшигчийн хүсэлт гаргасан **даялах** максимум хугацаагаар үйл ажиллагаанд ашиглахыг Зохион бүтээгч Улс зөвшөөрсөн байх;
- (3) 121.961(b)-гийн шаардлагыг хангасан байх.

121.965. 2-оос олон хөдөлгүүртэй нисэх онгоцны EDTO нислэгийн шаардлага

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тохиромжтой аэродромоос 180 минутаас их хугацаагаар холдохыг шаарддаг нислэгийн замд (стандарт цаг агаарын нөхцөлд, тогтуун агаарт, нэг хөдөлгүүр ажиллагаагүй үеийн аяллын нислэгийн хурдтай байхаар тооцоолсон) хоёроос олон турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоцоор үйл ажиллагаа гүйцэтгэх EDTO нислэгийн зөвшөөрөл авах хүсэлтийг Даргад бичгээр гаргаж болно.

(b) 121.961(b)-г харгалзан, энэ зүйлийн (a)-ийн дагуу EDTO нислэгийн зөвшөөрөл авах хүсэлт гаргаж байгаа АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах мэдээллийг Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (1) EDTO нислэгт ашиглах нисэх онгоцны хүчилсэн бүтэц болон хөдөлгүүрийн хослол, санал болгосон **даялах** максимум хугацаанд тохирох, 121.953(b)-д шаардсан мэдээлэл;
- (2) тухайн нисэх онгоцыг 121.957(b)(2)-т шаардсан холбооны системээр тоноглосон болохыг нотлох баримт.

121.967. 2-оос олон хөдөлгүүртэй нисэх онгоцны EDTO нислэгийн зөвшөөрөл

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, Дарга 180 минутаас их **даялах** максимум хугацаатай EDTO нислэгт хоёроос олон турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоц ашиглан арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхийг АТ-ийн гэрчилгээ эзэмшигчид зөвшөөрөх зорилгоор ИНД-119.15-д шаардсан Үйл ажиллагааны тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулж болно:

- (1) 121.965(b)-гийн шаардлагыг хангасан;
- (2) EDTO нислэгт ашиглах нисэх онгоцны хүчилсэн бүтэц болон хөдөлгүүрийн хослолд гэрчилгээ эзэмшигчийн хүсэлт гаргасан **даялах** максимум хугацаагаар үйл ажиллагаанд ашиглахыг Зохион бүтээгч Улс зөвшөөрсөн.

(b) Хэрэв АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ эзэмшигчийн хүссэн **даялах** максимум хугацаатай EDTO нислэгийн үйл ажиллагаанд тухайн нисэх онгоцны хүчилсэн бүтэц болон хөдөлгүүрийн хослол, тохиромжтой болохыг нотлох баримтыг Даргад гаргаж өгсөн бол, энэ дүрмийн 121.953(b)(3)-ын хүчилсэн бүтэц болон хөдөлгүүрийн хослолын СМР дэлгэрэнгүй мэдээллийн болон энэ зүйлийн (a)(2)-ын хүчилсэн бүтэц болон хөдөлгүүрийн хослолд Зохион бүтээгч Улсаас зөвшөөрсөн EDTO нислэгийн шаардлага нь 2018 оны 11 сарын 01-нээс өмнө үйлдвэрлэсэн, 180 минутаас их **даялах** максимум хугацаатай EDTO нислэгт ашигладаг хоёроос олон турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоцонд хамаарахгүй.

121.969. EDTO нислэгт гаргах шаардлага - ерөнхий зүйл

(a) Энэ Бүлгийн дагуу EDTO нислэг гүйцэтгэх эрхтэй АТ-ийн гэрчилгээ эзэмшигч дараахаас бусад тохиолдолд, нисэх онгоцыг EDTO нислэгт гаргахыг зөвшөөрөхгүй байх үүрэгтэй:

- (1) ИНД-91.519 болон ИНД-121.353-т шаардсан холбооны систем нь ажиллагаатай байх;
- (2) энэ зүйлийн (b)-г харгалзан, хөөрөлт болон хөөрөлтийн бэлтгэл аэродром, нисэн очих болон нисэн очих бэлтгэл аэродром болон нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродромыг багтаасан үйл ажиллагаанд шаардлагатай аэродромыг хөлгийн даргад хүргүүлсэн нислэгт гаргах жагсаалтад заасан байх;
- (3) 180 минут болон түүнээс дээш EDTO нислэгийн **даялах** максимум хугацааны хувьд, нислэгт гаргах жагсаалтад заасан хамгийн ойрын нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродром хүртэлх (стандарт цаг агаарын нөхцөлд, тогтуун агаарт, нэг хөдөлгүүр ажиллагаагүй үеийн аяллын нислэгийн хурдтай байхад) нислэгийн цаг нь тухайн нисэх онгоцны нислэгийн зааварт заасан хамгийн эрсдэлтэй цагийн хязгаарлалттай системийн цагаас (ачаа, тээшний бүхээгийн хамгийн их хязгаарлах галтай тэмцэх хугацааг багтаасан) 15 минутыг хассанаас хэтрэхгүй байх.

(b) Энэ зүйлийн (c)-д зааснаас бусад тохиолдолд, аэродромыг нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродромоор энэ зүйлийн (a)(2)-т заасан нислэгт гаргах жагсаалтад дараахаас бусад тохиолдолд оруулахгүй байж болно, хэрэв:

- (1) тухайн аэродром нь EDTO нислэгийн бэлтгэл аэродром бөгөөд 119.15(d)(3)-т шаардсан гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны тодорхойлолтод заагдсан бол;
- (2) тухайн улсын AIP-д хэвлэн нийтэлсэн 1-ээс доошгүй тохирох хэрэглэлийн ойртолтын журам нь буулт үйлдэж болох эхний боломжит цагаас буулт үйлдэж болох сүүлчийн боломжит цагийн хугацаанд тухайн аэродромд ашиглах боломжтой бол;
- (3) тухайн аэродромын сүүлчийн боломжит цаг уурын урьдчилсан мэдээ нь буулт үйлдэж болох эхний боломжит цагаас буулт үйлдэж болох сүүлчийн боломжит цагийн хугацаанд дараах нөхцөлийг харуулж байгаа бол:
 - (i) тухайн аэродромын цаг уурын нөхцөл нь ИНД-121.977-д заасан нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродромын хувьд, холбогдох аэродромын төлөвлөлтийн минима-тай тэнцүү, эсхүл түүнээс дээш байх;
 - (ii) ашиглахаар төлөвлөсөн ХБЗ-ны тогтворгүй салхийг багтаасан хөндлөнгийн салхины бүрдэл хэсэг нь тухайн нисэх онгоцны нислэгийн зааварт заасан максимум зөвшөөрөгдсөн **хажуугийн хөндлөнгийн** салхинаас ихгүй байх.

(c) Хэрэв энэ зүйлийн (b)(3)-т шаардсан цаг уурын урьдчилсан мэдээг нислэгт гаргах цаг хугацаанд авах боломжгүй бол тухайн аэродромыг, нислэгт гаргах жагсаалтад нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродромоор зааж болох ба нисэх онгоцыг EDTO нислэгт гаргаж болно, гэхдээ хөлгийн дарга нь буцаж болох сүүлчийн цэгт хүрэхээс өмнө тухайн аэродромын хүчинтэй цаг уурын мэдээ авсан ба энэ зүйлийн (b)(3)-ын шаардлага хангасан байхаас бусад тохиолдолд, хөлгийн даргад тухайн аэродромын буцаж болох сүүлчийн цэгийг давахыг зөвшөөрөхгүй.

(d) Энэ зүйлийн (b)(3)-ын зорилгоор, 40%-иас бага байгаа цаг уурын урьдчилсан мэдээний магадлалыг тооцохгүй байж болох боловч TEMPO нөхцөл урьдчилан мэдээлсэн бол түлшний шаардлагыг тооцохдоо тооцоонд авч үзэх ёстой.

121.971. EDTO нислэгт гаргах - 180 минутын **даялах максимум хугацаатай EDTO нислэгийн нэмэлт шаардлага**

Энэ Бүлгийн дагуу EDTO нислэг үйлдэхээр зөвшөөрөгдсөн АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлага хангаагүй тохиолдолд, нисэх онгоцыг нислэгт гаргах жагсаалтад заасан нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродромоос 180 минутын нислэгийн цагаас их хугацаа шаарддаг EDTO нислэгт тухайн нисэх онгоцыг гаргахыг зөвшөөрөхгүй байх үүрэгтэй:

- (1) 121.969-ийн шаардлага;
- (2) тухайн нисэх онгоцны дараах систем ажиллагаатай байх:
 - (i) түлшний хэмжээ заах систем;
 - (ii) хэрэв тухайн нисэх онгоцны EDTO нислэгийн зөвшөөрөлд ажиллагаатай APU шаардлагатай бол, тухайн APU зохион бүтээгдсэн хүчин чадлаар цахилгаан болон пневматик хангамжийг гаргах чадвартай APU;
 - (iii) хөдөлгүүрийн хүчний автомат бариул (auto throttle) / автомат татах хүчний (auto thrust) систем;
 - (iv) 121.957(b)(2)-т шаардсан холбооны систем;

- (3) нисэх онгоц нь нэг хөдөлгүүр ажиллагаагүй үед автомат-буулт үйлдэх (auto-land) чадвартай байх, хэрэв нислэгийн төлөвлөгөө нь тухайн чадвар дээр суурилсан бол;
- (4) нислэгт гаргах жагсаалтад заасан хамгийн ойрын нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродром хүртэлх нислэгийн цаг нь (салхи болон агаарын хэмийн засвартай бүх хөдөлгүүр ажиллагаатай үеийн аяллын нислэгийн хурдтай) нислэгийн аль ч үе шатанд 15 минутыг хасаж тооцсон, тухайн нисэх онгоцны нислэгийн зааварт заасан хамгийн их хязгаарлах чадвартай ачаа, тээшний бүхээгийн галтай тэмцэх системийн хугацаанаас хэтрэхгүй байх;
- (5) нислэгт гаргах жагсаалтад заасан хамгийн ойрын нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродром хүртэлх нислэгийн цаг нь (салхи болон агаарын хэмийн засвартай нэг хөдөлгүүр ажиллагаагүй үеийн аяллын нислэгийн хурдтай) 15 минутыг хасаж тооцсон, тухайн нисэх онгоцны нислэгийн зааварт заасан хамгийн их эрсдэлтэй цагийн хязгаарлалттай системийн (ачаа, тээшний бүхээгийн галтай тэмцэх системийг багтаагаагүй) чадвараас хэтрэхгүй байх.

121.973. Нислэгийн замын дагуух EDTO нислэг

(a) Энэ Бүлгийн дагуу EDTO нислэг үйлдэхээр зөвшөөрөгдсөн АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь нислэгт гаргах жагсаалтад заасан нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродромын нөхцөлд орсон томоохон өөрчлөлтийг тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд EDTO нислэг үйлдэж байгаа нисэх онгоцны даргад дараах тохиолдолд мэдэгддэг болохыг бататгах үүрэгтэй:

- (1) тухайн нисэх онгоц EDTO нислэг эхлэх цэгийг давахаас өмнө;
- (2) тухайн нисэх онгоц EDTO нислэг эхлэх цэгийг давсны дараа.

(b) Хэрэв нислэгт гаргах жагсаалтад заасан нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродромын нөхцөлд орсон томоохон өөрчлөлтийг, тухайн нисэх онгоц EDTO нислэг эхлэх цэгийг давахаас өмнө EDTO нислэгт ашиглаж байгаа нисэх онгоцны даргад мэдэгдсэн бол, хөлгийн дарга дараах шаардлагыг бататгах үүрэгтэй:

- (1) аэродромын тухайн нөхцөлийн өөрчлөлтөд дүгнэлт хийдэг байх;
- (2) хэрэв аэродромын тухайн нөхцөлийн өөрчлөлт нь энэ зүйлийн (c)(1)-д заасан ашиглах боломжит хугацааны туршид тухайн аэродромд аюулгүй ойртолт болон буулт үйлдэх боломжгүй болгох бол, аюулгүй ойртолт болон буулт үйлдэх боломжтой нөөц, тохиромжтой нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродром сонгодог байх.

(c) EDTO нислэгт ашиглаж байгаа нисэх онгоцны дарга тухайн нислэгийн хувьд, нислэгт гаргах жагсаалтад заасан, эсхүл энэ зүйлийн (b)(2)-ын дагуу сонгосон нислэгийн замын дагуух EDTO нислэгийн дараах бэлтгэл аэродром байхаас бусад тохиолдолд, EDTO нислэг эхлэх цэгийг давахгүй байх үүрэгтэй:

- (1) тухайн аэродромын цаг уурын урьдчилсан мэдээ нь тухайн төлөвлөсөн ойртолт үйлдэхэд ашиглах боломжит хугацааны туршид тухайн цаг уурын нөхцөл хэвлэн нийтлэгдсэн аэродромын буултын минимал-д, эсхүл түүнээс дээш байхыг харуулж байгаа;
- (2) тухайн аэродром нь нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродромоор сонгоход тохиромжтой.

(d) EDTO нислэгт ашиглаж байгаа нисэх онгоцны дарга нь тухайн нисэх онгоц EDTO нислэгийн SMP стандартын нислэгийн үеийн үйл ажиллагааны шаардлагыг хангаж байгааг бататгах үүрэгтэй.

(e) Хэрэв EDTO нислэгт ашиглаж байгаа нисэх онгоцны даргад тухайн нисэх онгоц EDTO нислэг эхлэх цэгийг давсны дараа, тухайн нислэгт гаргах жагсаалтад заасан нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродромын нөхцөлтэй холбоотой томоохон өөрчлөлтийн талаар мэдэгдсэн ба тухайн өөрчлөлт нь аэродромыг нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродромоор цаашид ашиглах боломжгүй болгож байгаа бол, хөлгийн дарга хэрэв нислэгийг үргэлжлүүлэх нь өөр бусад нөөц үйлдэл хийхээс илүү аюул багатай гэж үзвэл, тухайн нислэгийг үргэлжлүүлж болно.

(f) Энэ зүйлийн (a), (b) болон (e)-гийн зорилгоор, нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродромын нөхцөлийн томоохон өөрчлөлтөд дараах өөрчлөлт багтана:

- (i) цаг агаарын нөхцөл нь ашиглахаар төлөвлөсөн цагт аэродромын буултын минимал-д, эсхүл түүнээс доогуур байхыг харуулж байгаа аэродромын цаг уурын урьдчилсан мэдээний өөрчлөлт;
- (ii) тухайн аэродромыг EDTO нислэгийн бэлтгэл аэродромоор ашиглахад тохиромжгүй болгох тухайн аэродромын нөхцөл, эсхүл үйлчилгээний өөрчлөлт.

121.975. EDTO нислэгийн түлшний шаардлага

(a) Энэ Бүлгийн дагуу EDTO нислэг үйлдэх зөвшөөрөлтэй АТ-ийн гэрчилгээ эзэмшигч 121.75-д шаардсан гэрчилгээ эзэмшигчийн түлшний бодлогын шаардлага дээр нэмж, дараах шаардлагыг хангасан байхаас бусад тохиолдолд, нисэх онгоцыг EDTO нислэгт гаргахыг зөвшөөрөхгүй байх үүрэгтэй:

- (1) тухайн нисэх онгоц нь дараах түлшний аль ихийг тээвэрлэх ёстой:
 - (i) нислэгийн хамгийн эрсдэлтэй цэгт битүүмжлэл хурдан алдагдана гэж үзэн, ИНД-91.423-т нийцүүлэн аюулгүй **өндрийн**-түвшин хүртэл өндөр алдаж, ИНД-91.209-д заасан хүчилтөрөгчийн төхөөрөмжийг хэрэглэн, нислэгт гаргах жагсаалтад заасан нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродром руу нисэх хангалттай түлш; эсхүл
 - (ii) нислэгийн хамгийн эрсдэлтэй цэгт нэгэн зэрэг битүүмжлэл хурдан алдагдаж, нэг хөдөлгүүр татгалзана гэж үзэн, ИНД-91.209-ийн хүчилтөрөгчийн төхөөрөмжийн шаардлага болон ИНД-91.423-т нийцүүлэн аюулгүй **өндрийн**-түвшин хүртэл өндөр алдаж, нэг хөдөлгүүр ажиллагаагүй үеийн аяллын нислэгийн зөвшөөрөгдсөн хурдтайгаар, нислэгт гаргах

- жагсаалтад заасан нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродром руу үргэлжлүүлэн нисэхэд хангалттай түлш; эсхүл
- (iii) нислэгийн хамгийн эрсдэлтэй цэгт нэг хөдөлгүүр татгалзана гэж үзэн, нэг хөдөлгүүр ажиллагаагүй үеийн аяллын **өндрийн**-түвшин хүртэл өндөр алдаж, нэг хөдөлгүүр ажиллагаагүй үеийн аяллын нислэгийн зөвшөөрөгдсөн хурдтайгаар, нислэгт гаргах жагсаалтад заасан нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродром руу үргэлжлүүлэн нисэхэд хангалттай түлш; эсхүл
- (iv) тухайн нисэх онгоцны EDTO нислэгийн эрсдэлтэй түлш;
- (2) нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродромд хүрэхэд нисэх онгоц нь тухайн аэродромын өндөрлөгөөс дээш 450 м-ийн (1500 ft) өндөрт 15 минут хүлээх нислэг үйлдээд, хэрэглэлийн ойртолтын журмыг ашиглан буулт үйлдэх хангалттай түлштэй байх ёстой.
- (b) Энэ зүйлийн (a)-д шаардсан түлшийг тооцоолох зорилгоор, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг тооцож үзэх үүрэгтэй:
- (1) хэрэв гэрчилгээ эзэмшигч нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц салхины урьдчилсан мэдээний загварыг ашиглаж байгаа бол салхины урьдчилсан мэдээний алдааг тооцож үзэхдээ, 5%-ийн салхины хурдны хүчин зүйлийг (ж нь: **урдаас-чиглэсэн** **угтах** салхины нэмэгдэл, эсхүл **арын** **аас-чиглэсэн** салхины хорогдол) энэ зүйлийн (a)(1)-д шаардсан түлшийг тооцоолоход ашигласан салхины бодит, эсхүл урьдчилсан мэдээнд нэмж тооцох ёстой;
- (2) хэрэв гэрчилгээ эзэмшигч нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц салхины урьдчилсан мэдээний загварыг ашигладаггүй бол, салхины урьдчилсан мэдээний алдааг залруулахын тулд тухайн нисэх онгоц нь энэ зүйлийн (a)(1)-д шаардсанаас 5%-иар илүү нэмэлт түлштэй байх ёстой;
- (3) хэрэв төлөвлөсөн EDTO нислэгт мөстөлттэй нөхцөлийн урьдчилсан мэдээ байгаа бол энэ зүйлийн (a)(1)-д шаардсан түлш нь дараах нөхцөлд зарцуулах түлшнээс их байх ёстой:
- (i) мөстөлттэй байх урьдчилсан мэдээний 10%-ийн хугацаанд хүчилсэн бүтцийн мөстөлтийн үзүүлэх нөлөөг тооцож үзээд, ижил хугацаанд хөдөлгүүр болон далавчны мөстөлт эсэргүүцэхэд хэрэглэх түлш; эсхүл
- (ii) мөстөлттэй байх урьдчилсан мэдээнд тооцсон бүх хугацааны турш хөдөлгүүрийн мөстөлт эсэргүүцэх системийг ашиглах, хэрэв шаардлагатай бол, далавчны мөстөлт эсэргүүцэх системийг ашиглахад зарцуулах түлш:
- (4) энэ зүйлийн (a)(1)-д шаардсан түлшинд дараах түлш багтсан байх ёстой:
- (i) гэрчилгээ эзэмшигчийн **техникийн** үзүүлэлт **муудах** **ийн-элэгдлийн** (performance deterioration) зөвшөөрөгдөх хэмжээг хянах хөтөлбөрийн дагуу тооцоолсон тухайн нисэх онгоцны түлшний зарцуулалтын өсөлтийг нөхөх нэмэлт түлш; эсхүл
- (ii) хэрэв тухайн нисэх онгоцны түлш зарцуулалтад **техникийн** үзүүлэлт **муудах** **ийн-элэгдлийн** (performance deterioration) зөвшөөрөгдөх хэмжээг хянах хөтөлбөрийг ашигладаггүй бол аяллын нислэгийн түлшний зарцуулалтын элэгдлийг тооцохын тулд энэ зүйлийн (a)(1)-д шаардсанаас 5 %-иар илүү нэмэлт түлш.

- (5) хэрэв APU нь тухайн нисэх онгоцыг EDTO нислэгт ашиглахад шаардлагатай цахилгааны эх үүсвэр болдог бол, энэ зүйлийн (а)(1)-д шаардсан түлшинд APU-г ашиглаж болох нислэгийн бүх шатанд хэрэглэх түлшний зарцуулалт багтсан байх ёстой;
- (6) энэ зүйлийн (а)(1)-д шаардсан түлшинд нислэгийн аливаа холбогдох үе шатанд MEL, эсхүл конфигурацийн өөрчлөлтийн жагсаалт (CDL) ашиглахаас шалтгаалах нэмэлт түлш багтсан байх ёстой.

121.977. Нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродромын төлөвлөлтийн минима

ИНД-121.979-д зааснаас бусад тохиолдолд, 121.969-ийн дагуу нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродромоор зааж болох аэродромын холбогдох минима-г дараах Хүснэгтэд заасан байна:

Нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродромд байх байгууламж	Үүлний суурийн өндөр	Хараа
2, эсхүл түүнээс дээш тусдаа нарийвчлалтай ойртолтын журамтай ХБЗ (Жич: 2 талын нарийвчлалтай ойртолтын төй журамтай ганц ХБЗ нь энэ шаардлагыг хангахгүй)	Үүлний суурь нь 120 м (400 ft), эсхүл аэродромын хамгийн бага буултын минимумаас дээш 60 м-ийн (200 ft) аль өндрийг	Хараа 1500 м, эсхүл хамгийн бага буултын харааны минимумаас дээш 800 м-ийн аль ихийг
Ганц нарийвчлалтай ойртолтын журамтай	Үүлний суурь нь 180 м (600 ft), эсхүл аэродромын хамгийн бага буултын минимумаас дээш 120 м-ийн (400 ft) аль өндрийг	Хараа 3000 м, эсхүл хамгийн бага буултын харааны минимумаас дээш 1500 м-ийн аль ихийг
Нарийвчлалтай бус ойртолтын журамтай	Үүлний суурь нь 240 м (800 ft), эсхүл аэродромын хамгийн бага буултын минимумаас дээш 120 м-ийн (400 ft) аль өндрийг	Хараа 4000 м, эсхүл хамгийн бага буултын харааны минимумаас дээш 1500 м-ийн аль ихийг

121.979. Нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродромын төлөвлөлтийн бага минима

ИНД-121.977-г үл харгалзан, CAT II болон CAT III нарийвчлалтай ойртолтын журам зөвшөөрөгдсөн аэродромд хэрэв тухайн нарийвчлалтай ойртолтыг ИНД-91.417-д шаардсан батлагдсан нарийвчлалтай ойртолтын журмын заавраар гүйцэтгэсэн бол 121.977-д заасан нислэгийн замын дагуух EDTO нислэгийн бэлтгэл аэродромын төлөвлөлтийн минима-гаас бага минима-г ашиглаж болно.

121.981. Мөрдөж байгаа ETOPS нислэгийн шилжилт

Энэ Дүрмийн зорилгоор, гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны тодорхойлолтод хоёр турбинт-хөдөлгүүртэй нисэх онгоц ашиглан ETOPS нислэг үйлдэхээр зөвшөөрөгдсөн АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийг, түүний үйл ажиллагааны тодорхойлолтод ETOPS нислэгийг зөвшөөрсөнтэй ижил нисэх онгоцны хүчилсэн бүтэц/хөдөлгүүрийн хослолтой, ижил нислэгийн замд болон ижил **даялах** максимум хугацаатайгаар N Бүлгийн дагуу EDTO нислэг үйлдэхийг зөвшөөрсөнд тооцно.

Хавсралт А - Нөөц

Хавсралт В - Хэрэглэл болон төхөөрөмжийн НТЧ-ын загварын стандарт

F Бүлэгт шаардсан хэрэглэл, төхөөрөмж нь дараах тодорхойлолт болон шаардлагад нийцсэн байна:

В.1. Амьсгал хамгаалах төхөөрөмж (PBE)

(a) Амьсгал хамгаалах төхөөрөмж нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- (1) TSO C99 серийн, эсхүл TSO C116 серийн;
- (2) дараах нөхцөлд аюулгүй амьсгалах хийн системээр хангах:
 - (i) өөрөө;
 - (ii) түүнийг ажиллуулах аргаар;
 - (iii) бусад бүрдэл хэсэгт нөлөөлснөөр;
- (3) харааг хэт хязгаарлахааргүйгээр нүд хамгаалах;
- (4) багийн гишүүд дараах үйл ажиллагаа гүйцэтгэх боломжтой байх:
 - (i) хийн систем нь химийн хүчилтөрөгчийн генератор ашигладаг байхаас бусад тохиолдолд, нислэгийн үед амьсгалах хийн боломжит хэмжээг тодорхойлох;
 - (ii) харааны шилийг хараанд сөргөөр нөлөөлөхгүй, эсхүл амьсгалын хамгаалалтаа алдахгүй байхаар ашиглах;
 - (iii) багийн гишүүд дотоод холбоо ашиглах;
- (5) багийн гишүүд нисэх онгоцны радио холбоо ашиглах боломжтой байх;
- (6) 2400 м-ийн (8000 ft) даралтын **эндрийн** түвшинд 15 минутын турш амьсгалах хийгээр хангах.

(b) Хүчилтөрөгчийн төхөөрөмжийн стандартыг хангасан амьсгал хамгаалах төхөөрөмжийг ИНД-91-ийн нэмэлт хүчилтөрөгчийн шаардлагыг хангах зорилгоор ашиглаж болно.

В.2. Эмнэлгийн түргэн тусламжийн иж бүрдэл (Emergency medical kit)

Эмнэлгийн түргэн тусламжийн иж бүрдэл нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) дараах шаардлагын дагуу байрласан бөгөөд бэхлэгдсэн байх:
 - (i) ослын улмаас гэмтэх, эсхүл гээгдэх боломжийг багасгасан байх;
 - (ii) нисэх онгоцонд байгаа хүмүүст аюул учруулахааргүй байх;
- (2) тухайн иж бүрдлийг агуулсан савны гадна талд түүний байрлалыг зааж тэмдэглэсэн байх;
- (3) зөвхөн мэргэшсэн эмнэлгийн ажилтан ашиглахаар тэмдэглэсэн байх;
- (4) мансууруулах бодис агуулж байгаа бол, нисэх онгоцонд дараах шаардлагыг ханган байрлуулсан байх:
 - (i) Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай Хуулийн (2010) шаардлагыг хангасан байх;
 - (ii) хэрэглээгүй үед түгждэг, эсхүл түгжээтэй саванд хадгалдаг, эсхүл мансууруулах бодис агуулсан анхны тусламжийн иж бүрдлийг аюулгүй хамгаалагдсан байрлал руу зөөж хадгалдаг байх.

В.3. Зарлан мэдээлэх систем

(a) Зарлан мэдээлэх систем нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) 121.369(2)-т шаардсан багийн гишүүдийн дотоод холбооны системийн гар микрофон, чихэвч, микрофон, сонгох товчлууур болон дохионы хэрэгслээс тусдаа, бие даан ажиллах чадвартай байх;
- (2) нисэх багийн бүхээгт байгаа нисэх багийн хоёр гишүүний байрлалаас нэн даруй ашиглах боломжтой байх;
- (3) шалны түвшинд байрласан ослын гарцын ойролцоох бүхээгийн ажилтны суудал нь суудлаасаа ашиглах боломжтой микрофонтой байх;
- (4) зорчигчийн бүхээгт байгаа бүхээгийн ажилтны авч ашиглах боломжтой ажлын байрнаас 10 секундийн дотор ажиллах чадвартай байх;
- (5) бүх цаг хугацаанд, бүх зорчигчийн суудал, ариун цэврийн өрөө, бүхээгийн ажилтны суудал болон ажлын байранд ойлгомжтой сайн сонсогддог байх.

(b) Энэ зүйлийн (a)(3)-ыг үл харгалзан, бүхээгийн ажилтнууд суудлаасаа хоорондоо туслах хэрэгсэлгүйгээр яриагаар харилцах боломжтой байхаар тухайн гарцууд хоорондоо ойрхон байх тохиолдолд нэгээс олон гарцыг нэг микрофоноор удирдаж болно.

В.4. Багийн гишүүдийн дотоод холбооны систем

Багийн гишүүдийн дотоод холбооны систем нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) 121.369(1)-д шаардсан, зарлан мэдээлэх системийн гар микрофон, чихэвч, микрофон, сонгох товчлууур болон дохионы хэрэгслээс тусдаа, бие даан ажиллах чадвартай байх;
- (2) нисэх багийн бүх гишүүдийн хооронд хоёр талын холбооны хэрэгслээр хангах;
- (3) нисэх багийн бүхээг болон зорчигчдын бүхээг бүрийн хооронд хоёр талын холбооны хэрэгслээр хангах;
- (4) нисэх багийн бүхээгт байгаа нисэх багийн хоёр гишүүний байрлалаас нэн даруй ашиглах боломжтой байх;
- (5) зорчигчдын бүхээг бүрд байгаа нэгээс доошгүй бүхээгийн ажилтны хэвийн ажлын байрнаас ашиглах боломжтой байх;
- (6) зорчигчийн бүхээгт байгаа бүхээгийн ажилтны авч ашиглах боломжтой ажлын байрнаас 10 секундийн дотор ажиллах чадвартай байх;
- (7) зорчигчийн бүхээгийн шалны түвшинд байрласан ослын гарцыг тоногдсон суудлаас хянах боломжтой байхаар хангалттай тооны бүхээгийн ажилтны суудлыг ашиглаж болохоор суурилуулсан байх;
- (8) дараах анхааруулах системтэй байх:
 - (i) багийн гишүүн ашиглаж байхад өгөх дуут, эсхүл гэрлэн дохио;
 - (ii) дуудлага хүлээн авагч нь тухайн дуудлага хэвийн, эсхүл онцгой нөхцөлийн аль нь болохыг тогтоох хэрэгсэл;

- (9) дараах нөхцөлд нисэх багийн бүхээгт байгаа нисэх багийн хоёр гишүүн болон газрын ажилтны хооронд хоёр талын холбоо барих хэрэгслээр хангах:
- (i) тухайн нисэх онгоц газарт байх үед;
 - (ii) газрын ажилтан нисэх онгоцноос харж тодорхойлох боломжгүй байрлалаас дотоод холбооны системийг ашиглах үед.

В.5. Бүхээгийн дуу чимээ бичигч (CVR)

CVR нь дараах шаардлагыг хангасан байх ёстой нэ:

- (1) TSO C84 серийн, эсхүл TSO C123 серийн;
- (2) TSO C121 серийн шаардлага хангасан, усан дор байрлал тогтоох хэрэгслээр тоногдсон байх;
- (3) ~~Бичлэгийг арилгаж эхлэхийн өмнө, 30 минутын хугацаанд тасралтгүй бичлэг хийх минимум багтаамжтай байх~~ сүүлийн 2-оос доошгүй цагийн үйл ажиллагааны бичлэг хийдэг ба хадгалдаг байх;
- (4) ICAO Annex 6 6.3.2.4.1-ийн шаардлага хангасан ба тухайн CVR-ийг тэжээдэг цахилгааны эх үүсвэрээс тусдаа нөөц цахилгааны эх үүсвэртэй байх.

В.6. Нислэгийн өгөгдөл бичигч (FDR)

FDR нь дараах шаардлагыг хангасан байх ёстой нэ:

- (1) TSO C124 серийн;
- (2) TSO C121 серийн шаардлага хангасан, усан дор байрлал тогтоох хэрэгслээр тоногдсон байх;
- (3) 25-аас доошгүй цагийн өгөгдлийг үйл ажиллагааг тоон өгөгдөл хэлбэрээр бичих, ба хадгалах чадвартай байх бөгөөд салгаж болдоггүй төрөлийн (non-ejectable type) санах ойтой байх;
- (4) дараах шаардлагын дагуу үзүүлэлтийг бичдэг байх:
 - (i) Хавсралт В-гийн Зураг 1-д заасан FDR-ийн шийдвэр гаргах бүдүүвч;
 - (ii) Зөвлөмжийн цуврал AC121-0-ийн FDR-ийн үзүүлэлтийн шаардлага (FDR Parameter Requirements) болон FDR-ийн үзүүлэлтийн тодорхойлолт (FDR Parameter Specifications).

В.7. Нэмэлт байрлал заах хэрэглэл (Additional attitude indicator)

Гуравдагч байрлал заах хэрэглэл нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) бусад байрлал заах системээс тусдаа, бие даан ажилладаг байх;
- (2) цахилгаан үүсгэх системийн бие даасан эх үүсвэрээр тэжээдэг байх;
- (3) цахилгаан үүсгэх системийн бүрэн татгалзлын дараа 30 минут тасралтгүй найдвартай ажиллах чадвартай байх;
- (4) цахилгаан үүсгэх системийн бүрэн татгалзлын дараа тэжээл шилжүүлэхгүйгээр ажилладаг байх;
- (5) үйл ажиллагааны бүх үе шатанд зохих ёсоор гэрэлтдэг байх.

В.8. Цаг агаарын радар (Weather radar)

Цаг агаарын радар нь TSO C63 серийн шаардлагыг хангасан байна.

В.9. Газар ойртсоныг анхааруулах систем (GPWS)

Газар ойртсоныг анхааруулах систем (GPWS) нь TSO C92 серийн шаардлагыг хангасан байна.


В.10. Газар мэдрэх ба анхааруулах систем (TAWS)

(a) А ангиллын TAWS нь TSO C151a, эсхүл TSO C151b-гийн Ангилал-А төхөөрөмжийн шаардлага хангасан байх ёстой.

(b) В ангиллын TAWS нь TSO C151a, эсхүл TSO C151b-гийн Ангилал-В төхөөрөмжийн шаардлага хангасан байх ёстой.

В.11. Агаарт мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх систем (ACAS II)

ACAS II нь TSO C119b шаардлага хангасан байх ёстой.



Тэмдэглэл

1. deHavilland DHC-7, Fairchild FH 227, Fokker F-27 (Mark 50-уас бусад), F-28 Mark 1000 болон Mark 4000, Gulfstream G-159, Lockheed Electra 10-A, 10-B, 10-E, L-188, Maryland. F27, Short SD3-30, SD3-60.
2. Үзүүлэлт 12 - 17 нь нэг эх үүсвэрээс бичигдэж болно.
3. Үзүүлэлт 12 - 14 нь нэг эх үүсвэрээс бичигдэж болно.

Зураг 1. FDR-ийн шийдвэр гаргах бүдүүвч

Тэмдэглэл: ИНД-121-ийн FDR-ийн үзүүлэлтийн шаардлага болон FDR-ийн үзүүлэлтийн тодорхойлолтыг Зөвлөмжийн цуврал AC121-0-ээс (FDR Parameter Requirements and FDR parameter specifications) үзнэ үү.

Хавсралт С - Хөөрч, буух зурвас

Энэ Хавсралт нь 121.71-д хамаарна.

С.1. ХБЗ-ны минимум өргөн

ХБЗ-ны минимум өргөнийг тодорхойлохын тулд Хүснэгт 1-ийг ашиглан, тухайн нисэх онгоцны маягаас шалтгаалан аэродромын хяналтын кодыг (ARC) тодорхойлох шаардлагатай. Тухайн код нь нисэх онгоцны хүчин чадал, үзүүлэлт болон хэмжээтэй холбоотой 2 элементээс бүрдэнэ. Код элемент 1 нь нисэх онгоцны хяналтын талбайн уртаар (ARFL) тодорхойлдог дугаар байх ба код элемент 2 нь нисэх онгоцны далавчны урт болон гадна үндсэн дугуй хоорондын зайгаар тодорхойлдог үсэг байна.

С.1.1. Хүснэгт 1-ийг ашиглан аэродромын хяналтын кодыг (ARC) тодорхойлох

(a) **Нэгд:** Үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны ARFL-ийг тодорхойлох. ARFL нь тухайн нисэх онгоцны нислэгийн заавраас авсан, MCTOW-тэй, далайн түвшинд, ~~стандарт атмосферийн нөхцөлд~~ ISA-д, тогтуун агаарт, тэг налуутай ХБЗ-аас хөөрөлт үйлдэхэд шаардлагатай минимум зурвасны урт.

(b) **Хоёрт:** ARFL ашиглан Элемент 1-ийн кодын дугаарыг тодорхойлох.

(c) **Гуравт:** Нисэх онгоцны далавчны урт болон гадна үндсэн дугуй хоорондын зайн хэмжээтэй хамааралтайгаар элемент 2-ын үсгэн кодыг тодорхойлох. Элемент 2-ын үсгэн код нь далавчны урт, эсхүл гадна үндсэн дугуй хоорондын зайд тохирох үсгэн кодын аль их хэрэгцээтэй үсгэн код байна. Жишээ нь, хэрэв нисэх онгоцны далавчны уртад С үсгэн код тохирох ба нисэх онгоцны гадна үндсэн дугуй хоорондын зайд D үсгэн код тохирч байгаа бол тухайн нисэх онгоцны маягт D үсгэн кодыг сонгодог байх.

Хүснэгт 1. Аэродромын хяналтын код (ARC)

Код элемент 1		Код элемент 2		
Кодын дугаар	ARFL	Үсгэн код	Далавчны урт	Гадна үндсэн дугуй хоорондын зай
1	800 м хүртэл	A	15 м хүртэл	4.5 м хүртэл
2	800-1200 м хүртэл	B	15-24 м хүртэл	4.5-6 м хүртэл
3	1200-1800 м хүртэл	C	24-36 м хүртэл	6-9 м хүртэл
4	1800 м-ээс их	D	36-52 м хүртэл	9-14 м хүртэл
		E	52-65 м хүртэл	9-14 м хүртэл
		F	65-80 м хүртэл	14-16 м хүртэл

С.1.2. Хүснэгт 2-ыг ашиглан ХБЗ-ны минимум өргөнийг тодорхойлох

Тухайн нисэх онгоцны аэродромын хяналтын кодыг (ARC) ашиглан, ХБЗ-ны өргөнийг тодорхойлохдоо тохирох кодын дугаар оруулаад, тохирох үсгэн кодтой хамааралтайгаар тогтоодог байх. Жишээ нь хэрэв тухайн нисэх онгоцны аэродромын хяналтын код (ARC) нь 2С бол шаардлагатай ХБЗ-ны өргөн нь 30 м байна.

Хүснэгт 2. ХБЗ-ны өргөн

Кодын дугаар	Үсгэн код					
	A	B	C	D	E	F
1	18 м	18 м	23 м	-	-	-
2	23 м	23 м	30 м	-	-	-
3	30 м	30 м	30 м	45 м	-	-
4	-	-	45 м	45 м	45 м	60 м

Хавсралт D - ХБЗ-ны буултын зайн үнэлгээ

D.1. Хуурай ХБЗ-ны зөвшөөрөгдсөн буултын зайн үнэлгээ

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь ХБЗ хуурай байх тохиолдолд, 121.221(b)(2)-ын дагуу буултын зайг тооцоолохдоо дараах журмыг ашиглах үүрэгтэй:

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь ашиглаж байгаа нисэх онгоц бүрийн хувьд, буулт үйлдэх тооцоот цагийн буултын жин нь хуурай ХБЗ-ны босгоос дээш 15 м-ийн (50 ft) өндрөөс дараах зайд бүрэн зогсолттой буулт үйлдэх боломж олгодог болохыг бататгах үүрэгтэй:

- (1) турбо-жэт болон турбо-фэн хөдөлгүүртэй нисэх онгоцны хувьд, буултын боломжит зайн (LDA) 60%;
- (2) сэнсэн-хөдөлгүүртэй нисэх онгоцны хувьд, LDA-гийн 70%.

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу буултын жинг тооцоолохдоо, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах хүчин зүйлийг тооцож үзнэ:

- (1) аэродромын өндөрлөг;
- (2) тухайн аэродромын орчны агаарын хэм;
- (3) тухайн ХБЗ-ны гадаргуугийн төрөл болон ХБЗ-ны гадаргуугийн нөхцөл;
- (4) буулт үйлдэх чиглэл дэх ХБЗ-ны налуу;
- (5) мэдээнд өгөгдсөн ~~урдаас-чиглэсэн~~ **үгтах** салхины бүрдэл хэсэг 50%-иас ихгүй, эсхүл ар**ын** ~~аас-чиглэсэн~~ салхины бүрдэл хэсэг 150%-иас багагүй байх.

(c) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (a) болон (b)-д заасны дагуу буулт үйлдэх нисэх онгоцны хувьд, дараах хүчин зүйлийг тооцож үзсэнээр тухайн нисэх онгоц хамгийн тохиромжтой ХБЗ-д буулт үйлдэнэ гэж үзэх үүрэгтэй:

- (1) цаг уурын урьдчилсан мэдээний нөхцөл;
- (2) хүрээлсэн газрын бартаа;
- (3) ойртолт болон буултын туслах хэрэглэл;
- (4) ойртолтоос 2-т гарах нислэгийн замын дагуух саад.

(d) Нисэн очих аэродромын хувьд, хэрэв АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (c)-г хангах боломжгүй бол, энэ зүйлийн (a), (b) болон (c)-гийн шаардлага хангасан бэлтгэл аэродромыг сонгосон тохиолдолд, тухайн гэрчилгээ эзэмшигч нь нисэх онгоцыг нислэгт гаргаж болно.

D.2. Нойтон, эсхүл тунадастай ХБЗ-ны зөвшөөрөгдсөн буултын зайн үнэлгээ

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь ХБЗ нойтон, эсхүл тунадастай нөхцөлд, буултын зайг тооцоолохдоо 121.221(b)(2)-т заасан журмыг ашиглах үүрэгтэй:

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь, үйл ажиллагаандаа ашиглаж байгаа нисэх онгоцны хувьд, дараах шаардлагыг бататгана:

- (1) цаг агаарын урьдчилсан, эсхүл бодит мэдээ, эсхүл хамтатгасан мэдээнд тухайн нисэх онгоцны нисэн хүрэх тооцоот цагт ХБЗ нойтон, эсхүл тунадастай байж болохыг харуулж байгаа тохиолдолд, LDA нь энэ зүйлийн D.1-д шаардсан буултын зайны 115%-иас багагүй байх;
- (2) цаг агаарын урьдчилсан, эсхүл бодит мэдээ, эсхүл хамтатгасан мэдээнд тухайн нисэх онгоцны нисэн хүрэх тооцоот цагт ХБЗ тунадастай байж болохыг харуулж байгаа тохиолдолд, LDA нь дараах шаардлагыг хангасан байх:
 - (i) энэ зүйлийн D.1-д шаардсан буултын зайн 115%-иас багагүй; эсхүл
 - (ii) тунадастай ХБЗ-ны буултын зайн өгөгдлийн дагуу тогтоосон буултын зайнаас багагүй.

(b) Хэрэв техникийн өгөгдөл нь нойтон ХБЗ-д богино буултын зайг ашиглахыг зөвшөөрдөг бол, энэ зүйлийн (a)-д шаардсанаас богино буултын зайг нойтон ХБЗ дээр ашиглаж болно, гэхдээ энэ зүйлийн D.1-д шаардсанаас богино байж болохгүй.

D.3. TALPA журам

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь 121.221(b)(2)-ын дагуу ХБЗ-ны буултын зайг тооцоолоход хэрэглэдэг дараах нөөц журмыг авч явах үүрэгтэй:

- (1) үйлдвэрлэгчийн зөвлөмжийн дагуу нислэгийн үед нисэх багийн гишүүн буултын үзүүлэлтийг тооцоолох боломж олгодог, тухайн нисэх онгоц үйлдвэрлэгчийн хангасан TALPA техникийн өгөгдлийг ашиглах;
- (2) ХБЗ-ны гадаргуугийн нөхцөл болон гадна орчны цаг агаарыг багтаасан, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй тохирох аэродромын бусад өгөгдлийг ашиглах.

--oOo--